



МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ  
ЦАГААН | 2020  
НОМ

УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН

## МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ЦАГААН НОМ 2020

Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын  
Олон нийттэй харилцах хэлтэст эх бэлтгэлийг хийж, хэвлүүлэв.

### **Хянан тохиолдуулсан:**

Хурандаа Ц.Ганзориг (Ph.D)  
Хурандаа Д.Алтангэрэл (Ph.D)

### **Боловсруулсан:**

Дэд хурандаа Д.Сэржмядаг (Ph.D)  
Хошууч П.Чимэдцэрэн (Ph.D)  
Хошууч А.Ариунбилэг  
Ахлах дэслэгч Б.Хулан

### **Хэвлэлийн эх бэлтгэсэн:**

Ахмад Ч.Наранцацрал  
Ахлах дэслэгч Б.Отгон

Улаанбаатар хот. 2021 он  
Онцгой байдлын ерөнхий газар

## ГАРЧИГ

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГА

<b>Бүлэг 1.1. Гамшгаас хамгаалах эрх зүйн шинэчлэл</b> .....	7
1.1.1. Улсын их хурлаар батлуулсан баримт бичиг .....	8
1.1.2. Монгол Улсын засгийн газрын тогтоолоор батлагдсан баримт бичиг .....	10
1.1.3. Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан баримт бичиг .....	13
1.1.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан баримт бичиг .....	15
<b>Бүлэг 1.2 Гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт</b> ...	21
<b>Бүлэг 1.3 Гамшгаас хамгаалах хамтын ажиллагаа</b> .....	26
1.3.1. Гадаад хамтын ажиллагаа, айлчлал .....	26
1.3.2. Дотоод хамтын ажиллагаа .....	29
1.3.3. Онцгой байдлын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр .....	31
<b>Бүлэг 1.4 Онцгой байдлын байгууллагын чадавх</b> .....	31
1.4.1. Онцгой байдлын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын бэхжилт .....	31
1.4.2. Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавх .....	31
1.4.3. Техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт .....	37
<b>Бүлэг 1.5. Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ, инновац</b> .....	40
1.5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагаа .....	40
1.5.2. Гамшиг судлалын хүрээлэнгээс гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний ажил .....	41
1.5.3. Онцгой байдлын байгууллагын инновацийн үйл ажиллагаа .....	47

## ХОЁРДУГААР ХЭСЭГ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

<b>Бүлэг 2.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа</b> .....	57
2.1.1. Монгол Улсын Шадар сайдын баталсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ	58
2.1.2. 2020 онд төв, орон нутгаас гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил .....	58
2.1.3. Дадлага сургалт .....	60
2.1.4. Цахим сургалт .....	63
2.1.5. Онцгой байдлын албаны үйл ажиллагаа, алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлах .....	65
2.1.6. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагаа .....	71
<b>Бүлэг 2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа</b> .....	74
2.2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал .....	76
2.2.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа .....	79
2.2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа .....	80

## ГУРАВДУГААР ХЭСЭГ: ГАМШГИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

<b>Бүлэг 3.1. Гамшгийн нөхцөл байдал</b> .....	81
3.1.1. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тойм .....	82
3.1.2. Монгол оронд тохиолдсон зарим томоохон аюулт үзэгдэл, ослын тойм .....	87
<b>Бүлэг 3.2. Гал түймрийн нөхцөл байдал</b> .....	92
3.2.1. Объектын гал түймэр .....	92
3.2.2. Ой, хээрийн гал түймэр .....	94
3.2.3. Урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын талаар .....	94

## ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХОР УРШГИЙГ АРИЛГАХ, СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА

<b>Бүлэг 4.1. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж</b> .....	97
4.1.1. Улсын нөөцийн бараа, материал .....	98
<b>Бүлэг 4.2. Улсын Онцгой комиссын үйл ажиллагаа</b> .....	102



**ТАВДУГААР ХЭСЭГ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР  
(КОВИД-19)-ЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ,  
ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ**

<b>Бүлэг 5.1</b>	<b>Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээ</b>	<b>107</b>
5.1.1.	Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал	108
5.1.2.	Улсын хэмжээнд коронавируст халдварын үед авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ	113
<b>Бүлэг 5.2.</b>	<b>Коронавируст халдвар (Ковид-19)-ын үе дэх олон улсын хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж</b>	<b>132</b>
5.2.1.	Коронавируст халдвар (ковид-19)-ын үе дэх олон улсын хамтын ажиллагаа	132
5.2.2.	Коронавируст халдвар (ковид-19)-ын үе дэх хүмүүнлэгийн тусламж	133

<b>ХАВСРАЛТ</b>	<b>137</b>
-----------------	------------







**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.**

**ГАМШГААС ХАМГААЛАХ  
УДИРДАГА**





## **БҮЛЭГ 1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ**

### **1.1.1. Улсын их хурлаар батлуулсан баримт бичиг**

#### **1. ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

Дэлхий даяар коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал тархсанаас үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар зарлигийн 1.4-т “Дэлхий дахинд хүнээс хүнд, мал амьтнаас хүнд халдварлах халдварт өвчин ихээр тархах болсонтой холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай болон бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулган, шаардлагатай бол ээлжит бус чуулганаар яаралтай горимоор хэлэлцүүлэх.” гэж чиглэл өгсний дагуу Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгаж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Онц байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн агуулга

Гамшгаас хамгаалах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 35 хувьд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд дор дурдсан 7 зүйлээс бүрдэж байна. Үүнд:

- 1 дүгээр зүйлд 2 зүйл, 24 хэсэг, 38 заалтыг нэмсэн;
- 2 дугаар зүйлд 8 хэсэг, 3 заалтад нэмэлт оруулсан;
- 3 дугаар зүйлд 23 хэсэг, 22 заалтыг өөрчлөн найруулсан;
- 4 дүгээр зүйлд 2 хэсэг, 2 заалтыг өөрчилсөн;
- 5 дугаар зүйлд 2 хэсэг, 1 заалт хассан;
- 6 дугаар зүйлд 4 хэсэг, 1 заалтыг хүчингүй болгосон;
- 7 дугаар зүйл. Хуулийг дагаж мөрдөх хугацаа;

Хуулийн төсөлд гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хуулийн хэрэгжилт, олон нийтийн ойлголтыг харгалзан зарим нэр томъёог өөрчлөн найруулж, “гамшгийн онцгой нөхцөл байдал”, “гамшгаас урьдчилан сэргийлэх”, “хүмүүнлэгийн тусламж”, “хорио цээрийн дэглэм”, “хязгаарлалтын дэглэм”, “бэлэн байдал” зэрэг нэр томъёоны тодорхойлолтыг шинээр нэмж оруулсан;

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээг нэмж тусган бэлэн байдлын зэрэгт бүрэн болон хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх ойлголтыг шинээр томъёолсон;

3. Гамшгаас хамгаалах асуудлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар шинэ зүйл нэмж оруулсан;

4. Улсын Их Хурал, Засгийн газрын гамшгаас хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх

бүрэн эрхэд нэмэлт оруулсан;

5. Гамшиг, гамшигын онцгой нөхцөл байдал үүссэн үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссын бүрэн эрхэд хамаарах асуудлаар шинэ зүйл нэмж оруулсан;

6. Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, Засаг дарга нарын бүрэн эрх, улсын албад, хуулийн этгээд, албан тушаалтан, иргэний үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх хэсэг, заалтыг нэмж тусгасан;

7. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг хангахтай холбоотой хэсэг, заалтыг шинээр нэмж тусгасан;

8. Энэ хуулиар бусад хуульд давхардсан хэсэг, заалтыг хүчингүй болгож, зарим хэсэг, заалтыг өөрчлөн найруулсан.

Ийнхүү уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн нийгмийн хэвийн үйл ажиллагаа, хүн амын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөл хангагдсан эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

## **2. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗААГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

“Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн заагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн төслийг УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын Онцгой комисс, Төрийн байгууллага, Төв банк болон арилжааны банкнаас цар тахлын үеийн хүн, амын эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдэлийг бууруулах, нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, иргэн, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээллийн байгууллагын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон.

Мөн цар тахлын өнөөгийн болон цаашид үүсэх эрсдэлийг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, холбогдох хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар баталсан.

Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн агуулга: Улсын онцгой комисс болон аймаг, нийслэлийн Засаг даргаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Төрийн үйлчилгээнд мэдээллийн технологи ашиглах, цахим үйлчилгээ, цахим сургалт, цахим худалдаатай холбоотой асуудал, шатахуун, эрчим хүч, харилцаа холбоо, хүнс хангамж, шуудан,

бараа бүтээгдэхүүний хүргэлтийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, шаардлагатай дүрэм, журам, заавар боловсруулж батлах асуудал, мэргэжлийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг нэмэгдүүлэхээр тус тус тусгасан.

### **1.1.2. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан баримт бичиг**

#### **3. АЛСЛАГДСАН АЙМАГ, СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРЪЯА НЭГЖИД ТОМИЛОГДОН АЖИЛЛАЖ БАЙГАА АЛБА ХААГЧИД НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 50.10-т “Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах Онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харъяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх нэмэгдлийг улирал тутамд олгоно” гэж заасан бөгөөд тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дээрх нэмэгдлийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 165 дугаар тогтоолоор “Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид томилогдон ажиллаж байгаа алба хаагчид нэмэгдэл олгох журам”-ыг баталсан.

#### **4. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДСАН ТОХИОЛДОЛД НЭГ УДААГИЙН НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ЖУРАМ**

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 50.11-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно” гэж заасан бөгөөд тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дээрх нөхөн олговрыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан байна.

Сүүлийн 15 жилийн хугацаанд Онцгой байдлын байгууллагаас 47 алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсан бөгөөд үүнээс 15 буюу 32 хувь нь ой, хээрийн түймэр унтраах ажиллагаа, 68 хувь нь бусад үйл ажиллагаанд оролцож байсан байна. Мөн 162 алба хаагч эрүүл мэндээрээ хохирч, хөдөлмөрийн чадвараа алдсан.

Иймд алба хаагчдын эрх зүйн байдал, нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн нэг адил албан үүргээ гүйцэтгэж байгаад хөдөлмөрийн чадвараа алдсан алба хаагчдад нөхөн олговор олгох журмын төслийг боловсруулж батлуулсан юм.

#### **5. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн

50.9-т “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиас доошгүй байна.” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 380 дугаар тогтоолоор батлагдсан “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-д өөрчлөлт оруулан “... 20 хувиар” гэснийг “30 хувиар ...” гэж өөрчлөн Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 166 дугаар тогтоолоор батлуулж, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дээрх нэмэгдлийг 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө гэж заасан байна.

## **6. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэгтэй, орон тооны бус бүтэц юм.

“Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор нийт 7 бүлэг 28 зүйлтэй батлуулсан. Тус журамд дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 7 дугаар тогтоолоор Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон;

2. Үндэсний зөвлөл, зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарын эрх, үүргийн заалтыг нэмж тусгасан;

3. Орон нутгийн зөвлөлийн эрх үүргийн заалтыг шинээр нэмсэн;

4. Үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэр, үүрэг чиглэлийг биелүүлээгүй, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлээгүй, албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох тухай заалт шинээр нэмсэн.

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн төр, иргэний нийгэм, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ, хэвлэл мэдээллийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрддэг. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнд шинээр Жендэрийн үндэсний хороо нэмэгдсэн нь жендэрт суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд анхаарах чиг хандлага бодитоор хэрэгжих боломжтой болж байна.

Мөн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн хувьд тус зөвлөлийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүлэх болсон нь гамшгаас хамгаалах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шууд шийдвэрлэх

боломж бүрдэж байна.

Энэхүү журамд өөрчлөлт орсноор Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа, дарга, гишүүдийн бүрэн эрх тодорхой болж, гамшгийн эрсдэлийн удирдлага, зохион байгуулалт сайжирч байна.

## **7. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ**

“Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 190 дүгээр тогтоолоор нийт 8 бүлэг, 24 зүйлтэй болгон батлуулсан. Тус журмыг шинэчлэн боловсруулахад дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний ангиллыг шинээр нэмсэн;
2. Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх зорилго, үнэлгээний захиалагч болон гүйцэтгэх талын бүрэн эрхийг тодорхойлсон;
3. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний чиглэлд өөрчлөлт орсон;
4. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлан, дүгнэх шалгуур үзүүлэлттэй холбогдох заалт нэмсэн.

Шинэчлэгдсэн журамд гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний зорилгыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг: Гамшгийн эрсдэлийг тойм, суурь судалгаа байдлаар тодорхойлох зорилгоор хийх.

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг: Гамшгийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр мэргэжлийн түвшинд нарийвчлан тодорхойлох, болзошгүй хохирлын хэмжээг тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг төлөвлөх зорилгоор хийх.

Энэхүү журам шинэчлэгдэн батлагдсанаар гамшгийн эрсдэлийн үнэлгээний зохицуулалт, эрсдэлийн үнэлгээ хийлгэх захиалагч болон гүйцэтгэгч талын үүрэг тодорхой болж, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн эрсдэлийг бууруулах бодлого, төлөвлөлт хийх боломж, нөхцөл нэмэгдэж байна.

## **8. ГАМШГААС ХАМГААЛАХ ДОТООДЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 29.1.9-д “Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих”, мөн хуулийн 38.1-д “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна” гэж тус тус заасны дагуу “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 271 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах түр журам”-ыг тус тус үндэслэн “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын төслийг 6 хэсэг, 27 заалттайгаар боловсруулж, Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 07-



ны өдрийн 133 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан.

Энэхүү журам нь гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулж төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн үзүүлж буй эд материалын болон мөнгөн хөрөнгө хэлбэрээр олгосон хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах, тээвэрлэн хүргэх, зарцуулах, тайлагнах харилцааг зохицуулах зорилготой юм.

### **1.1.3. Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан баримт бичиг**

#### **9. БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын тархалтыг хязгаарлах, бууруулах, таслан зогсоох, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах зорилгоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж”-ийн төслийг боловсруулж, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 20 дугаар тушаалаар батлуулсан.

Уг удирдамжид Коронавируст халдварын цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах зорилгоор байгууллагуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгаж өгсөн байна.

#### **10. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨ**

Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай, Онц байдлын тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиуд болон бусад хууль тогтоомжийн хүрээнд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг үндэсний хэмжээнд өндөр зохион байгуулалттайгаар шуурхай авч хэрэгжүүлэн, эрсдэлийг бууруулах, бага хохиролтой даван туулах зорилгоор “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний стратеги, төлөвлөгөө”-г боловсруулж, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 26 дугаар тушаалаар батлуулсан.

Тус стратеги, төлөвлөгөөнд коронавируст халдварын цартахалтай тэмцэх үе шатуудад /цартахалын өмнөх үе, үед, дараах үе/ төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, олон улсын байгууллага, иргэдийн үүрэг оролцоо, авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг нарийвчлан тусгаж өгсөн байна.

## 11. ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2021-2024

Төрийн албаны тухай хуулийн 53.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харъяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасны дагуу “Онцгой байдлын ерөнхий газрын стратеги төлөвлөгөө 2021-2024”-г боловсруулан Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 161 дүгээр тушаалаар батлуулсан.

Стратеги төлөвлөгөөг “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, түүнтэй нийцүүлэн УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдтэй, Гамшгаас хамгаалах хуультай уялдуулан, “Гамшгийн эрсдлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”-г дэвшүүлсэн зорилго, зорилтод нийцүүлэн боловсруулсан байна.

Стратеги төлөвлөгөөнд Засгийн газрын өмнөх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт гамшгаас хамгаалах чиглэлээр дэвшүүлсэн зорилтын биелэлт, Гамшгаас хамгаалах үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын үр дүн, Онцгой байдлын байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн гол арга хэмжээний үр нөлөө, өмнөх 5 жилд хэрэгжсэн Онцгой байдлын ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Онцгой байдлын ерөнхий газраас 2016-2020 онд дэвшүүлсэн жил бүрийн зорилтын үр дүнг тусгасан.

Мөн төлөвлөгөөнд “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр-т гамшгаас хамгаалах чиглэлээр тусгагдсан 5 зорилт, 9 арга хэмжээ, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн 3 зорилт 11 арга хэмжээ, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх буюу Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгасан 9 зорилт, 40 арга хэмжээг ирэх 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэхээр боловсруулсан ба дээрх зорилт, арга хэмжээг нийлүүлэхдээ хүн хүч, хөрөнгө санхүүгийн нөөцийг хамгийн оновчтой байдлаар хуваарилан зарцуулж, дэвшүүлсэн зорилтуудын эцсийн үр дүнг хангахаар тооцсон.

## 12. ИЛ, ДАЛД УУРХАЙД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар батлагдсан “Ил, далд уурхай, баяжуулах үйлдвэрийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар”-ыг тодотгох, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой болгох үүднээс “Ил, далд уурхайд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын төслийг боловсруулж, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 160 дугаар тушаалаар батлууллаа.

Аргачлалын төслийг Гамшгаас хамгаалах тухай хууль, “Гамшгийн эрсдэлийн

## 1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага

үнэлгээ хийх журам”, “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”, “Ил, далд уурхай, баяжуулах үйлдвэрийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний нийтлэг заавар”, Оросын Холбооны Улсын “Үйлдвэрлэлийн аюултай байгууламж, үйлдвэрийн аюулгүй байдлын тухай хууль”, Эрсдэлийн менежмент MNS ISO 31000:2011, Эрсдэлийн үнэлгээний арга MNS ISO 31010:2016, Австралийн Өмнөд Уэльс мужийн “Ашигт малтмалын салбарын аюулгүй байдал, эрүүл мэнд, эрсдэлийн удирдлагын удирдамж”, Австралийн эрдэс баялгийн зөвлөлөөс гаргасан “Эрсдэлийн үнэлгээ ба менежмент” зэрэг дотоод, гадаадын эрсдэлийн үнэлгээний талаарх эрх зүйн баримт бичиг, туршлагыг судлан боловсруулжээ.

Аргачлалын төсөл нь мэдээлэл цуглуулах, тохиолдож болзошгүй аюул осол, түүний үр дагаврыг тодорхойлж, хор хохирлоор нь эрэмбэлэх, аюулд нөлөөлөх эмзэг байдал, чадавхыг тодорхойлох, аюул тус бүрийн тохиолдож болзошгүй магадлалыг тодорхойлох, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай зөвлөмж боловсруулах гэсэн 6 хэсэгтэй ба хавсралтаар ил, далд уурхай, баяжуулах үйлдвэрт тохиолдож болзошгүй аюул осол, түүнд нөлөөлөх үндсэн хүчин зүйлийг тодорхойлж, лавлах материал зэргийг хавсаргасан байна.

Энэхүү аргачлалыг эрсдэлийн үнэлгээ хийх ажилтан, алба хаагчдад ойлгомжтой, ашиглахад хялбар байдлаар боловсруулж “Аюулгүй ажиллагаа нэгдүгээрт” гэсэн олон улсын зарчмыг удирдлага болгосон ба дараах зарчмын шинж чанартай зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1. Ил, далд уурхайд тохиолдож болзошгүй аюул, ослын үр дагаврын ангилал, түүнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт;
2. Ил, далд уурхайд тохиолдож болзошгүй аюул ослын магадлал, түүний ангилал;
3. Эрсдэлийн матриц, эрсдэлийн түвшин.

Энэхүү аргачлал батлагдсанаар Монгол Улсын уул уурхайн салбарт хийгдэх гамшгийн эрсдэлийн үнэлгээний чанар сайжирч, улмаар тухайн салбарт тохиолдож болзошгүй гамшиг, аюул ослын тоо буурна гэж үзэж байна.

### 1.1.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан баримт бичиг

## 13. “ГАЛ СӨНӨӨГЧИЙН ХУВЦАС MNS 6448:2012” СТАНДАРТ

“Гал сөнөөгчийн хувцас MNS 6348:2012 стандарт”-ыг Онцгой байдлын байгууллагын алба хаагчид, Стандарт хэмжилзүйн газар, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг шинэчлэн боловсруулж Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/83 дугаар тушаалаар батлуулсан.

Объектын болон ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, бусад хүчин зүйлсийг хангасан хувцас,

хэрэгслээр хангах, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх, цаашид “Хувцас хэрэгслийн туршилт, үйлдвэрлэлийн төв”-д объект, ой хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалт, төрөл тус бүрээр дотооддоо үйлдвэрлэх, турших боломжийг бүрдүүлэх зорилгоор тус 3 багц стандартыг шинэчлэн боловсруулсан байна.



“Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага”  
CS 11-0439:2020



“Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага”  
CS 11-0440:2020



“Гал түймэрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага”  
CS 11-0441:2020

Зураг 1. “Гал сөнөөгчийн хувцас MNS 6448:2012” стандарт

#### 14. ОБЪЕКТЫН БОЛОН ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АЖИЛЛАГААНД ЗОРИУЛСАН ХАМГААЛАХ ТУСГАЙ ХУВЦАС, ХҮН НЭГ БҮРИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/96 дугаар тушаалаар “Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх журам”-ыг батлав.

Энэхүү журмын зорилго нь объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах, дадлага сургуульд оролцох үед алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах болон хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалах тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлийн ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Тус журмыг Онцгой байдлын байгууллагын алба хаагч, сонсогч, гал түймэртэй тэмцэх анги, хэсэг, сайн дурын хэсгийн ажилтан, дайчлагдсан иргэд дагаж мөрдөнө.

#### 15. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дүрэм, журам, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд Онцгой байдлын байгууллагын

## **1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага**

хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн зохистой орчныг бүрдүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам”-ыг батлан гаргасан. Тус журамд төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь 5-9 хүний бүрэлдэхүүнтэй, онцгой байдлын байгууллагын харьяа нэгжийн салбар зөвлөл нь 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байж болохоор тусгажээ.

### **16. СЭТГЭЛ ЗҮЙ, СЭТГЭЛ ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Онцгой байдлын байгууллагын алба хаагчид гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах, гамшгийн үед иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, өөрийн сэтгэл зүйн байдлыг удирдах, гамшгийн дараа сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн хямралыг зохицуулах, сэтгэцийн тулгамдсан асуудал болон эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлж сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн А/176 дугаар тушаалаар “Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-ыг батлуулсан.

Журам нь 6 бүлэг, 58 заалттай, онцгой байдлын байгууллагын алба хаагчид гамшиг осол, эрэн хайх үйл ажиллагаанд оролцоход сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах, гамшгийн үед ард иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, өөрийн сэтгэл зүйн байдлыг удирдах, гамшгийн дараа сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн хямралыг зохицуулах, сэтгэцийн тулгамдсан асуудал болон эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлж, сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад эрх зүйн үндэс болох ач холбогдолтой юм.

Энэхүү журам батлагдсанаар сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх заавар, сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулах, тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтний орон тоо, бүтцийг батлах, шаардлагатай өрөө тасалгаа, техник хэрэгсэл, сэтгэл зүйн оношлогооны сорил, тоног төхөөрөмж зэргийг шийдвэрлэх боломж бүрдсэн.

### **17. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАХИМ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГ АШИГЛАХ ЖУРАМ**

Монгол Улсын сайдын тушаалаар 2006 онд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын харьяаны Шуурхай бүлэг-105-ын бүтцэд 4 эмч, 2011 оноос Төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгуулагад эмч-сэтгэл зүйч, эмнэлгийн зааварлагчийн орон тоотой болж 2020 оны 3 дугаар сарын байдлаар нийтдээ 50 эмч-сэтгэл зүйч,

эмнэлгийн зааварлагч Онцгой байдлын албаны ажилтан, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн албан хаагчид болон нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхан шатны болон сэтгэл зүйн тусламж үзүүлэн холбогдох эрүүл мэндийн байгууллагад хүргэж хамтран ажиллаж байна. Онцгой байдлын байгууллагад дээрх үйл ажиллагааны нэгдсэн бүртгэл, мэдээлэл байдаггүй тул Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын “Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сан”-г ашиглах журмыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн А/175 дугаар тушаалаар батлуулсан.

Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагад эрүүл мэндийн цахим бүртгэлийн (Medsoft 1.0 beta) программ хангамжийг өргөн ашиглаж байна.

Мэдээллийн сан нь бодит үзлэг, оношилгоо, шинжилгээ, биеийн зохистой харьцаа, сэтгэл зүй, дархлаажуулалт гэсэн 5 хэсгээс бүрдэнэ.

“Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сан”-г шинээр нэвтрүүлснээр алба хаагч, ажилтнуудын эрүүл мэндийн тандалт, судалгаа болон өвчлөлийн судалгааны цахим мэдээллийн сан үүсгэх, нууцлалыг сайжруулах, нэгдсэн бүртгэл, заавартай болох ач холбогдолтой. Энэхүү систем нь “Цахим бүртгэл мэдээллийн систем”-ийн нэг дэд систем бөгөөд байгууллагын хүний нөөц буюу алба хаагч, ажилтны мэдээллийн сантай уялдаа холбоотой ажиллах боломжийг бүрдүүлж буй ач холбогдолтой.

## **18. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН РАДИО ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Төрийн болон албаны нууцын тухай хууль, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Засгийн газрын 2018 оны 30 дугаар тогтоолоор “Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээ байгуулах, ашиглах журам” батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын байгууллагын радио холбоог төлөвлөх, зохион байгуулах, ашиглахад нэгдсэн арга зүйгээр хангах хэрэгцээ шаардлага үүссэн юм. Иймд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/861 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын радио холбоо зохион байгуулах, ашиглах журам”-ыг шинэчлэн боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/232 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам” болгон батлуулсан.

Энэхүү журмыг 5 бүлэг, 14 заалттайгаар, холбогдох эрх зүйн баримт бичигт нийцүүлэн шинэчлэн боловсруулсан бөгөөд дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнд:

1. Журмын заалт, дэд хэсгүүдийг шинэчлэн найруулж, бүлгүүдийн нэр утгад өөрчлөлт оруулсан;

2. Радио холбоог төлөвлөж зохион байгуулахад Холбоо, техник, цахим мэдээллийн аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгж, чиглэлийн алба хаагчийн үүргийг тодорхой болгон нэмж оруулсан;

3. Радио холбооны техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааг хангах талаар;

4. Хөтлөх баримт бичгийн загвар болон зохион байгуулалтын бүдүүвчийг 1-8 дугаар хавсралтуудад;

5. Газар орны онцлогт тохируулан радио холбоог зохион байгуулахад анхаарах асуудлын талаар тус тус тусгасан.

6. Харилцаа, холбоо, мэдээлэл технологийн газар, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтнээс журмын төсөлд оруулах саналыг авч тусгасан болно.

Журам батлагдсанаар байнгын болон гамшгийн үеийн радио холбоог төлөвлөх, зохион байгуулах, ашиглах эрх зүйн орчин бүрдсэн юм.

## **19. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ**

Харилцаа, холбооны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолоор Онцгой байдлын байгууллагын хэмжээнд интернэтийн нэгдсэн сүлжээ байгуулсантай холбогдуулан төрийн байгууллагын интернет сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоом болон видео сан бүхий сайтуудад хандахыг хязгаарлах хэрэгцээ шаардлага үүссэн.

Онцгой байдлын байгууллагын цахим мэдээллийн сан, мэдээлэл, түүнийг дэмжих дэд бүтцийн цахим аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/182 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг шинэчлэн боловсруулж Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/233 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам” болгон батлуулсан.

Энэхүү журмыг 6 бүлэг, 32 заалттайгаар, холбогдох эрх зүйн баримт бичигт нийцүүлэн шинэчлэн боловсруулсан бөгөөд дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнд:

1. Журмын заалт, дэд хэсгүүдийг шинэчлэн найруулж, бүлгүүдийн нэр утганд өөрчлөлт оруулсан;

2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад байгууллагын удирдлага, алба хаагч, Холбоо, зарлан мэдээллийн асуудал хариуцсан бүтцийн нэгжийн үүргийг тодорхой болгон нэмж оруулсан;

3. Техник болон программ хангамж ашиглан мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар;

4. Серверийн өрөөний орчин, аюулгүй байдлын талаар;

5. Программ хангамж, тоног төхөөрөмж худалдан авахад анхаарах асуудлын талаар;

6. Эрсдэлийн үнэлгээ хийх талаар тус тус тусгасан.

Журам батлагдсанаар Онцгой байдлын байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, хяналтын тогтолцоо, интернетийн зохистой хэрэглээг бий болгох, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах, мэдээллийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюул заналаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, нэн даруй хариу арга хэмжээ авах эрх зүйн орчин



бүрдсэн юм.

## **20. ХЭЭРИЙН ЭМНЭЛЭГ ДЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ЗААВАР**

Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, томоохон осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тухайн газар орон, талбарт шилжин байршиж, хээрийн эмнэлгийг дэлгэн нэрвэгдэгсдэд төрөлжсөн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх нэгдсэн заавар, журам бий болгох шаардлагын дагуу “Хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах заавар”-ыг шинээр боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/303 дугаар тушаалаар батлуулсан.

Хээрийн эмнэлэг дэлгэн ажиллуулах зааврыг боловсруулахдаа Оросын Холбооны Улсын Онц байдлын яамны хээрийн эмнэлэг дэлгэх заавар, Бүгд Найрамдах Польш Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд нийлүүлэгдсэн евро стандартын хээрийн хөдөлгөөнт II шатлалын эмнэлгийг дэлгэсэн байдлыг судлан үзсэн.

Энэхүү заавар нь Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, томоохон осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тухайн газар орон, талбарт шилжин байршиж, хээрийн эмнэлгийг дэлгэн нэрвэгдэгсэд болон үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн төрөлжсөн тусламж үйлчилгээг шуурхай, тасралтгүй, чанартай, хүртээмжтэй зохион байгуулахад зорилготой.

Заавар батлагдсанаар гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, томоохон осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нэрвэгдэгсдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тухайн газар орон, талбарт үзүүлж лавлагаа шатлалын эмнэлэгт тээвэрлэх нөхцөл бололцоо бүрдэж байгаа юм.

## **21. ТҮР ЦУГЛАРАХ ТАЛБАЙ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БАЙРШИЛ, ТҮР БАЙРНЫ ЗААВАР**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ”, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.8-д “гамшиг болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах” гэж тус тус заасан.

Хуулийн эдгээр заалтуудад үндэслэн “Түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байрны заавар”-ыг шинээр боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/305 дугаар тушаалаар батлуулсан. Энэхүү заавар 7 бүлэг, 42 заалттай бөгөөд түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байр, түүнд тавигдах шаардлагыг тодорхой тусгасан байна.

Заавар батлагдсанаар түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршил, түр байр байгуулан ашиглах эрх зүйн орчин бүрдсэн юм.

Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх түр байрыг хэрхэн байгуулж тоноглох талаар өмнө хийгдсэн судалгаа, олон улсын жишиг баримт бичгүүд болох Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний минимиум стандарт (Сфер төсөл, 2011), Нэгдсэн Үндэстний



Байгууллагын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссарын албанаас боловсруулсан онцгой байдал үүссэн үед авах арга хэмжээний гарын авлага зэргийг үндэслэн уг зааврыг боловсруулсан.

## **22. ГАМШИГ, ОСЛЫН ҮЕД НЭРВЭГДЭГСДИЙГ ОСЛЫН ГОЛОМТООС ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ЭМНЭЛЭГТ ШУУРХАЙ ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Монгол Улсын хүн ам нь тархан суурьшсан, аймгийн төвөөс алслагдмал, сум, тосгонд байрлах эрүүл мэндийн анхан шатны нэгжүүдэд түлэгдэлт, гэмтэл, мэс заслын тусламж үзүүлэх боломжгүй, сэхээн амьдруулах, тогтворжуулах эмчилгээ хийх тоног төхөөрөмж хангалтгүй, эмч, эмнэлгийн мэргэжилтний хүрэлцээ дутмаг байдаг зэргээс шалтгаалан эмнэлгийн яаралтай тусламжийн үйл ажиллагаанд их хэмжээний цаг хугацаа зарцуулж байгаа нь гамшиг ослын үед нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилах, эмнэлгийн тусламж үйлчилгээг газар дээр нь үзүүлэх, шаардлагатай тохиолдолд хамгийн ойр байрлах эрүүл мэндийн байгууллагад агаараар болон газраар тээвэрлэн шилжүүлэх ажлыг бусад мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах шаардлагатай тулгардаг.

Иймээс “Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдийг ослын голомтоос лавлагаа шатлалын эмнэлэгт шуурхай шилжүүлэх төлөвлөгөө”-г шинээр боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/302 дугаар тушаалаар батлуулсан.

Төлөвлөгөөний зорилго нь гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай, чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөөг Монгол Улсын нийт нутаг дэвсгэр, нутаг дэвсгэрийн зарим хэсэгт аюулт үзэгдэл, ослын улмаас хүний эрүүл мэнд, амь нас хохирох эрсдэл үүссэн, амь нас хохирсон үед хэрэгжүүлнэ.


Төлөвлөгөө батлагдсанаар гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд эрүүл мэндийн тусламж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт шуурхай шилжүүлэх үйл ажиллагааг бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүс, орон нутгийн хэмжээнд удирдлага зохицуулалтаар шуурхай хангах ажлыг зохион байгуулж, бэлэн байдал хангагдана.

### **БҮЛЭГ 1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх нийтлэг журам”-ыг баримтлан Онцгой байдлын ерөнхий газарт 2020 онд хэрэгжсэн дараах бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд Дотоод хяналт шалгалт аюулгүй байдлын газраас хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд:

1. Улсын их хурлын 2011 оны 22 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар

батлагдсан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөр”, МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 23 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан нь үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрч сайн, үр дүн гарсан буюу 97.3 хувьтай дүгнэгдсэн.



Зураг 2. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний цагалбар

“Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөр”-ийг 2012-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2012 оны биелэлтийг 73.8 хувиар, 2013 оны биелэлтийг 49.1 хувиар, 2014 оны биелэлтийг 53.7 хувиар, 2015 оны биелэлтийг 71.4 хувиар, 2016 оны биелэлтийг 69.1 хувиар, 2017 оны биелэлтийг 87.3 хувиар, 2018 оны биелэлтийг 84.0 хувиар, 2019 оны биелэлтийг 94.8 хувиар 2020 оны биелэлийг 97.3 хувиар тус тус үнэлсэн.

**1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага**

2. Улсын их хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрч сайн, үр дүн гарсан буюу 100 хувьтай дүгнэгдсэн.


*Гамшгаас хамгаалах мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гамшгийн үеийн бэлэн байдлын түвшинг дээшлүүлэх 10 дугаар зорилтын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар дараах 2 арга хэмжээг хариуцан ажилласан.*



Зураг 3. “Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2020 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэл”-д хэрэгжүүлэхээр туссан 2 арга хэмжээний хэрэгжилт

3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан нь “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрч сайн, үр дүн гарсан буюу 100 хувьтай дүгнэгдсэн.

4. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 41 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан нь үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрч сайн, үр дүн гарсан буюу 91.2 хувьтай дүгнэгдсэн.



Зураг 4. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

5. Монгол Улсын 2 хуулийн 19, Улсын Их Хурлын 1 тогтоолын 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 18, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 тогтоолын 3, Монгол Улсын Засгийн газрын 36 тогтоолын 53, Монгол Улсын Ерөнхий сайдын 1 захирамжийн 1, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 14 тэмдэглэлийн 28, Монгол Улсын Засгийн газрын 1 албан даалгаврын 3, нийт 63 шийдвэрийн 126 заалтыг хяналтад авч ажилласан бөгөөд дээрх шийдвэрүүдээс бүрэн биелсэн 123, “хэрэгжих шатанд” буюу 30 хувьтай биелсэн 1, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 1 шийдвэр буюу 99.4 хувьтай дүгнэгдсэн.

6. Онцгой байдлын ерөнхий газарт гадаадын зээл тусламжаар 2019-2023 онд хэрэгжиж буй 5 төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ-үнэлгээ хийхэд;

- Бүгд найрамдах Беларус улсын Засгийн газрын хөнгөлттэй зээлээр 2019-2020 онд хэрэгжих “Онцгой байдлын албаны гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх” төсөл 100 хувь
- Бүгд найрамдах Франц улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр 2020-2023 онд хэрэгжих “Онцгой байдлын албанд агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх” төсөл 100 хувь
- Бүгд найрамдах Франц улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр 2020-2021 онд хэрэгжих “Онцгой байдлын албанд гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх” төсөл 100 хувь

**ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ГАЛ  
ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ТЕХНИК,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ  
ШИНЭЧЛЭХ ТӨСӨЛ**

**2019-2020 он**

• Гал түймэртэй тэмцэх автомашин, техникийг хүлээн авах. 100%

• Гал түймэртэй тэмцэх автомашин, техникийг төв, орон нутгийн ОББ-д хүлээлгэн өгөх. 100%

**Төслийн нийт хэрэгжилтэд өгсөн үнэлгээ-100%**

**ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНД  
АГААРААС ЭРЭН ХАЙХ, АВРАХ  
НЭГЖ БАЙГУУЛАХ, НИСДЭГ  
ТЭРЭГ НИЙЛҮҮЛЭХ ТӨСӨЛ**

**2020-2023 он**

• ОБЕГ-ын Агаараас эрэн хайх, аврах ажиллагааны нэгж байгуулах. 100%

• Агаараас эрэн хайх, аврах ажиллагааны нэгжид шаардагдах нисдэг тэрэг, симуляторыг нийлүүлэх, ангар, сургалтын байгууламж байгуулах. 100%

**Төслийн нийт хэрэгжилтэд өгсөн үнэлгээ-100%**

**ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНД  
ГАЛ УНТРААХ ТУСГАЙ  
ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИН  
НИЙЛҮҮЛЭХ ТӨСӨЛ**

**2019-2021 он**

• Төслийн гэрээ болон бусад баримт бичгүүдийг боловсруулах, батлуулах. 100%

• Төслөөр худалдан авах гал унтраах тусгай зориулалтын автомашинуудын техникийн тодорхойлолтыг боловсруулах, гүйцэтгэгчийг шаардлагатай мэдээллээр хангах. 100%

**Төслийн нийт хэрэгжилтэд өгсөн үнэлгээ-100%**

Зураг 5. ОБЕГ-т гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй техник хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх төслүүдийн хэрэгжилт (2019-2023 он)

### 1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага

- “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон эрсдэл шилжүүлэх механизмийг боловсронгуй болгох” төсөл (Азийн хөгжлийн банкны техникийн туслалцаа 2020-2022 он) 40 хувь
- “Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх” төсөл (Азийн хөгжлийн банкны техникийн туслалцаа 2020-2022 он) 40 хувь буюу нийлбэр дүнгээр 76.0 хувь

#### ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЭРСДЭЛ ШИЛЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



- Азийн хөгжлийн банкны 2.0 сая долларын буцалтгүй тусламж (2020-2022 он)
- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний чадавхыг сайжруулах. 40%
- Гамшгийн тэсвэртэй байдлыг сайжруулах. 40%
- Гамшгийн эрсдэлийг даван туулах санхүүгийн чадавхыг бэхжүүлэх. 40%
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын техникийн болон төслийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх. 40%

Төслийн нийт хэрэгжилтэд өгсөн үнэлгээ-40%

#### МОНГОЛ УЛСАД ГАМШГИЙН АЮУЛЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



- Азийн хөгжлийн банкны 550 мянган доллар, Японы ядуурлыг бууруулах сангийн 500 мянган доллар, нийт 1.05 сая долларын санхүүжилт. (2020-2021 он)
- Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцооны загварыг гаргах. 40%
- Цар тахлын тандан судалгаа, хөл хорионы хяналтын системийг боловсруулж, ашиглах. 40%

Төслийн нийт хэрэгжилтэд өгсөн үнэлгээ-40%

Зураг 6. ОБЕГ-т гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт (2020-2022 он)

7. Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 4 хөтөлбөр, 98 арга хэмжээ, ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс 88 ажил, арга хэмжээг 100 хувь, 9 ажил, арга хэмжээг 70 хувь, 1 ажил, арга хэмжээг 40 хувь тус тус хэрэгжүүлж, нийт дүнгээр үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрч сайн, үр дүн гарсан буюу 96.6 хувьтай дүгнэгдсэн.



Зураг 7. ОБЕГ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Тайланг хагас, бүтэн жилээр Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Шадар сайдын ажлын алба, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлэн, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний unelgee.gov.mn цахим сайтад тухай бүр байршуулж ажилласан.

## БҮЛЭГ 1.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГАА

### 1.3.1. Гадаад хамтын ажиллагаа, айлчлал

Онцгой байдлын байгууллагаас 2020 онд гадаад улс оронд зохион байгуулагдсан 11 удаагийн айлчлал, хурал, зөвлөгөөн, уулзалт, сургалт, семинар, үзэсгэлэн, яармагт нийт 20 алба хаагч оролцсон. Гадаад томилолтоор ажилласан 20 алба хаагчдаас дээд офицер 2, ахлах офицер 12, дунд офицер 4, ахлагч бүрэлдэхүүн 2 байгаа нь нийт гадаад томилолтоор ажилласан алба хаагчийн тоо өмнө жилийн үзүүлэлттэй харьцуулахад 92.2 хувиар буурсан. Харин гадаад улс орон, харилцаатай байгууллагуудаас Монгол Улсад 1 удаагийн айлчлал хийсэн байна.

Айлчлалын хүрээнд ОБЕГ-ын дарга, хошууч генерал Т.Бадралар ахлуулсан Онцгой байдлын байгууллагын алба хаагчид Оросын Холбооны Улсын Эрхүү муж, Бүгд Найрамдах Буриад Улсуудад 2020 оны 01 дүгээр сарын 19-24-ний өдрүүдэд албан айлчлал хийсэн бөгөөд тус айлчлалын үеэр Оросын Холбооны Улсын Онцгой



байдлын яамны Байгалийн эрэн хайх, аврах төвийн үйл ажиллагаатай танилцаж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр тус төвийн удирдлагуудтай санал солилцсон.

Уулзалтын үеэр сүүлийн жилүүдэд жуулчдын тоо эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан тус төвтэй ижил чиг үүргийн төвийг Хөвсгөл аймгийн Ханх суманд байгуулах шаардлага бий болоод байгаа талаар ярилцсан ба айлын талаас бидэнтэй хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн. Уулзалтын төгсгөлд Монгол Улсын Онцгой байдлын байгууллагын аврагчдыг жилд 2-3 удаа Байгалийн эрэн хайх, аврах төвд гүний шумбалт, гүний шумбалтын аврагчдыг бэлтгэх багш болон уулын аврах ажиллагааны чиглэлээр сургахаар тохиролцсон бөгөөд тус төвийн мэргэжлийн багш нарыг жилд 2 удаа Монгол Улсад авчран сургалт зохион байгуулахаар тохиролцсон.

Улмаар 2021 оны 3-р улиралд Байгалийн эрэн хайх, аврах төвтэй хамтран Хөвсгөл нууранд живсэн тээврийн хэрэгслийг уснаас гарган авах ажиллагааг гүний шумбалт, гүний шумбалтын аврагчдыг бэлтгэх багш нарын сургалттай хослуулан зохион байгуулахаар ажиллаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн мэдээллийн менежментийг хөгжүүлэх Ази, Номхон далайн төвөөс Бүгд Найрамдах Пакистан Улсын Гамшгийн удирдлагын газартай хамтран тус улсын Исламабад хотноо 2020 оны 02 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан “Гамшгийн мэдээллийн менежментийг хөгжүүлэх Ази, Номхон далайн төвийн Удирдах зөвлөлийн IV хуралдаан”-д ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Ц.Ганзориг оролцсон.

Энэхүү хуралдаан нь бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн хэмжээнд гамшгийн мэдээллийн менежментийн чадавхыг хөгжүүлэхэд тухайн бүс нутгийн улс орнууд, байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зорилготой зохион байгуулагдсан бөгөөд дараах үр дүнд хүрсэн юм. Үүнд:

- Уулзалтад оролцогчид бүс нутгийн гамшгийн мэдээллийн менежментийн нөхцөл байдал, чиг хандлага, хөгжлийн талаархи нийтлэг ойлголтод хүрсэн;
- Оролцогч улс, байгууллагын төлөөлөл гамшгийн мэдээллийн менежментийн чиглэлээр өөрсдийн мэдлэг, туршлагыг хуваалцсан;
- 2020, 2021 оны бүс нутгийн гамшгийн мэдээллийн менежментийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, 2020-2021 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн мэдээллийн менежментийг хөгжүүлэх Ази, Номхон далайн төвийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан байна.



Зураг 8. Гамшгийн мэдээллийн менежментийг хөгжүүлэх Ази, Номхон далайн төвийн Удирдах зөвлөлийн IV хуралдаан /2020.02.19-20/

Мөн ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Ц.Ганзориг тэргүүтэй төлөөлөгчид 2020 оны 02 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Чанвон хотод танилцах айлчлал хийсэн бөгөөд тус айлчлалын үеэр Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын “Чангшин” их сургууль, Чангвон хотын Галын газар хоорондын “Харилцан ойлголцлын санамж бичиг”, Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Чангвон хотын Захиргаа хоорондын “Эрмэлзлийн захидал”-д тус тус гарын үсэг зурж хамтран ажиллаж байна.



Зураг 9. Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын “Чангшин” их сургууль, Чангвон хотын Галын газар хоорондын “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулах ёслолын ажиллагаа /2020.02.17/



### 1.3.2. Дотоод хамтын ажиллагаа

Онцгой байдлын ерөнхий газар нь 2020 онд Иргэний нисэхийн ерөнхий газар, Зам, тээврийн яамны харьяа Далайн захиргаа, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Насан туршийн боловсролын төв, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын улаан загалмай нийгэмлэг, “Менежмент ба ур чадварын хүрээлэн”, “What3words Лимитэд” зэрэг төр, хувийн хэвшлийн нийт 7 байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулан гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гамшиг, ослын үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран 2020 онд “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, эрх зүйн орчин”, “Галын аюулгүй байдал”, “Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах нь” сэдэвт цахим сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр МҮХАУТ-ын хурлын танхимд зохион байгуулж нийт 60 гаруй ААНБ-ын төлөөллийг хамруулсан.



Зураг 10. МҮХАУТ-тэй хамтран ажиллах санамж бичиг байгуулах үйл ажиллагаа

Зам, тээврийн яамны харьяа Далайн захиргаатай хамтран Усан замын тээврийн хэрэгслээс осолдох, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учрахаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, усан замын тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиглэлээр ажиллаж байна.

What3Words Лимитэд компанитай хамтран гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг

арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд 3 үгт хаягжилтийн байршил тодорхойлох системийг нэвтрүүлэн ашиглаж байна. Энэхүү системийг нэвтрүүлснээр аливаа аюул, ослын голомтыг шуурхай тогтоож, эрэн хайх, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах боломж бүрдэж байгаа юм.



Зураг 11. "What3Words Лимитэд" компанитай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа

Монголын Улаан загалмай нийгэмлэгтэй хамтран Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, дунд шатны улаан загалмайн хороодын дарга нарт 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр "Ослын үеийн удирдлагын систем" сэдэвт сургалт зохион байгуулсан.

Сургалтад төв, орон нутгийн Онцгой байдлын газар, нийслэлийн 9 дүүргийн Онцгой байдлын хэлтэс, дунд шатны Улаан загалмайн хороодын дарга нар нийт 62 удирдах бүрэлдэхүүн хамрагдсан.



Зураг 12. МУЗН-тэй хамтран ажиллах санамж бичиг байгууллаа

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Насан туршийн боловсролын төв болон "Каритас Монгол" ТББ-тай хамтран "Гамшгийн үеийн сайн дурынхны удирдлага зохион байгуулалт" сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Сүхбаатар аймагт, 2021 оны 01 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд Орхон аймагт тус тус зохион байгуулсан. Уг сургалтад Насан туршийн боловсролын төвийн багш, мэргэжилтнүүд болон боловсролын байгууллага, иргэд нийт 84 хүнийг хамруулсан.

### **1.3.3. Онцгой байдлын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр**

Онцгой байдлын байгууллагад Азийн хөгжлийн банкны 2.0 сая ам.долларын санхүүжилт бүхий “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх төсөл” (2020.09-2022.09) болон 1 сая ам.долларын санхүүжилт бүхий “Эрт зарлан мэдээлэх нэгдсэн систем болон гамшгийн бэлэн байдлын чадавхыг бэхжүүлэх төсөл” (2020.09-2021.09) хэрэгжиж байгаа ба “Эрт зарлан мэдээлэх нэгдсэн систем болон гамшгийн бэлэн байдлын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн 33 сая ам.долларын санхүүжилт бүхий дараагийн шат буюу үндсэн зээлийн төсөл нь 2022 оны 02 дугаар сараас 2029 оны 01 дүгээр сар хүртэл 7 жилийн хугацаанд хэрэгжинэ. Дээрх төслүүдийн хүрээнд Онцгой байдлын байгууллагын холбоо, эрт зарлан мэдээлэх, орон зайн мэдээллийн систем болон гамшгийн эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх болон эрсдэл шилжүүлэх чадавх дээшилнэ.

## **БҮЛЭГ 1.4. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ**

### **1.4.1 Онцгой байдлын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын бэхжилт**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн мн/163 дугаар тогтоолоор “Салбар нэгжийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, Онцгой байдлын ерөнхий газрын харьяанд Агаараас эрэн хайх, аврах анги, Хувцас хэрэглэлийн туршилт үйлдвэрлэлийн төв, Эрэлч нохойн сургалтын төвийг шинээр байгуулсан.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд Клиник сургалтын IV-р зэрэглэлийн гал унтраах, аврах анги, Төв аймгийн Батсүмбэр суманд IV-р зэрэглэлийн гал унтраах, аврах анги, Булган аймгийн Хутаг-Өндөр суманд Эрэн хайх, аврах салбар шинээр байгуулсан.

### **1.4.2 Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавх**

Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах, бие бүрэлдэхүүний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллага 2020 оны сургуулийн жилдээ “Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг хангуулахдаа эзэмшсэн онолын мэдлэгт тулгуурлан дадлага олгох, сургалтын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх замаар алба хаагчдын мэргэшсэн байдлыг хангаж, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлнэ” гэсэн зорилт тавьсан.


Энэ зорилтын хүрээнд үйл ажиллагаа, мэдлэг чадвар, хандлага төлөвшил гэсэн үндсэн гурван чиглэлээр онолын мэдлэгт тулгуурласан дадлага олгох, дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх, хөдөлмөрийн

аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг эрчимжүүлэх, алба хаагчдад эх оронч үзэл, цэрэгжилт, жагсаалч байдлыг төлөвшүүлэх, бие бялдар-сэтгэлзүйн бэлтгэл олгохоор сургалтын нэгдсэн төлөвлөгөө, удирдамж боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг хангах, сургалт, дадлага, тэмцээн уралдаан зохион байгуулах, амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор олон улсын стандартын шаардлага хангасан хөлбөмбөгийн талбай, спорт заал, гүйлтийн замтай “Сургалт, биеийн тамирын цогцолбор”-ыг 2020 онд байгуулсан.

### Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар:

Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүнд сургалт дадлагыг танхим, дадлага, хосолсон хэлбэрээр зохион байгуулснаас сургалт, бэлтгэлийн амжилт 90%, 70%-ийн чанартайгаар дүгнэгдсэн.



Зураг 13. Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний 2019, 2020 оны сургалт, бэлтгэлийн үнэлгээний харьцуулалт

Онцгой байдлын байгууллага 2020 оны сургуулийн жилдээ “Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн ажлын хүрээнд ОБЕГ-ын даргын А/168 дугаар тушаалаар Үндэсний аврах бригадын Эрэн хайх, аврах нохойн алба “Ангийн гаралтай түүхий эд олж, илрүүлэх” анхан шатны 45 хоногийн сургалтыг 2020 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо Туул тосгон Эрэн хайх, аврах нохойн албаны сургалтын байранд амжилттай зохион байгууллаа.





Зураг 14. Эрэн хайх, аврах нохойн албаны “Ангийн гаралтай түүхий эд олж, илрүүлэх” сургалтын явц

“Тарваган тахал” өвчнөөс урьдчилан сэргийлэх, тарваганы махыг Улаанбаатар хот руу оруулахгүй байх зорилгоор зохион байгуулагдсан тус сургалтад Нийслэлийн Онцгой байдлын газрын ГТУА 26, 35, 65, 80, 28, 64 дүгээр ангиудын нийт 6 алба хаагч тээврийн хэрэгслүүдэд нохойны үнэрлэх чадварыг ашиглан ангийн гаралтай түүхий эдийг эрэн хайх, үзлэг хийх, нохой хөтлөгч болгон бэлтгэгдлээ.



Зураг 15. “Тарваган тахал” өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой Эрэн хайх, аврах нохойн албаны “Ангийн гаралтай түүхий эд олж, илрүүлэх” сургалт

Онцгой байдлын албаны Эрэн хайх, аврах анги, салбарын захирагч нарын Эрэн хайх аврах ажиллагааны ахлах удирдагч сэдэвт “ЭХААУ” сургалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/17 дугаар тушаалаар төв, орон нутгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах анги, салбарын 22 захирагчийг хамруулсан.

Сургалтыг Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар, Гамшгийн шуурхай удирдлагын газар хамтран Үндэсний аврах бригадад амжилттай зохион байгууллаа.



Зураг 16. “Эрэн хайх аврах ажиллагааны ахлах удирдагч” сэдэвт сургалт

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны А/174 дүгээр тушаалаар Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны аврагч-уулчдын “ӨУЭХААС-20” Баруун бүсийн аймгуудын Онцгой байдлын газруудын хамтарсан дадлага сургалтыг 2020 оны 08 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд Ховд аймгийн Онцгой байдлын газрыг түшиглэн тус аймгийн Мөнххайрхан сумын Мөнххайрхан уулын “Жамъянгарав” оргил, Зэрэг сумын Жаргалант хайрхан уулын “Баатархайрхан” оргилд тус тус зохион байгуулсан. Сургалтад Ховд аймгийн онцгой байдлын газрын 13, Говь-Алтай аймгийн онцгой байдлын газрын 9, Увс аймгийн онцгой байдлын газрын 5, Аврагч спорт хорооны 1, нийт 26 алба хаагч хамрагдсан.

“ХС-20” Баруун бүсийн Онцгой байдлын байгууллагын Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор, шуурхай удирдлагын оператор, жолооч-холбоочдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 16 цагийн онол, дадлагын сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд Увс аймгийн Онцгой байдлын газрын “Усны сургалт, хяналт дадлагын төв”-д зохион байгуулж нийт 58 алба хаагч, 35 холбооны тоног төхөөрөмж, 6 автомашинтайгаар хамрагдсан.



*Зураг 17. “Өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаан-20” сэдэвт сургалт*

“ХС-20” Баруун бүсийн Онцгой байдлын байгууллагын Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор, шуурхай удирдлагын оператор, жолооч-холбоочдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 16 цагийн онол, дадлагын сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд Увс аймгийн Онцгой байдлын газрын “Усны сургалт, хяналт дадлагын төв”-д зохион байгуулж нийт 58 алба хаагч, 35 холбооны тоног төхөөрөмж, 6 автомашинтайгаар хамрагдсан.



*Зураг 18. “ХС-20” сэдэвт сургалт*



### *1-р хэсэг. Гамшигаас хамгаалах удирдлага*


Онцгой байдлын ерөнхий газраас Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хөргөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлсэн “Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах” төслийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа гал унтраах тусгай зориулалтын автомашины жолооч нарын сургалт, дадлагыг зохион байгууллаа.

Сургалтад төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын 80 гаруй алба хаагч хамрагдсан бөгөөд сургалтыг Беларусь улсын сургагч багш нар удирдан явуулсан.



*Зураг 19. Гал унтраах тусгай зориулалтын автомашины жолооч нарын сургалт*

Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн гадаад улс оронд хүний нөөцийг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн ажлын хувьд ОХУ-д 2020-2021 оны хичээлийн жилд ОБЯ-ны Иргэний хамгаалалтын академийн бакалаврт 5 сонсогч, Гал эсэргүүцэх албаны академийн бакалаврт 2 сонсогч, хэлний бэлтгэлд 10 сонсогч, Санкт-Петербургийн Гал эсэргүүцэх их сургуулийн бакалаврт 2 сонсогчийг тус тус сонгон шалгаруулж, бэлтгэл ажлыг ханган сургуульд нь элсүүлсэн. Бүх сонсогчид 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хичээл сургалтдаа цахимаар хамрагдаж байна.



Зураг 20. ОХУ-ын Гал эсэргүүцэх албаны академи, Иргэний хамгаалалтын академид сурч буй сонсогчдын судалгаа

Бүгд Найрамдах Турк улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт 2020 оны хичээлийн жилд оюутан элсүүлж, суралцуулах хүсэлтийг БНТУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүргүүлж, нэр дэвшигчдийг сонгон шалгаруулалтад оруулсан ба нийт 6 сонсогч сонгогдож, эцсийн шатны шалгаруулалтад 2 сонсогч тэнцсэн бөгөөд 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн цахим хэлбэрээр Турк хэлний хичээлд хамрагдаж байна.

Бүгд Найрамдах Польш улсын Галын ерөнхий сургуульд “Галын аюулгүй байдлын инженер” мэргэжлээр бакалаврын түвшний сургалтад 3 алба хаагч 2020 оны 9 сараас эхлэн суралцаж байна.

Дотоод хэргийн их сургуулийн хэмжээнд 2020 онд 4 жилийн сургалттай өдрийн ангид шинээр элссэн 19 сонсогч, нийт 135 сонсогч, “Гамшиг судлал” магистрын зэргийн сургалтад нийт 31, докторын сургалтад нийт 22 алба хаагч, эчнээ 5 жилийн ахлагчийн ангид нийт 68, эчнээ 3 жилийн офицерийн ангид нийт 20, өдрийн 2 жилийн офицер, ахлагчийн ангид нийт 12, эчнээ 5 жилийн ангид 20, Удирдлагын академийн өдрийн ангид 1, гаригийн ангид 9, заасан улиралын ангид 9 тус тус нийт 339 суралцагч суралцаж байна.




Зураг 21. Дотоод хэргийн их сургуульд сурч буй сонсогч, суралцагчдын судалгаа



### 1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага

Цэргийн алба хаагчийн ёс зүй, цэргийн дүрэм, жагсаалын дүрэм, штабын дадлага сургууль, байр зүйн зураг дээр ажиллах, амилуулах суурь тусламж, химийн дадлага зэрэг агуулгын хүрээнд хээрийн дадлага хэлбэрээр явагдсан нь Онцгой байдлын байгууллагад цэргийн албыг хэвшүүлж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд томоохон ахиц гарсан.

Алба хаагчдын цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт, биеийн зохистой харьцааг хангах Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2017 оны 505 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд уян хатан, тэсвэр, хурд хүч, авхаалж самбаа биеийн зохистой харьцаа гэсэн үзүүлэлтээр тогтмол бэлтгэл сургуулилт хийлгэж байна.



**Үүнээс биеийн жингийн илүүдэлтэй нь Хэнтий аймгийн ОБГ (49 алба хаагч), хэвийн жинтэй манлайлагч нь Баянхонгор аймгийн ОБГ**

Зураг 22. Алба хаагчдын биеийн зохистой харьцааны судалгаа

Зэвсэгт хүчний жанжин штабын даргын биеийн жингийн зохистой харьцааг хангах тухай тушаал гарснаас хойшхи 3 жилийн хугацаанд жингийн хэтрэлттэй алба хаагчдын тоо 15 орчим хувиар, сүүлийн 1 жилтэй харьцуулахад 8 хувь буурсан нь эрүүл, амьдралын зөв хэвшлийг хэрэгжүүлж байгаагийн илрэл болж байна.

#### 1.4.3 Техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт

2020 онд гамшгаас хамгаалах техник, хэрэгслийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор 2 дүүрэг, 13 аймгийн 18 нэгжид 18 иж бүрдэл шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн тоног төхөөрөмж, амьсгалын бие даасан төхөөрөмж, аврах ажиллагааны комби багаж, амьсгалын бие даасан төхөөрөмж цэнэглэх шахуурга, аккумулятор, гал унтраах хөөс үүсгэгч бодис худалдан авч, төв, орон нутгийн онцгой байдлын анги байгууллагуудад хуваарилсан.

**Гадаад улсын засгийн газрын нөхцөлт зээлийн хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн зээлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Онцгой байдлын байгууллагад Агаараас аврах ажиллагааны нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх” төслийн **1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:** Буянт-Ухаа Олон улсын нисэх онгоцны буудлын хамгаалалтын бүсд ангар, сургалтын байгууламж барих, агаараас эрэн хайх, аврах үйл ажиллагаа явуулах ЕС-145 маркийн 3ш нисдэг тэрэг, 1ш сургалтын Кабри нисдэг тэрэг, сургалтын симулятор нийлүүлэх, **2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:** Онцгой байдлын газар, хэлтсүүдэд химийн болон нефть бүтээгдэхүүний гал унтраах тусгай зориулалтын 41ш гал унтраах автомашин нийлүүлэх 30.5 сая евро үнийн дүн бүхий төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй “Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах” төслийн хүрээнд **15 427 750** еврогийн өртөг бүхий **14** төрлийн нийт **71** автомашин нийлүүлэгдэх бөгөөд гэрээний дагуу 1, 2, 3 дугаар ээлжийн 56 автомашиныг ОБЕГ-ын даргын тушаалаар төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хүрээнд хэрэгжсэн “Гамшгийн үеийн хөдөлгөөнт хээрийн эмнэлэг-2 иж бүрдэл” төслийн үр дүнд Онцгой байдлын алба гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх зориулалт бүхий II шатлалын хээрийн хөдөлгөөнт эмнэлэгтэй болж, чадавх дээшилсэн.

Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсад ашиглагдаж байсан тусгай зориулалтын Гал унтраах зориулалттай 3ш автомашиныг Архангай, Булган, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар худалдан авч Архангай аймгийн Хотонт сум, Булган аймгийн Тэшиг сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгүүдэд хүлээлгэн өгсөн.

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд:**

Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т зааснаар Онцгой байдлын байгууллага нь төрийн цэргийн байгууллагын болсонтой холбогдуулан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, улсын болон батлан хамгаалах нөөцийн бодит хэмжээ, байршил, тайлан, санхүүжилтийн тухай мэдээ, онцгой байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглах тухай мэдээлэл, удирдлагын хоргодох байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээллийг төрийн нууцад хамааруулахаар болсон.

Тус хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс товчхондоо ОББ-ын төсөв, орон тоо төрийн нууцад хамаарах болсон.

### *1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага*

Онцгой байдлын байгууллага нь гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх хүрээнд 2020 оны улсын төсвийн хүрээнд Увс аймгийн Баруунтуруун суманд Улсын төсвийн 2,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Гал түймэр унтраах, аврах 3-р зэргийн ангийн барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад оруулсан.

Улсын төсвийн 13,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдах Нийслэлийн Онцгой байдлын газар, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлсэн, 2021 оны 4-р улиралд ашиглалтад орно.

Алба хаагчдын ажлын байр, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор төсвийн урсгал зардлаар ДССЗТөв 113 дугаар ангийн дэргэдэх Сургалт, биеийн тамирын цогцолбор, спорт заалны барилга угсралтын ажил, Онцгой байдлын ерөнхий газрын 3, 4 дүгээр давхрын засвар, соёлын төв, шалган нэвтрүүлэх байрны засварын ажил гүйцэтгүүлсэн.

2020 онд төсвийн урсгал зардлаар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Гал түймэр унтраах, аврах /ГТУА/ 26 дугаар ангийн барилгын засвар, Багануур дүүргийн ОБХ-ын дээвэр болон сантехникийн засварын ажил, Дундговь аймгийн Онцгой байдлын газрын барилгын засвар, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум дахь ГТУА 73 дугаар ангийн барилгын засвар болон Өвөрхангай аймгийн газрын техник хэрэгслийн засвар үйлчилгээ, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Баянхонгор аймгийн Баянговь, Жаргалант, Дархан-Уул аймаг, Дорнод аймгийн Баян-Уул, Сэлэнгэ аймгийн Баянгол, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Гал түймэр унтраах, аврах анги, Хэнтийн аймгийн Баян-Адрага сум дахь Эрэн хайх аврах салбарын гадна цэвэр, бохир усны холболтын ажил, төв, орон нутгийн Онцгой байдлын анги байгууллагын тавилга хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн засварын зардалд зориулж төсвийн хуваариар Онцгой байдлын анги байгууллагад тус тус олгосон.

Хандив тусламжийн ажлын хүрээнд 2020 онд иргэд, аж ахуйн нэгжийн санаачлагаар цугларсан 6,396,334,174.9 төгрөгийн мөнгөн хөрөнгө, 5,859,395,298.0 төгрөгийн үнэ бүхий бараа, материал цугларсныг Нийслэлийн Онцгой комисс болон 21 аймгуудад мөнгөн хөрөнгө болон бараа материалын тусламж үзүүлсэн байна.

## **БҮЛЭГ 1.5. ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ**

### **1.5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагаа**

Дэлхий дахинд болон Монгол Улсын хэмжээнд үзэл баримтлалын шинэчлэл явагдаж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд гамшгийн эрсдэлийн удирдлагын үүрэг, оролцоо нэмэгдэж байгаатай уялдуулан онцгой байдлын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээний нэгжийг нэгдмэл удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулах зорилгоор ОБЕГ-ын Шинжлэх ухаан технологийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг ОБЕГ-ын даргын 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/330 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

ОБЕГ-ын ШУТЗ нь салбарын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны бодлого, зохицуулалтыг сайжруулах, инновацийг дэмжих орчин бүрдүүлэх чиглэлээр түлхүү анхаарч ажиллаж байна. Тус зөвлөл нь 2017-2019 онд онцгой байдлын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээний нэгжийг нэгдмэл удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулахад чиглэсэн дараах баримт бичгийг батлан гаргажээ.

Онцгой байдлын байгууллагад оюуны өмчийг бүтээх, хамгаалах, ашиглах, түгээн дэлгэрүүлэх, олсон орлогыг хувиарлах үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, оюуны өмчийн соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Оюуны өмчийн талаар онцгой байдлын байгууллагын баримтлах бодлого” -ыг боловсруулж ОБЕГ-ын даргын 2017 оны А/332 тоот тушаалаар батлуулсан.

“Онцгой байдлын байгууллагын инновацийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/334 дүгээр тушаалаар батлууллаа. Энэхүү инновацийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Онцгой байдлын байгууллагад инновацийн тогтолцоо бүрдэх, нийт алба хаагчдын инновацийн мэдлэг дээшилж, тэдгээрийг шинэ, шинэлэг санаа, арга замыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломж бүрдэж, инновацийн үйл ажиллагааны хамтын ажиллагаа сайжрах боломж бүрдэнэ.

Гамшгаас хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс Онцгой байдлын албаны сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд болох Гамшиг судлалын хүрээлэн, Онцгой байдлын сургууль, Нийслэлийн иргэдийн сургалтын төв, Онцгой байдлын музей гэсэн 4 байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг шинэчлэн тодорхойлж 2018-2022 он хүртэлх хугацааны стратеги зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардлагатай хөрөнгийг тусгасан “Онцгой байдлын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээний нэгжүүдийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г боловсруулж, ОБЕГ-ын даргын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/149

## **1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага**

дүгээр тушаалаар батлуулсан.

Онцгой байдлын байгууллагад шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг тогтоох, энэхүү үйл ажиллагаанд оролцогч талууд болох ОБЕГ-ын ШУТЗ, Гамшиг судлалын хүрээлэн, Онцгой байдлын сургууль, Иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв, Давтан сургалт, сэргээн заслын төв, Аврагч спорт хорооны үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааны хүрээг тогтоосон "Онцгой байдлын байгууллагын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журам"-ыг боловсруулж ОБЕГ-ын даргын 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлуулсан.

Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөс гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодлого, эрхзүйн орчин, практикт тулгамдсан асуудлыг шинжлэх ухаанд тулгуурлан, уламжлал, шинэчлэлийг хослуулан шийдвэрлэх талаар дэвшүүлсэн эрдэмтэн, судлаачдын үзэл, бодол, дүгнэлт санал, судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгоход дэмжлэг үзүүлэх "Гамшиг судлал, инновац" онол, арга зүйн мэргэжлийн сэтгүүлийг 2018 оноос эхлэн эрхлэн 2020 онд 2 дугаар гаргасан.

Шинжлэх ухаан технологийн зөвлөлийг байгуулснаар Онцгой байдлын байгууллага дахь шинжлэх ухаан технологи, инновацын үйл ажиллагааны эрхзүйн орчин сайжирч, сургалт, судалгааны байгууллагууд үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд хамтран ажиллах, нэгдмэл удирдлагаар хангах, судлаач, эрдэм шинжилгээний ажилтнуудыг урамшуулах орчин бүрдсэн юм.

### **1.5.2. Гамшиг судлалын хүрээлэнгээс гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний ажил**


#### **НЭГ. СУДАЛГААНЫ АЖИЛ**

Гамшиг судлалын хүрээлэн нь байгуулагдсан цагаасаа хойш буюу 2005-2020 онд нийт 120 судалгааны ажлыг хийж гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

Тус хүрээлэн нь 2020 онд дараах 10 судалгааны ажлыг гүйцэтгэж, явцын болон эцсийн тайланг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн, хүлээн авсан байна.

Хүснэгт 1. Гамшиг судлалын хүрээлэнгээс  
2020 онд гүйцэтгэсэн судалгааны ажил

ОБЕГ-ын захиалгат судалгаа		Хүрээлэнгээс төлөвлөж хийсэн судалгаа	
1	"Ой, хээрийн түймрийг эрт илрүүлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нь" судалгаа	6	Гамшгаас хамгаалах бодлого ба стратеги
2	Нийслэлийн үерийн эрсдэлийн судалгаа	7	Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд хийсэн шинжилгээ
3	Хувийн сууцны галд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх боломж	8	Улсын нөөц дахь гурилын хадгалалтад хийсэн судалгаа
4	Барилгад ашиглаж буй бодис, материалын галын аюулын шинж чанар, тэдгээрийг ашиглалтанд хийсэн шинжилгээ	9	Ганд тэсвэртэй буудайн сорт, сорилт, туршилт судалгаа
5	Сумдад байгуулагдсан сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн судалгаа	10	Улсын нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох арга зам



Зураг 23. 2005-2020 он хүртэлх Гамшиг судлалын хүрээлэнгийн гүйцэтгэсэн судалгааны ажлын тоо

Эдгээр судалгааны ажлын тайлан, үр дүнгийн талаар Гамшиг судлалын хүрээлэнгийн бүтээлийн эмхэтгэл 2020 номноос дэлгэрэнгүй харж болно.

**Хээрийн түймрийг эрт илрүүлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх асуудал сэдэвт захиалгат судалгааны ажлын 2020 оны үр дүн**

ОБЕГ-ын захиалгат Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэй “Хээрийн түймрийг эрт илрүүлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зарим асуудал” сэдэвт судалгааны ажлын хүрээнд хээрийн түймэртэй тэмцэхэд дэвшилтэт технологийг ашиглаж буй гадаад орнуудын тэргүүн туршлагыг судлаж, өнөөгийн байдлын судалгааны хүрээнд Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн 1000 иргэнээс түймрийн талаарх ойлголт, мэдлэг, унтраах ажиллагааны багаж хэрэгслийн талаар судалгаа авч боловсруулалт хийсэн.

Эдгээр судалгааны үр дүнгээр “Дэвшилтэд технологид суурилсан ой, хээрийн

## **1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага**

түймэртэй тэмцэх үйл ажиллагааг нэвтрүүлэх боломж” илтгэл бичиж 2019 оны 9 дүгээр сарын 27-нд болсон “Хот суурин газрын гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэх арга зам” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэв. Мөн 2019 оны 09-р сарын 20-ны өдөр гамшгаас хамгаалах албадын болон их дээд сургуулиудын эрдэмтэн судлаачдын хүрээнд “Хээрийн түймэртэй тэмцэхэд дэвшилтэт технологийг ашиглаж буй гадаад орнуудын тэргүүн туршлага” сэдэвт хэлэлцүүлэг хийлээ.

“Хээрийн түймрийг эрт илрүүлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зарим асуудал” төслийн судалгааны ажлын хэлэлцүүлэг, (зүүн тал- Туушин зочид буудал 2019.09.27, баруун тал- Гамшиг судлалын хүрээлэн, 2020.09.20)

### **Гамшгаас хамгаалах бодлого ба стратеги суурь судалгааны ажлын 2020 оны үр дүн**

“Гамшгаас хамгаалах бодлого ба стратеги” суурь судалгааг Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлж байна. 2019-2021 онд энэ судалгааны ажлын үр дүнд нэг сэдэвт бүтээл гарна. 2020 онд тус судалгааны ажлын хүрээнд “Гамшгаас хамгаалах бодлогын хөгжил, шинэчлэл” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр цахимаар зохион байгуулж, 12 заалт бүхий зөвлөмж гаргаж, талуудад хүргүүлсэн. Мөн Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг тодорхойлж, тайланг боловсруулан “Гамшиг судлал-Инновац” онол, арга зүйн сэтгүүлд хэвлүүлсэн.

### **Ганд тэсвэртэй буудайн сорт, сорилт, туршилт судалгаа**

Монгол Улсын стратегийн нөөцөд ганд тэсвэртэй, нутагшсан сортын үр үржүүлэн гарган авч хадгалах зорилгоор “Ганд тэсвэртэй буудайн сорт, сорилт, туршилт судалгаа”-ны ажлыг амжилттай үргэлжлүүлэн хийж байна. 2020 онд Булган аймгийн Сэлэнгэ 50 га, Увс аймгийн Баруунтуруун 100 га-д үр үржүүлгийн тариалалт хийж нийт 155 орчим тонн буудай хураан авч, газар тариалангийн 5 бүсэд 16 буудайн сорт туршилтыг тариалах ажлыг зохион байгуулан ХХААЯ, орон нутгийн агрономичтай хамтарч хянан баталгаа хийгдсэн. .

Энэхүү сорт сорилт, туршилт, судалгааны ажлын хүрээнд 2020 оны 8 дугаар сарын 18-26-ний өдрүүдэд Увс аймгийн Баруунтуруун, Булган аймгийн Сэлэнгэ сумдад сорт нутагшуулах, үр үржүүлгийн онол арга зүйн дадлага сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар сорт сорилт явуулах, үр үржүүлэх, хөрсний дээж авах арга зүйн талаар илтгэл тавьж



үр үржүүлгийн тариалагийн талбайд хянан баталгаа хийх, мөн сорт сорилт явуулж байгаа үед талбайн журналын болон цаг агаарын мэдээллийн хөтлөлтийг явуулах арга зүйн талаарх сургалт зохион байгуулагдсан.

Тус судалгааны ажил нь 2018 онд эхэлсэн бөгөөд нийт 5 жил үргэлжилж 2022 онд дуусна.

### ХОЁР. ЛАБОРАТОРИЙН ТУРШИЛТ, ШИНЖИЛГЭЭ



Зураг 24. Увс аймгийн Баруунтуруун, Булган аймгийн Сэлэнгэ суманд хэрэгжиж буй "Ганд тэсвэртэй буудайн сорт, сорилт, туршилт судалгаа"-ны ажлын явц

Гамшиг судлалын хүрээлэнгийн Галын болон химийн лаборатори нь сүүлийн 15 жилийн хугацаанд жилд дунджаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 185 бодис, материалд галын аюулын үзүүлэлтийг тодорхойлсон дүгнэлтийг, түүнчлэн шүүх, прокурор, мөрдөгчийн тогтоолын дагуу гал түймрийн хэргийн газраас ирүүлсэн 295 дээжинд шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллаж байна. Түүнээс гадна жилд дунджаар улсын хэмжээнд гарсан томоохон хэмжээний 166 гал түймрийн шалтгаан нөхцөлийг тодорхойлоход шинжээчээр ажилласан. Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор тус лабораторид хандан дүгнэлт гаргуулахаар ирүүлж буй гал түймрийн шалтгаан тогтоох шаардлагатай дээжийн тоо эрс нэмэгдсэн. Нийт шинжилгээнд ирж буй дээжний 45 хувийг цахилгаан дамжуулагчид шинжилгээ хийх дээж материал эзэлж байна.



Зураг 25. 2006-2020 онд Галын лабораторид ирүүлсэн материалын галын аюулын үзүүлэлтийг тодорхойлуулах хүсэлт болон шинжилгээ хийсэн бүтээгдэхүүний тоо



### *1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага*

Гамшиг судлалын хүрээлэнгийн Галын лаборатор нь 2020 онд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хүсэлтээр 219 албан бичгээр ирсэн 267 дээжинд туршилт шинжилгээ хийж, 219 лабораторийн сорилтын дүгнэлт гаргаж, Шүүх цагдаагийн байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөгчийн 166 тогтоолоор 295 дээжинд шинжилгээ хийж, шинжээчийн 166 дүгнэлт гарган ажилласан.

Химийн лаборатор нь цагдаагийн газраас “Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай” 58 мөрдөгчийн тогтоолын дагуу гал түймрийн хэргийн газраас шинжилгээнд ирүүлсэн 272 дээжийг хүлээн авч, шинжлэн 58 шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

2020 онд нэгдсэн дүнгээр 443 албан бичгийн хүрээнд ирүүлсэн 834 дээжинд батлагдсан стандарт, арга, аргачлалын дагуу холбогдох сорилт, шинжилгээг хийж, 224 шинжээчийн дүгнэлт болон лабораторийн сорилтын дүн гарган шийдвэрлэсэн байна.

### **ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, СУРГАЛТ**

#### ***“Гамшгаас хамгаалах бодлогын хөгжил, шинэчлэл” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал:***

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс “Гамшгаас хамгаалах бодлогын хөгжил, шинэчлэл” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр цахимаар зохион байгууллаа.

Хуралд Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн онцгой байдлын газар, Үндэсний аврах бригад, Гамшгаас хамгаалах улсын албад, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, Монголын улаан загалмай нийгэмлэг, Дотоод хэргийн их сургууль, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэн судлаачид зэрэг нийт 24 байгууллагын 100 гаруй төлөөлөл оролцож, гамшгаас хамгаалах бодлогын хөгжил, шинэчлэл, түүний хэрэгжилт, цаашдын чиг хандлага, стратегийн чиглэлээр шинэлэг санааг агуулсан онол, арга зүйн болоод практик ач холбогдолтой 6 илтгэлийг хэлэлцлээ.

Боловсрол, шинжлэх ухаан, спортын яамны захиалгат “Гамшгаас хамгаалах бодлого ба стратеги” суурь судалгааны төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа энэхүү хурлаар гамшгаас хамгаалах бодлогын хөгжил, шинэчлэлийн асуудлыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талууд, эрдэмтэн судлаачдын төлөөллийг оролцуулан хэлэлцэж, тэдний санал зөвлөмжийг авч байгаа нь судалгааны ажлыг чанаржуулахад ихээхэн түлхэц болж хурлын ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

Эрдэм шинжилгээний бага хурлаас гамшгаас хамгаалах бодлого,

стратегийг боловсруулагчид болон энэ чиглэлээр судалгаа хийж байгаа эрдэмтэн судлаачдад хандсан дараах зөвлөмжийг гаргасан. Үүнд:

***Нэг. Гамшгаас хамгаалах бодлогын баримт бичиг боловсруулагчдад:***

1.1.Өсөн нэмэгдэж буй гамшгийн эрсдэл, тэдгээрт эмзэг бүлгийн өртөх байдал, нэн ялангуяа газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг бодлого, стратеги боловсруулахад заавал харгалзан үзэж байх;

1.2.Бүх түвшинд гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй байгууллагын чадавхыг бэхжүүлж, орон нутаг дахь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх;

1.3.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зайнаас тандан судлал, орон зайн мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, холбоо зарлан мэдээллийн системийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

1.4.Үндэсний болон орон нутгийн гамшгаас хамгаалах материал техникийн нөөцийг бий болгон иргэд, байгууллагын гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх;

1.5.Гамшгаас хамгаалах салбар дундын хамтын ажиллагааг дээшлүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бүх нийтийн үйл хэрэг болгох нөхцлийг бүрдүүлэх;

1.6.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэгдүүлэх, гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд оролцогчдын нийгмийн баталгааг сайжруулах;

1.7.Гамшгаас хамгаалах бодлогыг үндэсний аюулгүй байдлын болон салбаруудын хөгжлийн бодлоготой уялдуулах, гамшгаас хамгаалах бодлогын хэрэгжилтэд салбар дундын оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн механизмыг сайжруулах.

***Хоёр. Эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдад:***

2.1.Үндэсний болон салбарын хөгжлийн бодлого дахь гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын байр суурь, ач холбогдлыг авч үзэх шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлох.

2.2.Гамшгийн эрсдэлийн удирдлагын засаглал, гамшгаас хамгаалах стратегийн удирдлагын хэрэгжилт, хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх онол, аргазүйн үндсийг тодорхойлох.

2.3.Гамшгаас хамгаалах бодлогын зорилго, зорилт, үр нөлөө, суурь болон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлох.

2.4.Гамшгаас хамгаалах бодлого судлалыг хөгжүүлэх, энэ чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрдэмтэн, судлаачид мэдлэг, туршлагаа хуваалцах үйл явцыг дэмжих, судалгааны ажлын санхүүжилт олох, хөрөнгө оруулалт татах нэгдсэн механизм бүрдүүлэх

2.5.Судалгааны байгууллага, төрийн байгууллага хоорондын түншлэлийг

бодитой идэвхжүүлэх, эрдэм шинжилгээний бүтээлүүдээ сурталчилан таниулж хэрэглээнд оруулж ач холбогдлыг нь өсгөх арга хэмжээг зохион байгуулах.

### **Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт:**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.3.1 дэх “эрсдэлийн үнэлгээний шинжээчийн бүрэлдэхүүн нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх” гэсэн заалт, Монгол Улсын Засгийн газрын 67 дугаар тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалаар батлагдсан Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар зэрэг баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гамшиг судлалын хүрээлэнгээс анх удаа Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалтыг 2020.01.20-2020.02.02-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалтаас нийт 41 төгсөгчид Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалтын чадамжийн гэрчилгээ гардан авсан. Сургалтын агуулгад дараах сэдвүүд багтсан. Үүнд:

- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний арга зүй ба эрх зүйн орчин
  - Ой, хээрийн түймрийн эрсдэлийн үнэлгээ
  - Объектын гал түймрийн эрсдэлийн үнэлгээ
  - Ус, цаг уурын гаралтай гамшгийн эрсдэл (үер, салхи шуурга)-ийн үнэлгээ
  - Уур амьсгалын гаралтай гамшгийн эрсдэл (ган, зуд)-ийн үнэлгээ
  - Хүн ба мал, амьтны халдварт өвчний эрсдэлийн үнэлгээ
  - Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ
  - Химийн ослын эрсдэлийн үнэлгээ
  - Цацрагийн ослын эрсдэлийн үнэлгээ
  - Тэсэрч дэлбэрэх ослын эрсдэлийн үнэлгээ
- гэсэн 10 багц сэдвийн агуулгын хүрээнд 110 цагийн танхимын сургалт болон үйлдвэрлэлийн дадлага гэсэн хэлбэрээр зохион байгууллаа.


### **1.5.3. Онцгой байдлын байгууллагын инновацын үйл ажиллагаа**

Онцгой байдлын байгууллагын хэмжээнд инновацийн үйл ажиллагаа нь Инновацын тухай хууль, “Төрөөс инновацын талаар баримтлах бодлого”, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Патентийн тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай хууль, ОБЕГ-ын даргын 2017.12.20-ны өдрийн А/332 дугаар тушаалаар батлагдсан

*Монгол Улсын гамшгаас хамгаалах Цагаан ном 2020*

“Оюуны өмчийн талаар онцгой байдлын байгууллагын баримтлах бодлого”, ОБЕГ-ын даргын 2017.12.21-ний өдрийн А/334 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын инновацийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө” зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд явагдаж байна.

2020 оны Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэвшилтэт технологи, стандарт, инновацыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Орон нутгийн ОББ-ын 26 салбар, нэгжүүдийн 540 орчим алба хаагчид цахим сургалтыг Google Classroom, Meet, Zoom программууд ашиглан “Инноваци ба Бүтээмж” багц сургалт зохион байгууллаа.



**Хүснэгт 2. Онцгой байдлын байгууллагын салбар нэгжүүдийн шинэлэг санаа, бүтээлч ажил**

№	ОББ-ын бүтцийн нэгжүүд	Тоон үзүүлэлт	Хувиар
1	Гал түймэртэй тэмцэх газар	2	1.3%
2	Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар	3	2.0%
3	Орхон аймгийн ОБГ	10	6.6%
4	Төв аймгийн ОБГ	4	2.6%
5	Булган аймгийн ОБГ	9	5.9%
6	Дархан-Уул аймгийн ОБГ	4	2.6%
7	Архангай ОБГ	4	2.6%
8	Сэлэнгэ ОБГ	5	3.3%
9	Хөвсгөл ОБГ	9	5.9%
10	Ховд аймгийн ОБГ	5	3.3%
11	Баян-Өлгий аймгийн ОБГ	4	2.6%
12	Завхан аймгийн ОБГ	6	3.9%
13	Говь-Алтай аймгийн ОБГ	6	3.9%
14	Дорнод аймгийн ОБГ	6	3.9%
15	Хэнтий аймгийн ОБГ	10	6.6%
16	Сүхбаатар аймгийн ОБГ	2	1.3%
17	Баянхонгор аймгийн ОБГ	4	2.6%
18	Өвөрхангай аймгийн ОБГ	9	5.9%
19	Дундговь аймгийн ОБГ	4	2.6%
20	Говьсүмбэр аймгийн ОБГ	5	3.3%
21	Дорноговь аймгийн ОБГ	9	5.9%
22	ДССЗТ-113 дугаар анги	5	3.3%

1-р хэсэг. Гамшигаас хамгаалах удирдлага

23	Үндэсний аврах бригад	3	2.0%
24	НОБГазар	13	8.6%
25	№3 Нөөцийн салбар	6	3.9%
26	Шатахууны нөөцийн салбар	1	0.7%
27	№179 Нөөцийн салбар	4	2.6%
НИЙТ		152	100%

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/334 дугаар тушаал “ОББ-ын инновацын дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор Гамшиг судлалын хүрээлэнгээс “Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны инновацийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллав. Энэ хүрээнд төв, орон нутгийн ОББ-ын 27 салбар, нэгжүүдээс 152 ажил ирүүлсэн байна.

Сүүлийн 2 жил дараалан ОББ-ын алба хаагчдын гаргасан шинэ санаа, бүтээлч ажлуудад дүн шинжилгээ хийж холбогдох заавар зөвлөмж өгч ажилласны үр дүнд бүтээлийн тоо 51 хувиар өссөн.

**2019 он: 75 шинэлэг санаа, бүтээлч ажил /15 салбар, нэгж, газар**

**37%**

**2020 он: 152 шинэлэг санаа, бүтээлч ажил /27 салбар, нэгж, газар/**

**75%**

*Зураг 26. 2019, 2020 онд ОББ-ын алба хаагчдын гаргасан шинэлэг санаа, бүтээлч ажлуудын харьцуулалт*

Эдгээрээс инновацын бүтээгдэхүүнийн шинж агуулсан, үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдсэн 115 ажлыг сонгон авч дүн шинжилгээ хийсэн. 2020 оны 2 дугаар зорилтын хүрээнд ОББ-ын салбар нэгжүүдийн алба хаагчдаас гаргасан шинэлэг санаа, бүтээлч ажлыг авч үзвэл нэвтрүүлсэн ажил 70%, өөрсдийн гараар ажлаа хялбаршуулж бүтээмжээ нэмэгдүүлсэн ажил 30 орчим хувийг эзэлж байна. Шинэлэг санаа бүтээлч ажилд дүн шинжилгээ хийж 4 багц, 11 үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр ангиллаа.

Хүснэгт 3. Төв, орон нутгийн ОББ-ын бүтээлч ажлын тоон үзүүлэлт

Үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх ажил	Тоон үзүүлэлтээр	Хувиар
Инновац, бүтээлч ажил	74	64%
Программ хангамж, шинэ технологийн боловсруулалт, нэвтрүүлэлт	1	1%
Санхүүжилттэйгээр хийгдсэн бүтээлч ажил	40	35%
Нийт	115	100%

Хүснэгт 4. Төв, орон нутгийн ОББ-ын бүтээлч ажлын тоон үзүүлэлт, задаргаа

Үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх ажил	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Тоон үзүүлэлт	Хувиар
Инновац, бүтээлч ажил	Шинээр хийсэн бүтээл	20	17.4%
	Программ хангамж нэвтрүүлсэн	3	2.6%
	Үйл ажиллагааг хялбаршуулах, бүтээмж нэмэгдүүлэх зорилгоор сайжруулалт хийсэн ажил	51	44.3%
Программ хангамж, шинэ технологийн	Ухаалаг технологид суурилсан зохион бүтээлт	1	0.9%
Санхүүжилт-тэйгээр хийгдсэн бүтээлч ажил	Улсын төсвийн санхүүжилтээр худалдан авч нэвтрүүлсэн	25	21.7%
	Төслийн хүрээнд худалдан авч үйл ажиллагаанд нэвтрүүлсэн	3	2.6%
	Тухайн байгууллагын санхүүжилтээр хийгдсэн бүтээлч ажил	5	4.3%
	Орон нутгийн санхүүжилтээр хийгдсэн бүтээлч ажил	4	3.5%
	Хандив тусламжаар хийгдсэн бүтээлч ажил	3	2.6%
Нийт		115	100%

Хүснэгтээс харахад инновацын шинж бүхий бүтээлч ажил 64%, программ хангамж, шинэ технологийн боловсруулалт, нэвтрүүлэлтийн ажил 1%, гадны болон дотоодын санхүүжилтээр хийгдсэн бүтээлч ажил 35%-ийг тус тус эзэлж байна.

Төв, орон нутгийн ОББ-ын бүтээлч ажлуудаас харахад шинээр санаачлан хийсэн бүтээл 20, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хялбаршуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сайжруулалт хийх зорилгоор 51 ажил гүйцэтгэсэн байна. Эдгээрээс зарим ажлыг онцлон дурьдая. Үүнд:

Архангай аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 51 дүгээр ангийн алба хаагчид санаачлан өдөр тутмын дасгал сургуулийг чанартай зохион байгуулах, алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, албаны бэлтгэл бэлэн байдлыг хангахад ашиглах цахилгаан болон механик ажиллагаатай шатыг хийж, одоо бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж байна.



Зураг 27. Цахилгаан болон механик ажиллагаатай шат

Баян-Өлгий аймгийн ОБГ-ын алба хаагчдын санаачлагаар хөдөлгөөнт удирдлагын байрыг цэргийн зориулалттай бүхээг бүхий ЗИЛ-130 маркийн автомашины чиргүүл ашиглан шинээр төхөөрөмжилж ор, сандал, эвхдэг ширээ, бичиг баримт хадгалах шүүгээ, хувцасны шкаф, зуух, угаалтуур, зурагт байрлуулан 12 В, 220 В-ын цахилгаан хэрэгсэл цэнэглэх оролт, чиргүүлийн доод хэсэгт түлээ болон бусад ахуйн зүйлс хийх тусгай хайрцгаар тоноглон байна.



Зураг 28. Бүхээгийн дотор болон гадна талын байдал

Дундговь аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх, сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн оролцоог дээшлүүлж тоглоомоор дамжуулан гамшгаас хамгаалах мэдлэг ойлголтыг хүргэх зорилгоор хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тулгуурлан монголын уламжлал, ёс заншил, Онцгой байдлын албаны үйл ажиллагааны онцлогийг тусган дараах тоглоомуудыг



санаачлан бүтээж үйл ажиллагаандаа ашиглаж байна.


Нийслэлийн аврах анги 105 нь Эрэн хайх, аврах 4 дүгээр бүлэг бэлэн байдлын



Зураг 29. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглаж буй тоглоомууд

аврах ажиллагааны олсыг өндрөөс аврах ажиллагаанд түргэн шуурхай, цаг хугацаа алдахгүйгээр зохион байгуулахад ашиглах зорилгоор аврах ажиллагааны үүргэвчийг шинээр хийсэн.


Орхон аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 58 дугаар ангийн хамт олон алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Nema ГОК 58” аппликейшныг бүтээсэн.



Зураг 30. “Nema ГОК 58” аппликейшн

*1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага*

Дархан-Уул аймгийн ОБГ-ын санаачлагаар “Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ДА-6, ДА-20 төхөөрөмж”-ийг хийж ажиллагаанд оруулан ашиглаж байна. Энэ бүтээлээрээ С.Равдангийн нэрэмжит Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний уралдаанд оролцсон.



Зураг 31. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ДА-6, ДА-20 төхөөрөмж

Уг бүтээл нь хэрэглээний хувьд ач холбогдол өндөртэй үнэлэгдсэн тул Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчид мөн адил ариутгалын терминал хийсэн.



Зураг 32. Терминал ариутгалын терминал төхөөрөмж



Зураг 33. Түймрийн хавирганы галыг унтраах зориулалт бүхий чирэгч дугуй

Завхан аймгийн Онцгой байдлын газар нь 4 ширхэг өлгүүр 2 ширхэг тень, халуун дамжуулах хоолой ашиглан хөдөлмөр хамгааллын хувцас хатаах зориулалт бүхий хатаагуур хийж ажилд бэлэн болгосон байна.



Зураг 34. Хөдөлмөр хамгааллын хувцас хатаах тоногдсон өлгүүр



Гамшиг судлалын хүрээлэнгийн Нөөцийн төв нь 5 бүсэд буудайн 15 сорт сорьж Улсын сорт сорилтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, **Алтайская-75** нь **нутагшсан сортоор** батлагдсан нь Монгол Улсын сүүлийн 30-аад жилд хийгдээгүй томоохон туршилт судалгаа боллоо.





Зураг 35. Ганд тэсвэртэй сорт турших үйл явц

Мөн тус хүрээлэнгээс санаачлан Асгарсан мөнгөн ус цуглуулах багаж угсарч амжилттай туршлаа. Уг багаж нь мөнгөн усны осол, асгарлын үеийн бэлтгэл бэлэн байдлыг нэмэгдүүлэх, мөнгөн усны хордолтоос хүн, мал, амьтан, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилготой хийгдсэн. Энэхүү бүтээлийг хийхэд Үндэсний аврах бригад дэмжлэг үзүүлж, хамтран угсарсан болно.



Зураг 36. Асгарсан мөнгөн ус цуглуулах иж бүрдэл

Онцгой байдлын алба хаагчдын санаачилсан эдгээр бүтээлүүдээс харахад ихэвчлэн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хийж санаачилсан байгаа нь тэдний ажлыг урамшуулах, дэмжих орчин бүрдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Иймээс Гамшиг судлалын хүрээлэнгээс Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангахаар төлөвлөн ажиллаж байна.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЭМЖИЙН ХӨТӨЛБӨР

/ОБЕГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/292 тоот тушаал /

### ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, инновацын мэдлэгийг сайжруулах, тэдгээрийг шинэ, шинэлэг санаа, дэвшилтэт арга, шийдлийг дэвшүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг дэмжих орчныг бүрдүүлж, байгууллагын ажлын бүтээмжийг дээшлүүлэх



Зураг 37. Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийн товч агуулга

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгууллагын алба хаагч, ажилчдын бүтээлч хандлага нэмэгдэж, шинэ, шинэлэг санаа, дэвшилтэт арга, шийдлийг инновац болгох таатай орчин бүрдэж улмаар байгууллагын ажлын бүтээмж дээшлэх боломж бүрдэнэ. Мөн Онцгой байдлын байгууллага бүхэлдээ MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотой стандартыг нутагшуулах хэвшүүлэхэд чухал үүрэгтэй.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ:**

**УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**





## БҮЛЭГ 2.1. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1.1. Монгол Улсын Шадар сайдын баталсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн удирдамжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2020 онд анх удаа сүүлийн 15 жилээр аюулт үзэгдэл, ослын тоон мэдээг гаргаж, Монгол Улсын гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний, өдөрлөгийг зохион байгуулах хуваарийг Монгол Улсын Шадар сайдаар батлуулан, хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

Хүснэгт 5. 2020 онд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн хуваарь

д/д	Нэгдсэн арга хэмжээний нэр		2020 он												
			1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	
1	Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Хамтран ажиллах байгууллага	■	■	■	■						■	■	■	
2	Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ				■	■	■								
3	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ							■	■	■					
4	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг				■										
5	Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг												■		
6	Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг				■										

2020 оны нэгдсэн арга хэмжээний удирдамжийг Монгол Улсын Шадар сайдаар батлуулснаар аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, төв, орон нутгийн Засаг дарга, төрийн байгууллага, албан тушаалтны оролцоо, уялдааг хангаж, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой ажил болсон. Мөн 2020 онд гарсан гал түймрийн тоо 2019 онтой харьцуулбал 30 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.

### 2.1.2. 2020 онд төв, орон нутгаас гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил



1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах цахим сургалтад 1.262.350 хүн хамрагдсан



4. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд эрсдэл бүхий 306 айл, өрхийг нүүлгэн шилжүүлсэн.



2. Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 1.5 сая иргэнд багц мессеэжээр сэрэмжлүүлэг хүргэсэн



5. Олон улсын иргэний хамгаалалтын өдөр "Өрх бүрт анхны тусламж үзүүлэгчтэй байх" цахим сургалт 150 удаа явуулахад 1848 хүн хамрагдсан.



3. Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 23 км далан цэвэрлэж 12600 кв талбайд ариутгал хийсэн.



6. Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр "Сайн засаглал буюу гамшгийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх" уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн.

Зураг 38. Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг

*2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага*

2020 онд Гамшгаас хамгаалах ангиллын сургалт явуулсан тоон үзүүлэлт бага зэрэг буурсан боловч үүнийг улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, нийтийг хамруулсан арга хэмжээг хязгаарласан цаг үед явагдсан гэж үзвэл харьцангуй сайн гэж дүгнэж болохоор байна.



*Зураг 39. Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагаас зохион байгуулсан гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт*



*Зураг 40. Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, ухуулга сурталчилгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт*

### 2.1.3. Дадлага сургалт:

#### **“КОВИД-19 халдварын цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” дадлага сургууль**

Монгол Улсын Засгийн газраас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт” /хэсэгчлэн/ шилжүүлсэн. 2020 онд “КОВИД-19 халдварт цар тахлын нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан “КОВИД-19 халдварын цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт үндэсний хэмжээний дадлага сургуулийг зохион байгуулсан.



*Зураг 41. “Ковид-19 халдварын цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулийн үеэр нийслэлийн Чингэлтэй дүүрэгт хатуу хөл хорио тогтоосон байдал*

Энэхүү дадлага, сургуулийг Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 33 дугаар тушаалаар 2020 оны 5 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд үндэсний хэмжээнд анх удаа “КОВИД-19 халдварын цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдвээр зохион байгуулсан. Уг дадлага сургуульд Улсын онцгой комисс, 21 аймаг, нийслэл, сум, дүүрэг, гамшгаас хамгаалах улсын албад, яам, агентлаг, Төрийн цэргийн байгууллага, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, Нэгдсэн үндэстний байгууллага, хүмүүнлэгийн байгууллага, хуулийн этгээд нийт 80 гаруй салбар нэгжийн 13794 удирдах албан тушаалтан, 153.000 иргэн хамрагдсан.

Мөн дадлага, сургуулийн хүрээнд нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвийг түшиглэн “Яармаг-100” эмнэлэг, Буянт-Ухаа спорт цогцолборыг түшиглэн “Яармаг-300” эмнэлэг, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төв-113 дугаар ангийг түшиглэн зөөврийн

## 2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага

Евро стандартын II шатлалын 60 ор бүхий хээрийн эмнэлгийг тус тус дэлгэж, нийслэлийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт хатуу хөл хорионы дэглэмийг өдрийн 8 цагийн хугацаанд тогтоох дадлага сургуулийг хийж бэлэн байдлыг хангуулж ажилласан.



Зураг 42. “Ковид-19 халдварын цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулийн үеэр “Яармаг-300” эмнэлгийг дэлгэсэн байдал

Тус дадлага, сургуулилтаар эрүүл мэндийн салбарын хүн, хүч, багаж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, халдварт өвчин тархаж, нөхцөл байдал хүндэрсэн үед иргэдээ эмчлэх нөөц бололцоог тооцоолж, туршсан ач холбогдолтой сургууль болсон.

### “Ослын үеийн удирдлагын систем” сургалт

Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас 2020 онд зохион байгуулсан томоохон, шинэлэг, цогц сургалт бол “Ослын үеийн удирдлагын систем” сургалт юм. Онцгой байдлын ерөнхий газраас АНУ-ын ойн албатай хамтран 2016 онд Монгол Улсад нэвтрүүлсэн уг сургалт нь Ослын удирдлагын системийг ашиглан гамшиг ослын үеийн удирдлагыг оновчтой зохион байгуулах боломжийг олгох зорилготой юм.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны хэлтэс, баг хамт олон 2020 онд дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

1. Цаг үеийн нөхцөл байдал “КОВИД-19” халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор Иргэний нисэхийн үндэсний төвийн удирдах бүрэлдэхүүнд “Ослын үеийн удирдлагын систем” анхан шатны сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалтад ИНҮТ-ийн удирдлага, ажилтнуудаас гадна 19 аймгийн нисэх буудал, ИНҮТ-ийн нэгж, авиа компанийн нийт 30 ажилтан хамрагдсан.

“Ослын үеийн удирдлагын систем” сургалтын агуулгад:

- Ямар ч хэмжээний, ямар ч төрлийн ослын хариу арга хэмжээний шаардлагад нийцэх;
- Төрөл бүрийн агентлагуудын ажилтнуудыг нэгдсэн удирдлагын бүтэц рүү богино хугацаанд оруулах боломжийг олгосон;
- Үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудад хангалт, захиргааны дэмжлэг үзүүлэх,
- Үйл ажиллагааны давхардлаас сэргийлэх замаар зардлыг



хэмнэх мэдлэг, дадлагыг нийт 93 удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчдад “Ослын үеийн удирдлагын систем”-ээр ажиллах сургалтыг олгосон байна.

2. Онцгой байдлын ерөнхий газар, Монгол Улаан загалмай нийгэмлэг хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2 байгууллагын удирдах бүрэлдэхүүнд “Ослын үеийн удирдлагын систем” анхан, дунд шатны сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд МУЗН-ийн “Хүүхэд залуучуудын төв”-д зохион байгуулсан. Уг сургалтад төв орон нутгийн Онцгой байдлын газар, нийслэлийн 9 дүүргийн Онцгой байдлын хэлтэс, дунд шатны Улаан загалмайн хороодын дарга нар нийт 45 хүн хамрагдан.

3. Мөн Монголын улаан загалмай нийгэмлэгийн Үндэсний нийгэмлэгийн гамшгийн хариу арга хэмжээ авах багийн гишүүдэд “Ослын үеийн удирдлагын систем” анхан шатны сургалтыг 2020 оны 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад нийт 18 хүн хамрагдсан.




Зураг 43. “Ослын үеийн удирдлагын систем” анхан, дунд шатны сургалт

### **-“Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулийн үеийн холбоо зохион байгуулалт**

Тоон болон сансрын олон сувгийн телевиз 800,000 гаруй хэрэглэгчийн дэлгэцийн нэвтрэх хуудаст дадлага сургуулийн талаарх мэдээллийг байршуулсан.

Үүрэн холбооны 4 оператор компани дадлага сургуулийн талаарх мэдээллийг 4 сая орчим хэрэглэгчдэд мессежээр хүргүүлсэн.

Онцгой байдлын ерөнхий газраас дадлага сургуулийн үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн Шуурхай штаб, аж ахуйн нэгж байгууллагын 100 хэрэглэгчдэд нэгэн зэрэг цахимаар шууд дамжуулах ажлыг анх удаа зохион байгуулсан.




Зураг 44. Дадлага сургуулийн үеийн холбоо зохион байгуулалт

### **Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх орон нутгийн шуурхай штабыг бэлтгэх сургалт**

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 89 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга нарын хамтран баталсан удирдамжийн хүрээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, орон нутгийн Онцгой комиссын шуурхай штабт зөвлөгөө өгөх, тохиолдлын удирдлагын багийг бий болгох, чадавхжуулах сургалтыг 2020 оны 08 дугаар сарын 21-нээс 11 дүгээр сарын 10-ны хооронд зохион байгуулсан. Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүтцээр Архангай, Баян-Өлгий, Ховд, Увс, Булган, Хөвсгөл, Орхон, Хэнтий, Дорнод, Сүхбаатар гэсэн нийт 10 аймгийн салбар хоорондын 905-н мэргэжилтэнг бэлтгэсэн байна.

#### **2.1.4. Цахим сургалт:**

Онцгой байдлын ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, даргын 2020 оны А/88 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтний цахим сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү сургалтын үеэр нийт 47 ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтний мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох шалгалтыг авч үнэлсэн юм.



Зураг 45. Аймаг, нийслэлийн онцгой байдлын газар, хэлтсийн ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтний цахим сургалт

### Шилдэг бүтээл, шинэлэг санаа

Онцгой байдлын ерөнхий газраас 2020 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төв, орон нутгийн Онцгой байдлын газрын ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн дунд “Шилдэг бүтээл, шинэлэг санаа” бүтээлийн уралдаан зарласан. Уралдаанд Дундговь, Дархан-Уул, Дорноговь, Завхан аймгуудын Онцгой байдлын газар, хэлтсүүдээс ирүүлсэн нийт 5 материалыг удирдамжинд заагдсан шаардлагын дагуу шалгаруулсан. Үүнд:



Зураг 46. Уралдаанд ирүүлсэн шилдэг бүтээлүүд



## 2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага

- Дундговь аймгийн Онцгой байдлын газраас ирүүлсэн “Бөмбөрдэйг авраарай” хөлөгт тоглоом, “Үлгэрээ өвлүүлье” үлгэрийн ном зэрэг бүтээлүүдээр **“Тэргүүн байр”**;
- Дархан-Уул, аймгийн Онцгой байдлын газраас ирүүлсэн “Бага насны хүүхдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг дуулах дуртай дуугаар нь дамжуулан хүргэх”, бүтээл **“Дэд байр”**;
- “Хүүхдүүдээ будаж сурцгаая” буддаг ном бүтээл нь **“Гутгаар байр”**-д тус тус шалгарсныг шагнаж урамшуулсан.

### 2.1.5 Онцгой байдлын албаны үйл ажиллагаа, алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлах

- Олон нийтийн суваг-2669
- Өдөр тутмын сонинд ярилцлага-580
- Сонинд мэдээлэл-1071
- Байгууллагын цахим хуудас-11741
- Орон нутгийн сувгуудаар урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл-38322 сэрэмжлүүлэг мэдээлэл бүх төрлөөр өссөн.



Зураг 47. Албаны үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж байгаа нь

Онцгой байдлын ерөнхий газраас 2020 онд дэлхий нийтэд коронавируст халдвар /КОВИД-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, шторк, цаг үеийн мэдээ, мэдээлэл, холбогдох албан тушаалтны ярилцлага, хандив тусламж үзүүлсэн иргэд, аж ахуйн нэгж байгууллага, асуудал дэвшүүлсэн нийтлэл, мэдээллийг түлхүү явуулж, олон нийтэд хүргэсэн.

Энэ хугацаанд объектын болон ой, хээрийн гал түймэр, газар хөдлөлт, хүүхдийн аюулгүй байдал, ахуйн осол, коронавируст халдвар, мөс цөмрөлт, шар усны үер, хүчтэй цасан шуурга, зам даваа хаагдах зэрэг цаг агаарын аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх нийт 2655 орчим удаагийн сэрэмжлүүлэг, мэдээ мэдээлэл, ярилцлагыг сонин, олон нийтийн телевизийн суваг, цахим хуудас зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэлээ.

Мөн байгууллагын цахим хуудас, фэйж хуудас, олон нийтийн телевизийн суваг, сонин, цахим хуудсуудад 120 гаруй удаагийн ярилцлага, нийтлэл, сурвалжлага, тодруулга мэдээллийг нэвтрүүлж, нийтлүүлэн олон нийтэд хүргэсэн байна.

## ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

Цаг үеийн асуудлаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор 45 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж ажилласан. Хэвлэлийн бага хуралд 20 гаруй олон нийтийн суваг, 10 орчим сонин, 30 гаруй цахим хуудас, нийтдээ 70 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэл сурвалжлан олон нийтэд хүргэсэн байна.



Зураг 48. Цаг үеийн асуудлаар зохион байгуулсан хэвлэлийн бага хурал

## "АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭ" АЯН

Улсын онцгой комиссын шийдвэрээр "Амны хаалтаа зүүцгээ" 1, 2 дугаар аяныг улс орон даяар зохион байгуулсантай холбогдуулан "Амны хаалтаа зүүцгээ" фэйсбүүк хуудаст тус аяныг зохион байгуулж, 69 мянган хүн нэгдсэн байна.



Зураг 49. "Амны хаалтаа зүүцгээ" аяныг фэйсбүүк хуудсаар дамжуулж зохион байгуулсан

## ЦАХИМ СУРТАЛЧИЛГАА

Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, төрийн бодлого, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг



## 2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага

хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор [www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn) цахим хуудас, “Онцгой байдлын ерөнхий газар” фэйсбүүк хуудас, [www.ontsgoisur.gov.mn](http://www.ontsgoisur.gov.mn) цахим хуудсыг тогтмол ажиллуулж байна.



Зураг 50. [nema.gov.mn](http://nema.gov.mn) цахим хуудсыг шинэчилсэн нь

Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд 2020 онд нийт 1800 гаруй удаагийн цаг үеийн мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, дүрстэй мэдээ, олон нийтийн сувгийн нэвтрүүлэг, шторкыг байршуулан ажилласан.

Үүнд мөс цөмрөлт, объектын гал түймэр, угаарын хийн хордлого, ахуйн осол, коронавируст халдвар, цаг агаарын аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторкыг давхардсан тоогоор 620 гаруй удаа байршуулан олон нийтэд түгээж, цахим хуудсанд өдөрт 3.000-8.000 хүн, сард 60.000-90.000 хүн, давхардсан тоогоор нийт 3.340.000 орчим хүн хандсан байна.

Байгууллагын цахим хуудсыг хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн нэгдсэн группт холбуулсан нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид Онцгой байдлын албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шууд, цаг алдалгүй шуурхай авах боломж бүрдсэн. Ингэснээр өдөрт тогтмол 30 гаруй мэдээллийн цахим хуудас, сонингоор дамжуулан Онцгой байдлын албатай холбоотой мэдээлэл иргэд, олон нийтэд хүрч байна.

Мөн Онцгой байдлын байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагуудын төвлөрсөн цахим хуудас болох [zasag.mn](http://zasag.mn) цахим хуудаатай холбож, мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна.


Цахим сургалтын [ontsgoisur.gov.mn](http://ontsgoisur.gov.mn) хуудасны 4W төлөвлөгөөнд Олон улсын байгууллагуудын төлөөллийг нэмж, нэвтрэх нэр, нууц үг нээж, ажиллах эрхийг олгосон. Мөн [ontsgoisur.gov.mn](http://ontsgoisur.gov.mn), [nema.gov.mn](http://nema.gov.mn) цахим хуудсуудын танилцуулгын загварыг гарган эх бэлтгэлийг хийсэн.



Зураг 51. neta.gov.mn цахим хуудасны мэдээ, мэдээлэл, хандалтын тоо

Коронавируст халдварт /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хандивын аянд нэгдсэн байгууллага, хамт олон, иргэдийн мэдээллийг хэвлэлийн мэдээллийн хэрэгсэл болон neta.gov.mn цахим хуудсаар дамжуулан тухай бүрт олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Мөн иргэдэд ил тод, нээлттэй мэдээллийг хүргэх зорилгоор neta.gov.mn цахим хуудсанд “Хандив тусламжийн нэгдсэн мэдээлэл” тусгай цэс үүсгэн, долоо хоногийн даваа, лхагва, баасан гараг бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.



Зураг 52. “Хандив тусламжийн нэгдсэн мэдээлэл” тусгай цэс

Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Онцгой комиссын Шуурхай штабаас хийж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар нэгдсэн мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор “УОК-ын Шуурхай штаб” пэйж хуудсыг шинээр нээж, цаг үеийн мэдээллийг тухай бүрт байршуулан ажиллуулснаар 47.294 дагагчтай, сард 100 000 орчим хүн хандаж, мэдээ, мэдээлэл авч байна.

### “ОНЦГОЙ БАЙДЛЫН ЦАГ” НЭВТРҮҮЛЭГ

МҮОНТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, иргэдэд болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг олгох, Онцгой байдлын

## 2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага

байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ажил, мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлан таниулахад чиглэгдсэн “Онцгой байдлын цаг” 15 минутын нэвтрүүлгийг “Аврагч” студидээ бэлтгэн, 14 хоног тутамд давталттайгаар МҮОНТ-ийн 1 дүгээр сувгаар бямба гарагийн 18:20 цагаас, 2 дугаар сувгаар даваа гарагийн 21:20 цагаас, мягмар гарагт “Өлзий ТВ”-ээр 18:40 цагаас тус тус тогтмол нэвтрүүлэн ажиллаж байна.

2020 онд нэвтрүүлгийн нийт 24 дугаар буюу 30 цагийн нэвтрүүлгийг бэлтгэн үзэгчдэд хүргэсэн.



Зураг 53. “Онцгой байдлын цаг” нэвтрүүлэг

## “ОНЦГОЙ МЭДЭЭ” СОНИН

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа болон төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын ажил, үйлсийг сурталчлах, тэргүүний шилдэг алба хаагчдыг алдаршуулах, байгууллага, хамт олны шинэ санаачлага, тэргүүн туршлагыг алба хаагчидтай хуваалцах, бусдад түгээх зорилгоор 2020 онд “Онцгой мэдээ” сонины нийт 24 дугаарыг эрхлэн гаргасан. Тус сонин 14 хоногт нэг удаа 12 нүүрээр хэвлэгдэж байгаа бөгөөд төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагын хэмжээнд тараагдаж алба хаагчдад хүрч байна. 2020 онд тус сонинд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтан, алба хаагчдын ярилцлага-72, орон нутгийн мэдээ-528, албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээ, нийтлэл, сурвалжлага-120 бэлтгэн хэвлүүлсэн.




Зураг 54. “Онцгой мэдээ” сонины мэдээллийн төрөл

## ХЭВЛЭХ ХЭСЭГТ

2020 онд Онцгой байдлын ерөнхий газрын томилолтын хуудас, амралтын хуудас, утасны жагсаалт, нэрийн хуудас, хавтас, сургалтын материал, сэрэмжлүүлэг брошур, сургалт, цугларалт, хурлуудын сертификат, урилга, хөтөлбөр, гарын авлага, ном, эмхэтгэл зэрэг нийт 68628 гаруй хэвлэлтийг бэлтгэн хэвлэсэн байна.

Тухайлбал, “Онцгой байдлын байгууллагын 2015-2020 оны ажлын тайлан” эмхэтгэл, ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын Хөгжмийн салбарын 15 жилийн ойн “Энхийн аялгуут он жилүүд”, Завхан аймгийн Онцгой байдлын газрын Тосонцэнгэл сум дахь Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 39 дүгээр ангийн 60 жилийн ойн “Нэгэн жарны дурсамж” ном, Онцгой байдлын байгуулагаас гаргаж буй “Манай генералууд” цувралд Хошууч генерал Г.Махбариадын “Ёслолын жагсаал, “номхон”, баярын маршаар...” дурсамж ном, “КОВИД-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний гарын авлага”, УОК-ын Шуурхай штабын үйл ажиллагааны эмхэтгэл “Коронавируст халдварын Монгол Улс дахь нөхцөл байдал, хариу арга хэмжээний 2020 оны эхний хагас жилийн тайлан мэдээ”, “Коронавируст халдварын Монгол Улс дахь нөхцөл байдал, хариу арга хэмжээний 2020 оны жилийн тайлан мэдээ” номуудыг бэлтгэн гаргалаа.



Зураг 55. Хэвлэх хэсгээс гаргасан бүтээлүүд



## 2.1.6. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагаа



Зураг 56. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн хуралдаан

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн ээлжит хуралдаан 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдаж, тус хурлаар газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцсэн бөгөөд 2020 онд эрхзүйн орчинг сайжруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, иргэд олон нийтийг дадлагажуулах зэрэг дөрвөн чиглэлд нийт 40 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

### **Монгол орны болон хил орчмын бүс нутгийн газар хөдлөлтийн чичирхийллийн нөхцөл байдал**

2020 оны 1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт нийтдээ 64765 газар хөдлөлт болоод байна. Эдгээр газар хөдлөлтүүдээс Монгол орны нутаг дэвсгэрт 44462 газар хөдлөлт, Монгол орны хил орчмын бүсэд 20303 газар хөдлөлт болсон байна. Газар хөдлөлтүүдийг хүчний хувьд ялган авч үзвэл:

- Магнитуд нь  $M < 1.0$  газар хөдлөлт 38537 удаа,
- Магнитуд нь  $1.0 \leq M \leq 1.9$  газар хөдлөлт 22983 удаа,
- Магнитуд нь  $2.0 \leq M \leq 2.9$  газар хөдлөлт 3059 удаа,
- Магнитуд нь  $3.0 \leq M \leq 3.9$  газар хөдлөлт 143 удаа,
- Магнитуд нь  $4.0 \leq M \leq 4.9$  газар хөдлөлт 38 удаа,
- Магнитуд нь  $5.0 \leq M \leq 5.9$  газар хөдлөлт 5 удаа тус тус болсон байна.



Монгол орны нутаг дэвсгэрт магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 64 удаа болсон байна. /Хавсралт 1/

**Улаанбаатар хот орчмын газар хөдлөлт:**

2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Улаанбаатар хот орчмын бүс нутагт нийт 1357 газар хөдлөлт болсон байна. Эдгээр газар хөдлөлтүүдийг хүчний хувьд ялган авч үзвэл:

- Магнитуд нь  $M < 1.0$  газар хөдлөлт 1026 удаа,
- Магнитуд нь  $1.0 \leq M \leq 1.9$  газар хөдлөлт 296 удаа,
- Магнитуд нь  $2.0 \leq M \leq 2.9$  газар хөдлөлт 29 удаа,
- Магнитуд нь  $3.0 \leq M \leq 3.9$  газар хөдлөлт 6 удаа болсон байна.

**Барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ:**

Монгол Улсын хэмжээнд 2020 онд нийт 1773 зураг төсөл боловсруулан магадлал хийж дүгнэлт гаргасан. Үүнээс инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил хийгдсэн Улаанбаатар хот болон 12 аймгийн /Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий/ хэмжээнд нийт 1241 барилга байгууламж, ерөнхий төлөвлөгөө, их засварын зураг төслийг боловсруулахдаа газар хөдлөлтийн бичил мужлалын зураг, инженер-геологи, гидрогеологийн судалгааг ашигласан.

Болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт гамшгийн үед түр цугларах 82 талбайн газрыг нэмж ИТХ-ын 2020 оны 17 дугаар тогтоолоор батлуулсан.

Говь-Алтай, Говьсүмбэр, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий аймгууд Ашиглалтын гэрчилгээг огт олгоогүй байгаа бөгөөд бусад 16 аймгийн хэмжээнд 2018 онд 45 ногоон, 2019 онд 231 ногоон, 2 улаан, 2020 онд 205 ногоон, нийт 483 гэрчилгээ олгоод байна.

Үүнээс нийтийн орон сууцны барилга байгууламжид нийт олгогдсон гэрчилгээний 50,7% буюу 248 гэрчилгээ олгогдсон байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн орон сууцны зориулалттай 238 барилгын ашиглалтыг хориглосон бөгөөд нийслэлийн Засаг даргын захирамжаар Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх дүүргийн 134 барилгыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулах тухай шийдвэр гарсан.

Захирамжийн хүрээнд 2016 онд 18 айлын орон сууцыг буулган 64 айлын 1, 2017 онд 20 айлын орон сууцыг буулган 237 айлын 2, 2018 онд 70 айлын 3 орон сууцыг буулган 152 айлын 1 орон сууцыг тус тус ашиглалтад оруулсан бөгөөд 2020 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 72 барилга угсралтын ажил хийгдэж байна.

Нийслэлийн газар хөдлөлтийн эрсдэл багатай бүсийн газар ашиглалтын судалгааг гаргаж тухайн бүсийн онцлогт нийцсэн барилга, байгууламж төлөвлөлтийг боловсруулсан. Хот байгуулалтын менежментийн нэгдсэн сангийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалыг үндэслэн архитектур төлөвлөлтийн даалгаварт газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм БНБД22.04.16-ийн дагуу барилга байгууламжийг төлөвлөж зураг төсөл боловсруулах шаардлага тавьж,

## *2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага*

загвар зургийг баталгаажуулж 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 820 байршилд барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар, 454 загвар зураг батлагдсан.

“Улаанбаатар хот, Налайх, Багануур, Багахангай дүүрэг, 12 аймгийн төвийн 1:10000 масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал”-ыг Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын <https://geoport-tal.nsd.gov.mn/gzbgzgzg/home/> геопорталаар дамжуулж хэрэглээнд нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулж, нийслэлийн Газрын алба, нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Гэр хорооллын дэд бүтцийн газар, аймаг, дүүргүүдийн газрын албаны холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан.

### **ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан, ашиглалтын шаардлага хангахгүй, дахин төлөвлөх шаардлагатай 22 барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлсэн.

Улсын нөөцийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2008 оны 30 дугаар тогтоол, 2010 оны 42 дугаар тогтоолын хэрэгжилтийг тус тус ханган Монгол Улсын Засгийн газрын 2018 оны м/н 364 дүгээр тогтоолоор баталсан нэр, төрөл, тоо хэмжээнд хүргэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгуулан нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Аймаг, нийслэлээс авсан судалгаагаар улсын хэмжээнд 4.5 мянган тн малын мах, 47.0 мянган тн гурил (үйлдвэрийн агуулахад байгаа улаанбуудайн нөөцийг гурилд шилжүүлсэн), 2.9 мянган тн гурилан бүтээгдэхүүн, 12.1 мянган тн бүх төрлийн будаа, 2.1 мянган тн хуурай сүү, 3.8 сая ширхэг өндөг, 4.7 мянган тн ургамлын тос, 2.2 мянган тн төмс, 1.3 мянган тн хүнсний ногоо, 9.8 мянган тн элсэн чихрийн нөөцийн үлдэгдэлтэй байна. Энэ судалгаанд Улаанбаатар хот, хөдөө орон нутгийн худалдааны зах, төв, дэлгүүрүүд, хүнсний үйлдвэрүүд дэх хүнсний нөөцийн үлдэгдлийг тооцсон. Харин нийслэл, орон нутгийн мухлаг, жижиг дэлгүүр, айл өрхийн хэрэгцээнд хадгалсан нөөц, мөн хөдөө орон нутгийн төмс, хүнсний ногооны жижиг зоорь, агуулахын нөөц ороогүй.

Улсын нөөцөд 2020 оны жилийн эцсийн байдлаар 10 нэр төрлийн хүнсний бараа, материалын бүрдүүлэлт 84.7%, шатахуун тосолгооны материалын бүрдүүлэлт 52.1%, үйлдвэр техникийн бараа, хүний эм багаж хэрэгслийн бүрдүүлэлт 70.2%-тай байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны м/н 364 дүгээр тогтоолоор 5 нэрийн хордлого тайлах эм, байгалийн голомтот болон олон улсын хөл хориот халдварт өвчний үед хэрэглэх эм, малын тарга хүч алдагдсан үед хэрэглэх зориулалттай 5 нэрийн эмийн биобэлдмэлийг эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хадгалалтын гэрээ байгуулан улсын нөөцөд хуримтлуулан хадгалж байгаа бөгөөд гамшиг

тохиолдсон үед шуурхай гаргахаар бэлэн байдалд хадгалж байна.

Цус цусан бүтээгдэхүүний өдөр тутмын, урт хугацааны, улсын нөөцийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж, нийт 24933 нэгж улаан эс, сийвэнгийн бүтээгдэхүүний нөөц бүрдүүлсэн. МУЗН, ЦССҮТ-тэй хамтран нийслэлийн 6 дүүрэгт явуулын цусны донорын сурталчилгааг явуулж, нийт 4804 хүн сайн дураар цус хандивлав.

Цус, цусан бүтээгдэхүүн, цус орлох шингэн, эм эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. Үүнд:

1. Туяагаар шарсан ялтас эсийн өтгөрүүлэг /бүхэл цус, цитоферез/;
2. Туяагаар шарсан даршилсан улаан эс;
3. Эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтас эсийн өтгөрүүлэг /бүхэл цус, цитоферез/;
4. Нэгтгэсэн крио зэрэг нэгтгэсэн ялтас эсийн өтгөрүүлэг зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, ЦЦБ-ний нөөцийг бүрдүүлсэн.

## **БҮЛЭГ 2.2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Япон Улсын Сендай хотод 2015 онд зохион байгуулагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурлаас НҮБ-ын гишүүн 187 улс “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030” тэргүүлэх чиглэлийг санал нэгтэй баталсан.

Монгол Улсын Засгийн газраас олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлж “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлуулан, 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

I үе шат: 2017-2020

II үе шат: 2021-2025

III үе шат: 2026-2030

Эхний үе шатанд төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийт, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлд суурилж амжилттай хэрэгжүүлж дууссан. Шадар сайдын 2018 оны 23 дугаар тушаалаар батлагдсан эхний үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 38 арга хэмжээ тусгасан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 94.5 хувийн биелэлтэй амжилттай хэрэгжиж дууссан. Тус дунд хугацааны стратегийн II үе шат 2021-2025 онд хэрэгжинэ.

Санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбоотой зарим арга хэмжээний хэрэгжилт дүүрэн хангалттай дүгнэгдээгүй байна.

2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага

Хүснэгт 6. Дунд хугацааны стратегийн I үе шатанд  
дууу хэрэгжилттэй байсан арга хэмжээ

№	Арга хэмжээ	Хувь	Хугацаа	Хариуцагч
1	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн орон сууц, зарим төрийн захиргааны барилга байгууламжид газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийх, дахин төлөвлөлтөд оруулах (1.2.3)	70	2018-2020	МХЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ
2	Барилга байгууламжийн хийц, бүтээц, материал, түүхий эдийн чанарыг тодорхойлж, туршилт, шинжилгээ, судалгаа гаргах нэгдсэн лаборатор байгуулах (3.1.1)	70	2018-2020	БХБЯ
3	Гамшгийн эрсдэлээс хамгаалах даатгал, давхар даатгалын тогтолцоог бий болгох нөхцөлийг бүрдүүлэх (3.2.3)	70	2018-2020	ОБЕГ, СЗХ
4	Төв суурин газрын хүн амыг үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд нэн шаардлагатай доплерийн радарын сүлжээг байгуулах (3.1.2)	40	2018-2020	Нийслэлийн ЗДТГ, БОАЖЯ
5	Газрын тос, хүнсний бүтээгдэхүүн хадгалах улсын нөөцийн агуулах, хүмүүнлэгийн тусламжийн бараа, материал, бүтээгдэхүүн хадгалах агуулахыг тус тус шинээр барих (4.2.3)	40	2018-2020	ОБЕГ

НУБ-Д ХҮРГҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН ТАЙЛАНГИЙН МЭДЭЭЛЭЛ

1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн явцын хяналтын тайлан: Зорилт А, В, С, Е

2. Тогтвортой хөгжлийн хөтөлбөр: Зорилго 1 (1.5), 11 (11.5, 11b), 13 (13.1)

Хүснэгт 7. Сендайн үйл ажиллагааны хүрээ


СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ							
Он		2015	2016	2017	2018	2019	2020
Зорилт А, В	100,000 хүнд оногдох гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй алга болсон, шууд нэрвэгдсэн хүний нэгдсэн тоо	1106.4	2811.5	274.3	363.3	281.8	0
	Зорилт А: Гамшгийн улмаас амь насаа алдсан болон сураггүй алга болсон хүний тоо 100,000 хүн тутамд	6.4	7.5	6.4	6.3	6.4	0
	Зорилт В: Гамшигт нэрвэгдсэн хүний тоо 100,000 хүн тутамд	1100	2804	267.9	357	275.4	0
Зорилт С	Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь (*Үндэсний Статистийн хороо)	0.5	0.3	0.4	0.3	0	0

Зорилт Е	Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигтэй уялдуулан батлан хэрэгжүүлж буй гамшгийн эрсдэлийг бууруулах стратегитэй улс, орны тоо, хувь	-	-	1 (100%)	1 (100%)	1 (100%)	1 (100%)
	Үндэсний стратегитэй уялдуулан батлан хэрэгжүүлж буй гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн стратегитэй засаг, захиргаадын тоо, хувь	-	-	6 (27.27%)	6 (27.27%)	6 (27.27%)	6 (27.27%)

### 2.2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал:

#### ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ


Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс 2019-2020 онд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг 2019 онд 10, 2020 онд 125, нийт 135 аж ахуйн нэгж, байгууллагад хийж гүйцэтгэсэн. Үүнээс орон нутагт 69, нийслэлд 65 хуулийн этгээдэд нарийвчилсан үнэлгээ хийсэн байна.



Зураг 58. Аймаг орон нутагт нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, үнэлгээний чиглэл (2019, 2020 он)



2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага



Зураг 59. Нийслэлд нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, үнэлгээний чиглэл (2019, 2020)

**Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн ерөнхий үнэлгээ хийж дууссан (индикаторын аргачлал).

- 2016 онд **8** хувь
- 2019 онд **71** хувь
- 2020 онд **100** хувьд хүрсэн



Зураг 60. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний нэгдсэн дүн: **ДУНД** эрсдэлийн түвшин (аймгаар)

**Зам тээврийн салбарт:** Зам тээврийн салбарын түвшинд олон улс, улсын чанартай авто болон төмөр замын үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг Зам тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэгтэй ОБЕГ-ын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар, Гамшгийн шуурхай удирдлагын газрын Орон зайн мэдээлэл, технологийн тасгийн алба хаагчид хамтран


хийж гүйцэтгэсэн.

Олон улс, улсын чанартай авто болон төмөр замд учирч болзошгүй үерийн гамшгийн аюул, түүнд өртөх магадлал, эмзэг байдал, үерийн аюулыг даван туулах чадавхыг газар орон, гол усны ай сав, хагалбарын байрлал, аюулт үзэгдэл, осол, хохирлын мэдээлэл, авто болон төмөр замын үерийн аюулыг тэсвэрлэх чадавхын мэдээлэлд үндэслэн авто болон төмөр замд учирч болзошгүй үерийн эрсдэлийн түвшинг тодорхойлсон.

Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг авто замын улсын чанартай **34 чиглэлийн 14951 км зам**, төмөр замын **гол, олон салаалсан 8 салбар** зам тус бүрийг замын гүүр, хоолой, хиймэл байгууламжийн хамт үнэлсэн. Замын чиглэл тус бүийн усанд автаж болзошгүй цэгүүдийн тоо, байрлалын координатыг тодорхойлж, зурагласан.

**Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний дүн:** Авто замын үерийн эрсдэлийн түвшин 34 чиглэлийн нэгдсэн дүнгээр эрсдэлийн түвшин: **ДУНД**

Төмөр замын үерийн эрсдэлийн түвшин гол, олон салаалсан 8 салбар чиглэлийн нэгдсэн дүнгээр эрсдэлийн түвшин: **ӨНДӨР**



Зураг 61. Арвайхээр-Баянхонгорын авто замын үерийн усанд автаж болзошгүй цэг, байрлал




Зураг 62. Үерийн усанд угаагдсан төмөр замын ул шороо (Төв аймаг, 2020 он)

**Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээний дүн:**

Цагийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, өвөлжилтийн бэлтгэл болон хүн эмнэлгийн бэлэн байдалтай газар дээр нь танилцах, гантай байсан аймгуудад гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэг Улсын онцгой комиссын даргын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар тушаалаар байгуулагдан Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Архангай, Булган аймагт зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн.

Үнэлгээний дүнгээр зуншлага муу байсан аймгууд зудын эрсдэлийн түвшин ӨНДӨР үнэлэгдсэн байна. Улаан өнгөөр өндөр, шар өнгөөр дунд эрсдэлийн түвшинг илэрхийлэв.



Зураг 63. Зудын эрсдэлийн түвшин (аймгаар)

**2.2.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа**

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээн авч дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Шадар Сайдын 2018 оны 45 дугаар тушаалаар батлуулсан.

Тус зөвлөлийн хуралдааныг нь 2019 оны 8 дугаар сарын 31-ний өдөр, 2020 онд хоёр удаа буюу 4 дүгээр сарын 16, 9 дүгээр сарын 09-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Хуралдааныг шийдвэрээр 2019-2020 онд нийт 26 хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон.



Зураг 64. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хуралдаан

### **2.2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа**

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн удирдлагад аймаг, нийслэл, дүүргийн 31 орон нутгийн зөвлөл үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний 80.6 хувь нь Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн зөвлөлөө 2020 онд шинэчлэн байгуулсан.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаанаар батлагдсан зөвлөмж /Хавсралт 2/-ийн хэрэгжилт 92.5 хувийн биелэлттэй. Биелэлт дутуу арга хэмжээнээс 2021 оны зөвлөмжид тусгасан.





**ГУРАВДУГААР ХЭСЭГ:**

**ГАМШГИЙН ШУУРХАЙ  
УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТ**



## БҮЛЭГ 3.1. ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 3.1.1. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тойм

Монгол Улсын хэмжээнд 2020 онд нийт 4006 удаагийн аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 248 хүн амь насаа алдаж, 1301 хүн гэмтэж бэртэн, 80,954 толгой мал, амьтан хорогдож, 31.3 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан.

Эдгээрийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд Онцгой байдлын алба хаагчид, Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Цагдаа, байгаль хамгаалагчид, иргэд оролцсон нийт 33,591 хүн, 6,657 автомашин ажиллаж, 2,239 хүний амь нас, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 114,4 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах ажилд 517,9 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын 79.3 хувь буюу 3178 нь гал түймэр, 2.4 хувь буюу 96 нь биологийн гаралтай аюулт үзэгдэл, 13.6 хувь буюу 546 нь хүний үйл ажиллагаатай холбоотой осол, 3.2 хувь буюу 127 нь ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл, 1.5 хувь буюу 59 нь геологийн гаралтай аюулт үзэгдэл байна.



Зураг 65. 2020 онд нийт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

Аюулт, үзэгдэл ослын улмаас учирсан нийт хохирлын 46.8 хувь буюу 14,6 тэрбум төгрөг нь гал түймрийн улмаас, 52.7 хувь буюу 16.5 тэрбум төгрөг нь ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн улмаас, 0.3 хувь буюу 120.6 сая төгрөг нь биологийн гаралтай аюулт, үзэгдэл ослын улмаас, 0.03 хувь буюу 9.5 сая төгрөг нь учирсан байна.



Зураг 66. 2020 онд аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирлын эзлэх хувь, гамшгийн төрлөөр

### 3-р хэсэг. Гамшгийн шуурхай удирдлага, зохицуулалт

Аюулт, үзэгдэл ослын улмаас нас барсан иргэдийн ослын шалтгаанаар нь авч үзвэл 48.8 хувь буюу 121 хүн усны ослын улмаас, 31 хувь буюу 77 хүн объектын гал түймрийн улмаас, 1.2 хувь буюу 3 хүн хүчтэй салхи шуурганы улмаас, 3.6 хувь буюу 9 хүн аадар бороо, үерийн улмаас, 1.2 хувь буюу 3 хүн тарваган тахлын улмаас 0.8 хувь буюу 2 хүн тэсрэлт, дэлбэрэлтийн ослын улмаас, 0.8 хувь буюу 2 хүн уул, уурхайн ослын улмаас, 0.4 хувь буюу 1 хүн аянганы улмаас, 12 хувь буюу 30 хүн амь бусад төрлийн ослын улмаас амь насаа алдсан байна.



Зураг 67. 2020 онд аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

## УС, ЦАГ АГААРЫН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ

### Аадар бороо, үер

Арван найман аймаг, Нийслэлийн 46 сум, дүүргийн нутаг дэвсгэр хамарсан 64 удаагийн аадар бороо орж, үер болсны улмаас 9 хүн амь насаа алдаж, 8898 толгой мал хорогдож, 632 гэр, байшин урсан эвдэрч, 26 хүний амь насыг авран хамгаалсан. Үерийн голомтод 1220 албан хаагч, 240 автомашин техник ажилласан. 76.5 сая төгрөгийн хохирол учирсан.

### Аянга

Арван аймгийн 9 сумын нутаг дэвсгэрт 9 удаа аянга буусны улмаас 1 хүн түлэгдэж, 1 хүн амь насаа алдаж, 811 толгой мал хорогдож, 25.6 сая төгрөгийн хохирол учирсан байна.

### Хүчтэй салхи шуурга

Арван хоёр аймаг, Нийслэлийн 37 сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан 51 удаагийн хүчтэй салхи, шуурганы улмаас 3 хүн амь насаа

алдаж, 86 гэр, байшин нурж эвдрэн 198.4 сая төгрөгийн хохирол учирсан байна. Шуурганд төөрсөн хүмүүсийг эрэн хайх ажиллагаанд Онцгой байдлын байгууллага, орон нутгийн иргэд нийт 319 хүн, 76 автомашин техник ажилласан.

## ГЕОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ

### Газар хөдлөлт


Монгол Улсын 17 аймгийн 37 сумын нутагт 3.5 магнитудаас дээш хүчтэй газар хөдлөлтийн 59 тохиолдол мэдрэгдсэн. Үүний улмаас ямар нэгэн хохирол учраагүй байна.

## БИОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ

Нийт 96 удаа гарч, 3 хүн амь насаа алдаж, 80954 толгой мал хорогдсон. Хорогдсон мал, амьтдыг булж устган, ариутгал халдваргүйжүүлэлт хийж урьдчилан сэргийлэх зорилгоор 2 сая толгой малыг вакцинжуулахад нийт 801 хүн, 215 техник ажилласан байна.

## ХҮНИЙ БУРУУТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ОСОЛ

Нийт 546 удаа тохиолдож, 155 хүн амь насаа алдаж, 321 хүний амь насыг авран хамгаалж, 31 хүн гэмтэж бэртсэн. Ослын голомтод Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, орон нутгаас нийт 4571 хүн, 948 автомашин техниктэйгээр ажилласан.



Зураг 68. Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо, учирсан хохирлын хэмжээг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

### Аюулт үзэгдэл, ослын тоо

2020 онд тохилдсон аюулт үзэгдэл, ослыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гамшиг, аюулт үзэгдэл, ослоос аварсан хүний тоо 307 /16 дахин/, эд хөрөнгө 51,2 тэрбум төгрөг /1,8 хувь/-өөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3-р хэсэг. Гамигийн шуурхай удирдлага, зохицуулалт



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 307 буюу **1.1 дахин өссөн**




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 307 буюу **1.1 дахин өссөн**



Гэмтсэн хүний тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1148 буюу **8.5 дахин өссөн**



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 307 буюу **1.1 дахин өссөн**




Зураг 69. Нас баралтын төрөл өмнөх оны мөн үетэй харьцуулалт



Монгол Улсын гамшгаас хамгаалах Цагаан ном 2020

2020 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас баралтын 48,8 хувийг усны осол эзэлж байгаа бөгөөд 31 хувийг объектын гал түймэр эзэлж байна.



Зураг 70. 2020 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүн /аймаг нийслэлээр/

Аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүний тоогоор 1-рт Нийслэл, 2-рт Төв аймаг, 3-рт Хөвсгөл аймаг орж байгаа боловч тухайн орон нутгийн 100000 хүнд ногдох нас баралтын графикаар 1-рт Говьсүмбэр аймаг, 2-рт Төв аймаг, 3-рт Хэнтий аймаг орж байна.

Хүснэгт 8. Аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүний тоо /өсөлт, бууралт/

№	Аюулт үзэгдэл, осол	Нас барсан нийт хүн		Өсөлт, бууралт / тоогоор/
		2019	2020	
1	Хүчтэй салхи, шуурга	9	3	▼ 6
2	Үер	6	9	▲ 3
3	Аянга	1	1	-
4	Тарваган тахал	2	3	▲ 1
5	Усны осол	82	121	▲ 39
6	Объектын гал түймэр	54	77	▲ 23
7	Уурхайн осол	14	2	▼ 12
8	Тэсрэлт, дэлбэрэлтийн осол	1	2	▲ 1
9	Бусад осол	34	30	▼ 4
<b>НИЙТ</b>		<b>203</b>	<b>248</b>	<b>▲ 45</b>

### 3-р хэсэг. Гамшигийн шуурхай удирдлага, зохицуулалт

Нэрвэгдсэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрлийн 48,8 хувийг усны осол, 31 хувийг объектын гал түймэр эзэлж байна.

#### 3.1.2. Монгол оронд тохиолдсон зарим томоохон аюулт үзэгдэл, ослын тойм:

##### Тарваган тахал өвчин:

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Төгрөгийн эх багийн нутагт 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдөр тарваган тахал өвчнөөр өвчилж /1 иргэн/ нас барсан. Тус сумын орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлаж, хорио цээрийн дэглэм тогтоож, хяналтын 8 цэг, цогцос байгаа газрыг хамгаалалтад авч, хяналтын 1 цэг байгуулан, Онцгой байдлын газрын газраас 6 алба хаагч, 1 автомашин, Эрүүл мэндийн газрын 3 мэргэжилтэн 1 автомашин, Зоонозын өвчин судлалын төвийн 9 мэргэжилтэн 2 автомашин, Цагдаагийн газраас 6 алба хаагч 1 автомашинтай ажилласан.

Ховд аймгийн Буянт суманд 2020 оны 08 дугаар сарын 13-ний өдөр тарваган тахал өвчний шинж тэмдэгтэй /1 иргэн/ нас барсан. Тус сумын орох гарах хөдөлгөөнийг хязгаарлаж хорио цээрийн дэглэм тогтоон, хяналтын 4 цэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2 цэг, 1-р хавьталын 92 иргэнийг тусгаарлалтанд авч хяналтын 8 цэг, нийт 14 хяналтын цэгт Онцгой байдлын газрын 15 алба хаагч, 5 техник хэрэгсэл, Цагдаагийн газрын 21 алба хаагч, 6 техник хэрэгсэл, нийт 36 алба хаагч 11 техник хэрэгсэл үүрэг гүйцэтгэн ажилласан.

Завхан аймгийн Тосонцэнгэл суманд 2020 оны 09 сарын 03-ны өдөр тарваган тахал өвчнөөр өвчилж 09 дүгээр сарын 07-ны өдөр нас барсан. Тус сумын орох гарах хөдөлгөөнийг хязгаарлаж хорио цээрийн дэглэм тогтоон, 1-р хавьтагч 27 иргэнийг тусгаарлан, 2-р хавьтагч 561 иргэнийг судалгаа гарган бүртгэлжүүлж Онцгой байдлын албанаас-6, Цагдаагийн хэлтсээс-8, нэгдсэн эмнэлэгээс-3, Зоонозоос-7, Засаг даргын тамгын газраас-6, нийт-30 хүн, 5 техник хэрэгсэлтэй ажилласан.

Дээрх аймгуудад тус бүр 1 хүн, нийт хүн 3 нас барсан нийт 290 хүн, 33 техник хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэн ажилласан байна.



Зураг 71.  
Говь-Алтай,  
Ховд, Завхан  
аймагт гарсан  
тарваган  
тахал өвчний  
үед хорио  
цээрийн  
дэглэм  
тогтоож,  
ариутгал  
устгал хийж  
ажилласан  
байдал

### Уул уурхайн осол

Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгоны 7 дугаар багийн “Ангал” гэдэг газар (сумын төвөөс 3 км зайтай) “Идэрмэг-Өсөх” нөхөрлөлийн жонш олборлодог далд уурхайд гарсан ослын улмаас нурангад дарагдсан 1 иргэн, нас барсан 1 иргэнийг эрэн хайх ажиллагааг зохион байгуулсан.

2020 оны 08 дугаар сарын 16-ны өдөр 30.4 м<sup>3</sup> уулын цул зөөж зайлуулан, 92.2 метр урттай уулын малталтыг хийж (19 настай эрэгтэй)-ийг эсэн мэнд гарган сум дундын эмнэлэгт шилжүүлэн өгсөн.

8 дугаар сарын 17-ны өдөр 9 м<sup>3</sup> уулын цул зөөж зайлуулан, 3 метр урттай уулын малталт хийж /1 иргэн/-ий цогцсыг гаргасан.

Ослын голомтод Онцгой байдлын ерөнхий газрын 1 алба хаагч, Үндэсний аврах бригадын Уул уурхайн аврах ангийн 14 алба хаагч, Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын 17 алба хаагч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 4 албан хаагч, Цагдаагийн газрын 9 алба хаагч, Мэргэжлийн хяналтын байгууллагын 2 албан хаагч, нутгийн захиргааны байгууллагын 4 ажилтан, сумын Өрхийн эрүүл мэндийн төвийн 4 ажилтан, “Идэрмэг-Өсөх” нөхөрлөлийн 10 ажилчин, нийт 55 хүн, 14 техник хэрэгсэлтэйгээр нийт 75 цаг үүрэг гүйцэтгэсэн.



Зураг 72. Хэнтий аймгийн Батноров сумын “Идэрмэг-Өсөх” нөхөрлөлийн жонш олборлодог далд уурхайд гарсан осол

### Зам тээврийн осол /гал түймэр/

Архангай аймаг Эрдэнэбулган сумын “Цагаан даваа”-нд 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдөр “Петровис” ХХК-ийн Норд бенз Донгпэнг маркын 93-80 УНП улсын дугаартай шатахуун тээвэрлэх автомашин Цагаан даваа уруудаад зам тээврийн осол гарч шатах тослох материал их хэмжээгээр асгарч гал түймэр гарсан. Замын эсрэг урсгалд зорчиж явсан Alion, Sanato-7, Subaru-Forester, Alphard маркын суудлын автомашин нийт 4 автомашин, мустанг-5 маркын 1 мотоцикл тус тус шатсан. Улаанбаатар-Завхан чиглэлийн улсын чанартай автозамыг түр хугацаанд хааж асгарсан шатахууныг саармагжуулж үлдсэн 4 тонн шатахуунийг Шунхлай ШТС-ийн ISUZU-авто цистерн шилжүүлж аюулгүй болгосон.

Ослын улмаас 14 хүн нас барж, 2 хүн гэмтэж бэртсэн. Уг аврах ажиллагаанд нийт 54 алба хаагч, 13 техник хэрэгсэл, МИ-171 маркийн 1 нисдэг тэрэг ажилласан.




Зураг 73. "Цагаан даваа"-ны гал түймрийн осол

### Үерийн гамшиг

Архангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Өмнөговь, Төв, Увс, Хөвсгөл Хэнтий аймаг болон нийслэлд 2020 оны 6, 7 дугаар сард орсон их хэмжээний аадар, борооны улмаас 4 удаагийн томоохон үерийн нөхцөл байдал үүссэн.

Үерийн улмаас 9 иргэн (2 хүүхэд) амь насаа алдаж, 7200 гаруй толгой мал хорогдож, 2400 гаруй айл өрх, 100 гаруй барилга байшин үерт автаж, 64 айлын гэр үерт урссан, Улаанбаатар-Хөшигийн хөндий чиглэлийн хурдны авто зам, Улаанбаатар-Чойр, Зуунмод-Мандалговь, Зуунмод-Налайх, Мөрөн сумаас Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон, Мөрөн-Улиастай, Элсэн тасархай-Хархорин чиглэлийн автозам, Улаангом сумын "Гашууны гол"-ын түр гүүр, Түргэн сумын "Түргэн" голын 54 метр бетон гүүр, Бага Түргэний 186 метр төмөр бетон гүүр, Улаанбаатар-Сайншанд чиглэлийн төмөр замын 554-585 дахь км-т 8 хэсэг газар 2.8 км төмөр зам эвдэрсэн.

Нийслэлд 6 байршилд үерийн хамгаалалтын байгууламжид эвдрэл үүсч, 7.3 км явган хүний зам, 13.1 км авто зам эвдэрсэн. Ойролцоогоор 19.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь ДНБ-ний 0.31 хувийг эзэлж байна. Мөрөн-Хатгал, Мөрөн-Улиастай чиглэлийн авто замд гарсан эвдрэлийг засварлахаар "Хөвсгөл-А33А" ТӨХК-ийн 30 ажилтан 10 нэгж техниктэй ажиллаж, автозамын хажуугийн лаг шаврыг цэвэрлэн, 2 км урттай түр зам, 4 метр өргөн, 3 метр өндөр, 50 метр урттай шороон далан шинээр байгуулж, 70 м үерийн шуудуу татаж, түр зам гарган, 333-оос 337 дэх км-т замын зорчих хэсэг дээрх шороо, чулууг цэвэрлэсэн.








Зураг 74. Үерийн аюулаас үүссэн нөхцөл байдал

### Цаг агаарын төлөв байдал

Агаарын дундаж температур ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим, төв болон говийн аймгуудын нутгаар дунджаас 1.1-4.9 градусаар дулаан, агаарын температур өдөртөө 30 градусыг давж ихэнх нутгаар 11-30 хоног, говийн аймгуудын нутгаар 31-66 хоног халсан байна.




Зураг 75. 2020 оны зуны агаарын дундаж температурын хазайлт




### 3-р хэсэг. Гамшгийн шуурхай удирдлага, зохицуулалт

Нийт нутгийн 70 гаруй хувьд дунджийн орчим буюу түүнээс ахиу, 30 орчим хувьд буюу Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгийн нутгаар дунджаас бага тунадас орсон байна.




Зураг 76. 2020 оны зун орсон хур тунадасны хазайлт

32.5% - 50 хүртэлх хувь	(бэлчээрийн нөөцтэй)
18.1% - 51-100 хувь	(бэлчээр хүрэлцээтэй)
25.0% - 101-300 хувь	(даац 1-3 дахин хэтэрсэн)
6.1% - 301-500 хувь	(даац 3-5 дахин хэтэрсэн)
18.3% - 500 хувиас их	(даац олон дахин хэтэрсэн)



Зураг 77. 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даац, % /багийн нутгаар/



Зураг 78. Зудын эрсдэлийн зураг /2020.12.10-ны өдрийн байдлаар/

Нийт нутгийн 60 гаруй хувьд их (нэн их 16.5 хувь, их 50.4 хувь), 20 шахам хувьд нь (18.5%) дунд зэрэг эрсдэлтэй гарсан.

Үүнд Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгийн ихэнх, Төв аймгийн баруун урд хэсгээр зудын эрсдэл “нэн их” гарсан байна.

## БҮЛЭГ 3.2. ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 3.2.1. Объектын гал түймэр

Улсын хэмжээнд 2020 онд 3036 удаагийн объектын гал түймрийн дуудлага мэдээлэл ирснээс Гал түймэр унтраах, аврах анги хүрэлцэн очиж унтраасан 1701, иргэд унтраасан буюу бага хэмжээний гал түймрийн зөрчил 1132, мэдээлэл 203 удаа бүртгэгдсэн. Объектын гал түймрээс 1888 хүний амь нас, 114 тэрбум 295 сая төгрөгийн өмч хөрөнгийг аварч, гал түймэрт 75 иргэн /үүнээс том хүн 53, хүүхэд 22/ өртөж нас барж, 39 иргэн /үүнээс том хүн 36, хүүхэд 2/ түлэгдэж, гэмтсэн аж ахуйн нэгж, иргэний 114 тэрбум 235 сая төгрөгийн хохирол учирсан байна.



↓ **28.0% буурсан**


Зураг 79. Гал түймэрийн нөхцөл байдал

3-р хэсэг. Гамигийн шуурхай удирдлага, зохицуулалт

Улсын хэмжээнд гал түймрийн дуудлага мэдээллийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28.0 хувиар буурсан байна.

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд гал түймрийн дуудлага мэдээллийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36,7 хувиар буурсан байна.

	2019	2020	Харьцуулалт
Архангай	53	44	-17
Баян-Өлгий	56	45	-19.7
Баянхонгор	115	67	-41.8
Булган	31	36	14
Говь-Алтай	71	31	-57
Говьсүмбэр	39	36	-7.7
Дархан-Уул	141	134	-5
Дорноговь	23	57	59.6
Дорнод	72	64	-12
Дундговь	25	36	30
Завхан	47	54	13
Орхон	88	83	-6
Өвөрхангай	59	56	-6
Өмнөговь	51	52	2
Сүхбаатар	39	41	5
Сэлэнгэ	119	115	-4
Төв	42	42	0
Увс	102	85	-17
Ховд	88	56	-37
Хөвсгөл	81	86	6
Хэнтий	58	39	-33
Улаанбаатар	2809	1777	-36.7



Зураг 80. Гал түймэрийн нөхцөл байдал /аймаг, нийслэлээр/


### 3.2.2. Ой, хээрийн гал түймэр

Улсын хэмжээнд 2020 онд ой, хээрийн гал түймэр Улаанбаатар хот, Архангай, Булган, Говьсүмбэр, Завхан, Дорнод, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Төв, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Увс зэрэг 15 аймгийн 74 суманд нийт 142 удаагийн ой, хээрийн түймэр гарч, урьдчилсан байдлаар 9549.3 га ой, 235.762 га хээр, нийт 245.311 га талбай, 2 гэр, 4 айлын өвөлжөө, 2 автомашин түймэрт өртөж, экологийн хохирол 3 тэрбум, эд материал 41.1 сая, түймрийг унтраахад 145.4 сая төгрөг зарцуулж, нийт 3.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Улсын хэмжээнд ой, хээрийн гал түймрийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.2 хувиар өсөж, түймрийн улмаас учирсан хохирол 86.5 хувиар буурсан байна.

Ой, хээрийн түймэр унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагаас 2055 алба хаагч, 217 автомашин, Хил хамгаалах байгууллагаас 314 алба хаагч, Цагдаагийн байгууллагаас 73 алба хаагч, 73 автомашин, Орон нутгаас 4493 иргэн, 695 автомашин, 305 мотоцикл, 77 морь, нийт 6935 хүн, 1217 техник, Зэвсэгт хүчний 303 дугаар ангиас МИ-171 нисдэг тэрэг 2 удаа гарч хамтран ажилласан байна.

Монгол Улсын хилийн 833 дугаар тэмдэгтээр 2, 834, 836 дугаар тэмдэгтээр тус бүр 1 удаа, нийт 4 удаагийн хээрийн түймэр Оросын Холбооны Улсаас хил даван орж ирж 3933 га хээрийн талбай шатаж, Монгол Улсын хилийн 817 дугаар тэмдэгтээр 1 удаагийн хээрийн түймэр БНХАУ-ын хил, 837 дугаар тэмдэгтээр 1 удаагийн хээрийн ОХУ-ын хил давж, нийт 2 удаагийн хээрийн түймэр хил давж гарсан байна.



Зураг 81. Ой, хээрийн гал түймэрийн нөхцөл байдал

### 3.2.3. Урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын талаар


2020 онд Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн баталсан удирдамжийн хүрээнд 285.224 барилга байгууламжийг хамруулан хяналт шалгалтыг хийж, 106.093 зөрчил дутагдлыг илрүүлж, 54.535 зөрчлийг арилгуулан зөрчил дутагдлаа арилгаагүй 249



### 3-р хэсэг. Гамигийн шуурхай удирдлага, зохицуулалт


хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 302.6 сая төгрөгний шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан байна.

Хяналт шалгалтыг өнгөрсөн онтой харьцуулахад хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил 5.4 хувь, арилгуулсан зөрчил 3.9 хувь, шийтгэлийн арга хэмжээ буюу торгуулийн хэмжээ 18.4 хувиар тус тус өсөж, шалгасан барилга байгууламжийн тоо 19.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Зураг 82. Гал түймрийн улсын хяналт

2020 онд шинээр баригдах 847 барилга байгууламжийн зураг төсөлд хяналт хийж зөвшилцөн дүгнэлт гаргаж, 54.540.200 төгрөгийг Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд төвлөрүүлж, 1188 барилга байгууламжийг хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт-3580, Танилцуулга-377, Дүгнэлт-622, Үйл ажиллагаа зогсоох тухай саналыг прокурорт хүргүүлж прокурорын тогтоол-19, Мэдэгдэл-5341, Заавал билүүлэх албан шаардлага-5714, Шинжээчийн дүгнэлт-925, Зөрчлийн тэмдэглэл-2130, Гал түймэр гарсан тухай акт-707, Гал түймэр унтраасан нотлом-2490-ыг тус тус үйлдэж холбогдох хуулийн этгээд, иргэнд хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан.



Зураг 83. Гал түймрийн хяналт, шалгалтын хэрэгжилт



Зураг 84. Гал түймрийн шалтгаан

**ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ:**

**ХОР УРШГИЙГ  
АРИЛГАХ,  
СЭРГЭЭН БОСГОХ  
АЖИЛЛАГАА**



## **БҮЛЭГ 4.1. УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ**

Дэлхий дахинд тархаад буй шинэ коронавирус /COVID-19/-ийн халдварт цар тахлын нөхцөл байдал, түүний эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, сургамж, урьдчилан сэргийлэх, дэмжих үйл ажиллагаанд үзүүлж буй хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, түүний эрх зүйн орчинд тулгарч буй хүндрэл бэрхшээлд тулгуурлан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ыг 6 бүлэг, 25 зүйлтэйгээр шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 133 дугаар тогтоолыг батлуулсан.

Коронавируст халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд Улсын Онцгой комисст хандив, тусламжаар төвлөрсөн мөнгөн хөрөнгийг зарцуулахтай холбогдуулан “Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах түр журам”-ыг 7 бүлэг 22 зүйлтэйгээр боловсруулж, Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр батлуулан эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

### **4.1.1. Улсын нөөцийн бараа, материал**

Коронавирусийн халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, 2020-2021 оны өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан зарим аймаг, сумдын малчин иргэдэд төрийн болон албаны үйлчилгээг шуурхай үзүүлэх, эмнэлэгийн тусламжийг цаг алдалгүй хүргэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Хөрөнгө гаргах тухай” 6 удаагийн тогтоол, улсын нөөцийн бараа, материалын бүрдүүлэлт, технологийн дагуу хадгалах хамгаалах, агуулахын бэлэн байдлыг хангаж гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чиглэлээр Монгол Улсын Шадар сайдын 34 удаагийн, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 23 удаагийн тушаал, шийдвэрийг батлуулан төв, орон нутаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн 4 анги, 20 салбар, 41 цэгээр дамжуулан нийт 11,5 тэрбум төгрөгийн бараа, материал олгосон байна. Үүнд:

**1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Гамшгийн хохирлыг барагдуулах зарим арга хэмжээний тухай” 85 дугаар тогтоолоор:**

- Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн Архангай, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Завхан, Өмнөговь, Хэнтий, Хөвсгөл, Увс аймгуудад улсын нөөцөөс буцалтгүй тусламж хэлбэрээр 4440 тонн өвс, үнийг нь 50 хувь хямдруулан 3775 тонн тэжээл нийт 2,6 тэрбум төгрөгийн;

- Төрийн үйлчилгээг ард иргэдэд шуурхай хүргэх зорилгоор Ховд аймгийн Цагдаагийн газар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, Хэнтий аймгийн Батноров, Жаргалтхаан сумын Засаг даргын Тамгын газар, Баян-Адарга сумын Эрэн хайх, аврах бүлэг, Архангай, Говьсүмбэр, Сүхбаатар, Завхан, Хэнтий аймгийн Онцгой байдлын газар, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Онцгой байдлын хэлтэс, Увс аймгийн Баруунтуруун сумын Гал унтраах аврах анги, Хэнтий аймгийн Цагдаагийн газар, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газар, Завхан аймгийн Тэлмэн сумын Засаг даргын Тамгын газарт болон Улаанбаатар хот дахь Хүнсний нөөцийн салбар, Үндэсний аврах бригадэд улсын нөөцөөс нийт 720 сая



#### **4-р хэсэг. Хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаа**

төгрөгийн 20 автомашин;

- Гал түймэр, гамшгийн улмаас орон гэргүй болсон 17 өрхөд улсын нөөцөөс 59,5 сая төгрөгийн 17 ширхэг иж бүрэн гэр;

- Дорнод аймгийн Онцгой байдлын газарт 15 сая төгрөгийн 1 ширхэг усны моторт завь;

- БОАЖЯ, Хэнтий аймгийн Онцгой байдлын газарт 4 сая төгрөгийн 40 хос хөдөлмөр хамгааллын хувцас;

- Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газарт 65 сая төгрөгийн бохирын автомашин;

- Төв, орон нутгийн Онцгой байдлын газруудад 31,6 сая төгрөгийн ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг тус тус олгосон.

#### **2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” 139 дугаар тогтоолоор:**

- Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дорноговь, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүрэгт орсон хүчтэй аадар бороо, шороон шуурга, гал түймрийн улмаас орон гэргүй болсон иргэдэд улсын нөөцөөс 196 сая төгрөгийн 56 ширхэг иж бүрэн гэр;

- Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлын хангах зорилгоор Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын Цэнгэл сум дахь Гал түймэр унтраах, аврах 71 дүгээр анги, Дорнод аймгийн Баян-Уул сум дахь Гал түймэр унтраах, аврах 53 дугаар анги, Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар, Хэнтий аймгийн Онцгой байдлын газарт нийт 143,8 сая төгрөгийн 5 усны моторт завь, 6 мотопомп;

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор ОБЕГ-ын Үндэсний аврах бригад, Нийслэлийн онцгой байдлын газар, Баянхонгор, Хэнтий аймгийн Онцгой байдлын газрууд Ховд аймгийн ЗДТГазарт 2 тн, 5 тн-ын багтаамжтай ариутгал, халдваргүйтгэлийн 4 машин, 10 тн-ын багтаамжтай ус зөөврийн 2 машин, 5 тн-ын багтаамжтай бохирын 2 машин буюу нийт 574 сая төгрөгийн 8 автомашин, 64,4 сая төгрөгийн 12,225 кг ариутгал халдваргүйжүүлэлтийн гипохлорид кальци бодис, 32 хайрцаг жавелин;

- Төрийн үйлчилгээг ард иргэдэд шуурхай хүргэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн онцгой байдлын газар, Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын Цэнгэл сум дахь Гал түймэр унтраах, аврах 71 дүгээр анги, Дорнод аймгийн Халхгол сум дахь Гал түймэр унтраах, аврах 62 дугаар анги, Дорноговь, Ховд, Хэнтий аймгийн Онцгой байдлын газар, Сүхбаатар аймгийн Түмэнцогтсум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Хэнтий аймгийн Дадал, Баян-Адарга сумын Засаг даргын Тамгын газар, Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хөвсгөл аймгийн Хилийн цэргийн 0257 дугаар анги, ОХУ-ын Улан-Үдэ дэх Ерөнхий консулын газар, Цагдаагийн ерөнхий газар, Завхан аймгийн Сантмаргац сумын Засаг даргын Тамгын газар, Дорнод аймгийн Баян-Уул сум дахь ГТУА 53 дугаар анги, Баянхонгор аймгийн Жаргалант сум дахь Эрэн хайх, аврах бүлэгт улсын нөөцөөс “УАЗ-220695” маркийн нийт 885 сая төгрөгийн 24 автомашин;

#### **3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны**

**өдрийн “Улсын нөөцөөс хөрөнгө гаргах тухай” 162 дугаар тогтоолоор** Хэнтий аймгийн Онон, Балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 72 сая төгрөгийн 2 автомашин;

**4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай” 172 дугаар тогтоолын дагуу** Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газарт 36 сая төгрөгийн 1 автомашин;

**5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Улсын нөөцөөс өвс, тэжээл олгох, тэжээл нөхөн бүрдүүлэх тухай” 212 дугаар тогтоолоор** өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Увс, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан, Дундговь, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд аймгуудад улсын нөөцөөс буцалтгүй тусламж хэлбэрээр 3800 тонн өвс, үнийг нь 50 хувь хямдруулан 1900 тонн тэжээл нийт 2,2 тэрбум төгрөгийн;

**6. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” 240 дугаар тогтоолын дагуу**

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Хүн эмнэлэг, Өвөрхангай аймгийн Төгрөг сумын хүн эмнэлэг, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газарт 153 сая төгрөгийн 4 автомашин, Дархан Уул аймгийн Онцгой байдлын газарт 490 сая төгрөгийн 1 ширхэг аврах ажиллагааны автомашин;

- Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахал дотооддоо алдсанаас хойш Архангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорноновь, Говьсүмбэр, Орхон аймгуудад цар тахлын голомтод үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад улсын нөөцөөс 154 сая төгрөгийн халдвар хамгаалалтын хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис олгох ажлыг тус тус шуурхай зохион байгуулан ажиллалаа.



Зураг 85. Монгол Улсын Засгийн газраас олгосон автомашин, өвс тэжээл тусламж

Монгол Улсын Засгийн газраас зарласан “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ны хөтөлбөрийг хэрэгжүүлж 2020 оны хаврын тариалалтын ажилд дэмжлэг үзүүлэхээр Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Улсын нөөцөөс улаанбуудайн үр гаргах тухай” 32 дугаар тушаалаар улсын нөөцөд хадгалагдаж буй үрийн улаанбуудайг тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд олгохоор шийдвэрлэсэний дагуу ОБЕГ болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөдөө аж ахуйг дэмжих сантай “Хамтран ажиллах”

**4-р хэсэг. Хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаа**

АТ/60-10 дугаар гэрээ байгуулан улсын нөөцийн 2 анги, 2 салбар, 4 цэгээс урьдчилгаа төлбөрийн нөхцөлтэйгээр 2 тэрбум 436 сая төгрөгийн 2,918 тонн үрийн буудайг 104 аж ахуйн нэгж, иргэнд олгосон.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал, 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай холбогдуулан улсын нөөцөөс 2020 онд олгосон бараа, материалыг төрлөөр авч үзвэл:

3,2 тэрбум төгрөгийн  
**8240**  
тонн өвс



2,2 тэрбум төгрөгийн  
**5674**  
тонн тэжээл



315,1 сая төгрөгийн  
**90** ширхэг  
иж бүрэн гэр



2,8 тэрбум төгрөгийн  
**57** ширхэг  
аврах ажиллагааны, автомашин  
ариутгалын, УАЗ маркийн



79,1 сая төгрөгийн  
**6** ширхэг усны  
моторт завь



4,1 сая төгрөгийн  
хөдөлмөр хамгааллын  
**хувцас**




218,4 сая төгрөгийн ариутгал  
халдваргүйжүүлэлтийн  
**бодис**



64,8 сая төгрөгийн  
**МОТОПОМП**



2,4 тэрбум төгрөгийн  
**2,918** тонн  
үрийн буудай



Нийт тусламжийн 46,9 орчим хувийг өвс тэжээл, 24,3 хувийг автомашин, 20,8 хувийг үрийн буудай тус тус эзэлж байна.

Улсын хэмжээнд **2020 онд** тохиолдсон гамшиг ослын хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулан улсын нөөцөөс зарцуулсан зардал нь 2019 оныхтой харьцуулбал **46,9 хувиар өссөн** байна.

## БҮЛЭГ 4.2. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын Онцгой комисс нь коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах чиглэлээр 40 удаа хуралдаж Монгол Улсын Засгийн газрын 53, Улсын онцгой комиссын 12 тогтоол, Улсын Онцгой комиссын 5 албан даалгавар, Улсын Онцгой комиссын даргын 50 тушаалыг баталж, тусгай чиг үүрэг бүхий шуурхай бүлэг, ажлын хэсэг 21-ийг байгуулан холбогдох арга хэмжээг авч, үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Улсын хэмжээнд 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, хугацааг 12 удаа сунгаж, мөн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 4 удаа сунган ажилласан.



Монгол Улсад коронавируст халдвар дотоодод бүртгэгдсэнээс хойшхи хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 179, 196 дугаар тогтоолоор халдварын голомтот бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа эмч, эмнэлгийн ажилчид, төрийн тусгай болон холбогдох бусад байгууллагын 15.247 албан хаагчид 15.5 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон, 198 дугаар тогтоолоор тусгаарлах байр болон халдваргүйтгэлийн арга хэмжээнд 3.0 тэрбум төгрөг, 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын 240 дүгээр тогтоолоор коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны зардалд 1.7 тэрбум төгрөг, нийт 20.2 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. Хөрөнгө гаргах тухай Засгийн газрын 10 тогтоол гаргаж нийт 32.6 тэрбум төгрөг зарцуулсан.




**4-р хэсэг. Хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаа**

**Хүснэгт 9. 2020 онд Засгийн газрын тогтоолоор гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө**

д/д	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Зориулалт	Дүн /төгрөгөөр/
1	Засгийн газрын 2020 оны 419 дүгээр тогтоол	Өвөлжилт хүндэрч болзошгүй байгаа аймгийн малчид, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх, отрын штаб байгуулах, цаг үеийн шинжтэй бусад асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгө	1,705,075,890
2	Засгийн газрын 2020 оны 199 дүгээр тогтоол	Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн “Ковид-19”-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зардал	2,496,641,300
3	Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоол	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгууийн үед коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх хувийн хамгаалах хэрэгслийн зардалд шаардагдах хөрөнгө	483,247,300
4	Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоол	ХАВСРАЛТ -1: Зуншлага муу байсан зарим аймагт өвс, тэжээлийн аюулгүй нөөц бэлтгэх хөрөнгө. ХАВСРАЛТ -2: Төв, суурийн газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангахад шаардагдах хөрөнгө. ХАВСРАЛТ -3: Аймаг дундын отрын бүс нутагт малын тэжээл нөөцлөхөд шаардагдах хөрөнгө	2,991,000,000
5	Засгийн газрын 2020 оны 139 дүгээр тогтоол	ХАВСРАЛТ -1: Гамшгийн улмаас зарим аймагт учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход шаардагдах зардал ХАВСРАЛТ -2: Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зардал. ХАВСРАЛТ -3: Улсын нөөцийн бараа материал нөхөн бүрдүүлэх	3,645,761,500
6	Засгийн газрын 2020 оны 179 дүгээр тогтоол	ХАВСРАЛТ -1: Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зардал /ОБЕГ-Урамшуулал олгох/ ХАВСРАЛТ -2: Коронавируст халдвар (Ковид-19)-ын дотоодын тусгаарлалтын үйл ажиллагаатай холбогдон гарах нэмэлт зардал	12,214,650,000
7	Засгийн газрын 2020 оны 172 дугаар тогтоол	Хилийн зарим авто замын боомтыг хэвийн ажиллуулахад шаардагдах зардал	1,765,024,000
8	Засгийн газрын 2020 оны 196 дугаар тогтоол	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан халдварын голомтын бүсэд нийтийн хэв журмыг сахиулах, хяналтын цэгт хүч нэмэгдүүлэн үүрэг гүйцэтгэсэн цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад олгох урамшууллын зардал	3,314,400,000
9	Засгийн газрын 2020 оны 212 дугаар тогтоол	Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудад улсын нөөцөөс үнэ төлбөргүй олгох өвс, 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох тэжээлийн зардал	2,289,925,000
10	Засгийн газрын 2020 оны 240 дүгээр тогтоол	ХАВСРАЛТ -1: Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зардал, ХАВСРАЛТ -2: Улсын нөөцийн бараа материал нөхөн бүрдүүлэх	1,711,438,160
<b>Нийт</b>			<b>32,617,163,150</b>



Улсын төсвийн хөрөнгийн зарцуулсан нийт 7.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг ангилж үзвэл Улсын нөөцөөс үнэгүй олгох өвс, 50 хувь хямдруулан олгох тэжээл 2.6 тэрбум төгрөг, гамшгийн голомтод ажилласан алба хаагчдын томилолт 877.6 сая төгрөг, улсын нөөцөөс гарах бараа, материал 895.1 сая төгрөг, Эмнэлгийн хэрэгсэл, техник, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис 157.2 сая Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын томилолт, урамшуулал 1,8 тэрбум, Тусгаарлах байрны үйл ажиллагаатай холбоотой нэмэлт зардалд 1,3 тэрбум, Улсын онцгой комиссын шуурхай штабын зардал 164,6 сая, Коронавируст халдвар “Ковид-19”-ын үйл ажиллагаатай холбогдон гарсан нисдэг тэрэгний нислэгийн болон шатахууны зардал 105,0 сая төгрөгийг зарцуулсан байна.



Нийт нутгийн 60 гаруй хувьд их (нэн их 16.5 хувь, их 50.4 хувь), 20 шахам хувьд нь (18.5%) **дунд зэрэг** эрсдэлтэй, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгийн ихэнх, Төв аймгийн баруун урд хэсгээр зудын эрсдэл **“НЭН ИХ”** гарсан байна.

Улсын хэмжээнд 2020 онд үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдыг байгууллагаар нь авч үзвэл давхардсан тоогоор Онцгой байдлын албанд 3,500 орчим алба хаагч, Хил хамгаалах байгууллагын 3,000 орчим алба хаагч, Цагдаагийн байгууллагын 56,000 мянга орчим алба хаагч, Мэргэжлийн хяналтын байгууллагын 2,000 орчим албан хаагч, Зэвсэгт хүчин 859 албан хаагч, гаалийн байгууллагын 569 алба хаагч үүрэг гүйцэтгэн ажилласан байна.

2020 онд Улсын Онцгой комиссоосаймаг, нийслэлийн хэмжээнд шийдвэрлүүлсэн хөрөнгийг задалж харуулбал улсын төсвөөс 8 тэрбум, хүмүүнлэгийн тусламжаар 3,9 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласан байна.

**УОК-ын 2020 онд өвөлжилтийн бэлэн байдлыг хангуулах талаар хийсэн ажил**



Зураг 86. 2020 онд Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах чиглэлээр 21 аймаг, нийслэлийн хэмжээнд зарцуулсан хөрөнгө /сая төгрөгөөр/

Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах, хөдөө аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах зорилгоор төрөл бүрийн будаа/цагаан будаа, шар будаа, гурвалжин будаа, бусад/, ургамлын тос, хүнсний улаанбуудай, улаанбуудай, малын өвс, тэжээл, ургамлын түүхий тосыг Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлуулсан.

Мөн Засгийн газрын 2020 оны 138 дугаар тогтоолоор зудын эрсдэл өндөр гарсан Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Төв аймагт өвс, тэжээл нэмж худалдан авахад зориулж 200-500 сая төгрөг, аймаг, дундын отрын 7 бүсэд 460.0 сая төгрөг, нийт 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

Дэлхийн банкны “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” 5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн төслийн хүрээнд өвөлжилт хүндрэлтэй байгаа Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгийн 40 мянган малчдын нэг өрхөд 300.0 мянган төгрөгийн тэжээлийн дэмжлэг үзүүлж ажилласан байна.










**ТАВДУГААР ХЭСЭГ:**

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР  
(КОВИД-19)-ЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ,  
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, ХАМТЫН  
АЖИЛЛАГАА, ХҮМҮҮНЛЭГИЙН  
ТУСЛАМЖ**

## БҮЛЭГ 5.1. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

### 5.1.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар коронавируст халдварын 1215 батлагдсан тохиолдол бүртгэгдсэн. Монгол Улсад гадаад орноос зөөвөрлөгдсөн анхны тохиолдол 2020 оны 3 дугаар сарын 10, дотоодын анхны халдвар 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс Улаанбаатар хот, Архангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Сэлэнгэ аймгуудад халдварын тохиолдол бүртгэгдсэн байна.



#### БАТЛАГДСАН ТОХИОЛДОЛ


Эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн эсэхээс үл хамааран лабораторийн шинжилгээгээр коронавируст халдвартай болох нь тогтоогдсон тохиолдол

#### СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

Сүүлийн 14 хоногийн хугацаанд халдвар бүртгэгдсэн улс орноор зорчсон эсвэл онош батлагдсан хүнтэй ойрын хавьтал болсон, өвчний аль нэг шинж тэмдэг илэрсэн хүн

Зураг 87. Монгол Улсын хэмжээнд КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдол

#### Өвчлөгсдийн нас, хүйс:




Зураг 88. КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдол /насны ангилал болон хүйсээр/ /Дундаж нас: 34/

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХӨСҮТ, Цэргийн төв эмнэлэг, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II-т онош батлагдан эмчлэгдэж байгаа 375 (хөнгөн-267, хүндэвтэр-99, хүнд-7, маш хүнд-2) хүн байна.




5-р хэсэг. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, харцуу арга хэмжээ, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж



Зураг 88. КОВИД-19 халдварын батлагдан эмчлэгдэж байгаа тохиолдлын мэдээлэл

Батлагдсан тохиолдол /Иргэншил/



Батлагдсан тохиолдол /n=1215/



Зураг 89. Батлагдсан тохиолдлын тоо, иргэншил

### Монгол Улсад халдвар зөөвөрлөгдөн батлагдсан тохиолдол


2020 онд 23 улс, орноос 399 тохиолдол зөөвөрлөгдөн батлагдсан байна. Үүний 66.9 хувь нь Буянт-Ухаа боомтоор, 33.1 хувь нь Алтанбулаг боомтоор орж ирсэн хүмүүс байна. Үүний 96 хувь эмчлэгдэн эдгэрсэн.

Алтанбулаг боомтоор орж ирсэн ТИР ачаа тээврийн 64 жолооч коронавируст халдварын онош батлагдсан бөгөөд бүгд эмчлэгдэн эдгэрсэн.




Зураг 90. Зөөвөрлөгдсөн тохиолдол /улсаар/

### Монгол Улсад хүн амын дотор халдвар бүртгэгдсэн тохиолдол




Зураг 91. Монгол Улсад бүртгэгдсэн КОВИД-19 халдварын тархвар зүйн муруй  
Тохиолдлын тоо: 1215

5-р хэсэг. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, харцу арга хэмжээ, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж



Зураг 92. Монгол Улсад бүртгэгдсэн дотоодын КОВИД-19 халдварын тархвар зүйн муруй Тохиолдлын тоо: 736

Дотоодын халдвар /n=736/




Зураг 93. Монгол Улсад бүртгэгдсэн тохиолдлын тоо /аймаг, нийслэлээр/

Хүйс: (n=736)




Улаанбаатар хотын халдвар /n=410/



Зураг 94. Улаанбаатар хотод бүртгэгдсэн тохиолдлын тоо /дүүргээр/

### УБ тархвар зүйн муруй


Тохиолдлын тоо: 410



Зураг 95. Улаанбаатар тархвар зүйн муруй



*5-р хэсэг. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээ, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж*



Зураг 96. Улаанбаатар өвчлөлийн тархалт

**5.1.2. Улсын хэмжээнд коронавируст халдварын үед авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ:**


**Удирдлага, зохион байгуулалт**

Монгол Улсын Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай болон бусад холбогдох хууль, УИХ-аар 2020 онд шинээр батлагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага удирдлага зохион байгуулалтыг хэрэгжүүлэн ажилладаг.

Бодлогын түвшинд хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэгтэй, орон тооны бус зөвлөл Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл ажиллаж байна.

## Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх тогтолцоо



Зураг 97. КОВИД-19 халдвартай тэмцэх тогтолцоо

## УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС



Улсын хэмжээнд гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комисс (УОК) Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.3-ын дагуу байгуулагдан ажилладаг. Орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс ажиллана.

УОК-ыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлж, орлогч дарга нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байна. Орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга тэргүүлж, орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга орон нутгийн онцгой комиссын орлогч дарга, сумын Засаг даргын Тамгын газрын дарга тухайн сумын онцгой комиссын орлогч даргын эрх үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

**УОК-ын бүрэлдэхүүн  
(Засгийн газрын 2020 оны 202 тогтоол):**

**Дарга:**

Монгол Улсын Шадар сайд

дарга;

Тагнуулын ерөнхий газрын

дарга;

**Орлогч дарга:**

Батлан хамгаалахын сайд

Төрийн тусгай хамгаалалтын  
газрын дарга;

Онцгой байдлын ерөнхий

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

газрын дарга

ерөнхий газрын дарга;

Гаалийн ерөнхий газрын дарга;

**Гишүүд:**

Байгаль орчин, аялал  
жуулчлалын сайд;

Мэргэжлийн хяналтын ерөнхий  
газрын дарга;

Гадаад харилцааны сайд;

Шударга өрсөлдөөн,  
хэрэглэгчийн төлөө газрын

Сангийн сайд;

дарга;

Хууль зүй, дотоод хэргийн сайд;

Гадаадын иргэн, харьяатын

Хөдөлмөр, нийгмийн

газрын дарга;

хамгааллын сайд;

Стандарт, хэмжил зүйн газрын

Барилга, хот байгуулалтын  
сайд;

дарга;

Боловсрол, шинжлэх ухааны  
сайд;

Цаг уур, орчны шинжилгээний  
газрын дарга;

Зам, тээврийн хөгжлийн сайд;

Харилцаа холбоо, мэдээллийн

Соёлын сайд;

технологийн газрын дарга;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн  
сайд;

Шадар сайдын ахлах зөвлөх  
бөгөөд Ажлын албаны дарга;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн сайд;

Засгийн газрын Хэрэг эрхлэх  
газрын Хэвлэл мэдээлэлтэй

Эрчим хүчний сайд;

харилцах хэлтсийн дарга;

Эрүүл мэндийн сайд;

Цөмийн энергийн комиссын

Засгийн газрын Хэрэг эрхлэх  
газрын Тэргүүн дэд дарга;

Нарийн бичгийн дарга;

Ерөнхий сайдын ахлах зөвлөх  
бөгөөд Ажлын албаны дарга;

Монголын Үндэсний  
олон нийтийн радио,  
телевизийн Ерөнхий захирал  
(тохиролцсоноор);

Монгол банкны Тэргүүн дэд  
ерөнхийлөгч (тохиролцсоноор);

Монголын улаан загалмайн  
нийгэмлэгийн Ерөнхий

Эрүүл мэндийн яамны Төрийн  
нарийн бичгийн дарга;

нарийн бичгийн дарга  
(тохиролцсоноор).

Зэвсэгт хүчний Жанжин  
штабын дарга;

**Нарийн бичгийн дарга:**

Хил хамгаалах ерөнхий газрын

Орон тооны

УОК нь бүх төрлийн гамшгийн нөхцөл байдлын үед үйл ажиллагаагаа  
чиглүүлэн ажилладаг бөгөөд коронавируст халдвар (КОВИД-19)-аас

урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажиллагааг чиг үүргийн хүрээнд цаг алдалгүй, шуурхай зохион байгуулан ажиллаж байна. УОК-ын даргын шийдвэрээр коронавируст халдвартай тэмцэх чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах зорилгоор УОК, Гамшгаас хамгаалах улсын албад болон холбогдох бусад байгууллагын төлөөллөөс бүрдсэн “Улсын онцгой комиссын шуурхай штаб”-ыг Эрүүл мэндийн яаманд, орон нутгийн онцгой комиссын дэргэд “Орон нутгийн онцгой комиссын шуурхай штаб” байгуулагдан ажиллаж байна.

### Онцгой комиссын бүрэн эрх (ГХТХ-ийн 271 дүгээр зүйл)

- гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавих;
  - гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Засгийн газраас тогтоосон чиглэлийн хүрээнд ГХТХ-ийн 10.4, 10.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих;
  - гамшгаас хамгаалах алба, орон нутгийн онцгой комисс, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах асуудлаар хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох;
  - гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар тогтоол, албан даалгавар, тушаал гаргах;
  - гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын талаар болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Засгийн газарт танилцуулах;
  - шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж, ажиллуулах;
  - шаардпагатай тохиолдолд төрийн байгууллага, хуулийн этгээдийн мэдээллийг сонсох;
  - гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг нөхөн олговортойгоор дайчлан гаргах;
  - Орон нутгийн онцгой комисс нь ГХТХ-ийн 271.1.1, 271.1.2, 271.1.3, 271.1.4, 271.1.5, 271.1.6, 271.1.7-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
  - Онцгой комиссын шийдвэр, тогтоосон хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг сахин мөрдөхийг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, иргэнээс шаардана.
  - Шуурхай штаб, шуурхай бүлгийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын, орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлнэ.
  - Улсын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.
- Улсын онцгой комисс нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, бэлгэдэл, хэвлэмэл хуудастай байна.



**Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлэх арга хэмжээ**  
(Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйл)

Коронавируст халдвар / КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Улсын онцгой комисс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- гадаад улсад байгаа Монгол Улсын иргэн буцаж ирэх хүсэлт гаргасан тохиолдолд тухайн улс дахь өвчлөлийн тархалт, эрсдэл, шууд нислэгийн боломж, бусад нөхцөл байдлыг харгалзан татан авах, тусгаарлах, хяналтад байлгах арга хэмжээг уян хатан байдлаар үе шаттайгаар зохион байгуулах;

- Монгол Улсад байгаа гадаад улсын иргэн харьяалалгүй хүн буцах, гарах хүсэлт гаргасан тохиолдолд улсын хилээр нэвтрүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах;

- энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан ажиллагааны хүрээнд зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг баталж, хэрэгжүүлэх;

- дамжин өнгөрөх болон улс

хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хүрээнд ачаа тээврийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг батлах;

- энэ хуулийн 7.1.15-д заасан нөөц бүрдүүлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах;

- халдварын тохиолдол, тэдгээрийн хавьтлыг олж тогтоох, илрүүлэх шинжилгээ авах, сорьц цуглуулах, тусгаарлах, хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах, хөл хорионд орсон иргэдийг харьяалах оршин суух газарт зорчих үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

- цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага хоорондын хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлах;

- цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээний талаар холбогдох тушаал гаргах, дүрэм, журам, заавар, удирдамж батлах.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА



Онцгой байдлын байгууллага нь улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулан ажилладаг.

Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь чиг үүргийн хүрээнд улс, орон нутгийн хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх ажиллагааг удирдан чиглүүлэх, зохицуулалтаар хангах асуудалд гол үүрэг гүйцэтгэн,

- удирдах, шийдвэр гаргах
- зохицуулах
- гүйцэтгэх бүх түвшинд бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж байна.

### **Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг (ГХТХ-ийн 29 дүгээр зүйл)**

- гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, хяналт тавих;
- Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- өндөржүүлсэн болон бүхнийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;
- орон нутгийн онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих;
- гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах;
- шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж, гамшгийн цагийн байдлыг нэгтгэн дүгнэж онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах;
- хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах;
- гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн

шилжүүлэхэд гарсан зардал, нөхөн төлбөрийн талаар санал боловсруулан хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх;

- Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

- гамшгаас хамгаалах алба, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх;

- гамшгийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нөхөн сэлбэх;

- гамшгийн судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах, ашиглах;

- гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар, стандарт боловсруулах;

- гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

- гамшгаас хамгаалах талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж

байгаа арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

- гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад танилцуулах;

- гамшгаас хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын болон дотоодын

байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

- олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох багийг бүрдүүлж, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

- гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургах, бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх

## ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБА

Гамшгаас хамгаалах улсын алба: 12

Гамшгаас хамгаалах орон нутгийн алба: аймаг, нийслэл, сум, дүүрэг

Гамшгаас хамгаалах улсын албад	1	Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэх алба
	2	Барилга, хот байгуулалтын алба
	3	Зам, тээврийн алба
	4	Уул, уурхай, хүнд үйлдвэрийн алба
	5	Хүн ам, нийгмийн хамгааллын алба
	6	Хүнс, хөдөө аж ахуйн алба
	7	Түлш, эрчим хүчний алба
	8	Эрүүл мэндийн алба
	9	Мэдээлэл, харилцаа холбооны алба
	10	Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба
	11	Хэв журам сахиулах алба
	12	Сурталчилгааны алба

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.9-т заасны дагуу Монгол Улсад 12 Гамшгаас хамгаалах улсын алба байгуулагдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

- Гамшгаас хамгаалах улсын албаны дарга нь тухайн салбарын сайд, агентлагийн дарга байна. Орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн Гамшгаас хамгаалах албатай.

- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албаны төлөөлөл тухайн шатны шуурхай штабт ажиллаж, тус халдварт өвчинтэй тэмцэх ажиллагааны тэргүүн эгнээнд ажиллаж байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн

босгох арга хэмжээний төлөвлөгөө"-д гамшгийн төрлөөс шалтгаалан тухайн гамшгийн үед удирдан зохицуулах байгууллага, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах байгууллагыг тодорхойлсон.

• Тус төлөвлөгөөнд хүний халдварт өвчний үед Эрүүл мэндийн яам удирдан зохицуулах, СЯ, ГХЯ, ХЗЯ, ХНХЯ, БСШУСЯ, БХЯ, МХЕГ, ОБЕГ, ТЕГ, ИНЕГ болон нутгийн захиргааны байгууллага дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар төлөвлөсөн. Үүний дагуу коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед ЭМЯ, түүний удирдлага дор Халдварт өвчин судлалын үндэсний төв, III шатлалын эмнэлгүүд улсын хэмжээнд, II шатлалын эмнэлэг аймаг, нийслэлийн хэмжээнд, I шатлалын эмнэлэг сум, дүүргийн хэмжээнд хариу арга хэмжээг авч ажиллаж байна.

### Гамшгаас хамгаалах улсын албаны чиг үүрэг (ГХТХ-ийн 33 дугаар зүйл)

- салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх;
- хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах;
- салбарын онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүнийг тогтоох, мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангах;
- гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах;
- салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах;
- гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх;
- орон нутгийн гамшгаас хамгаалах албыг мэргэжлийн удирдлагаар хангах;
- гамшиг болон аюулын нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах;
- голомтын бүсэд ажиллах мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт оролцуулах;
- хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;
- гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;
- гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаархи мэдээ, тайлан гаргах;
- хариуцсан салбарын хүрээнд холбогдох дүрэм, журам, удирдамж, заавар, стандартыг боловсруулж, батлуулах.



### Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг (ГХТХ-ийн 10, 11 дүгээр зүйл)

#### **Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг:**

- өдөр тутмын бэлэн байдал
- өндөржүүлсэн бэлэн байдал
- бүх нийтийн бэлэн байдал

Бэлэн байдлын зэрэгт болон олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд шилжүүлэх хэлбэр:

- бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар
- шатдараалал, эсхүл шууд

Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, зэрэг бууруулах, цуцлах шийдвэрийг гаргах албан тушаалтан:

- сум, дүүргийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн сум,

дүүргийн Онцгой комиссын дарга;

• хоёр буюу түүнээс дээш сум, дүүрэг, аймгийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллага болон тухайн сум, дүүргийн Онцгой комиссын даргын саналыг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга;

• улсын хэмжээнд, эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт Улсын Онцгой комиссын даргын саналыг үндэслэн Засгийн газар;

• шаардпагатай тохиолдолд хариуцсан салбар, байгууллагыг гамшгаас хамгаалах улсын албаны дарга.

• олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийг Засгийн газар

#### **Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай Монгол Улсын хуулиас**

Монгол Улсын Их Хурлаас “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг

- 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр шинээр яаралтай горимоор хэлэлцэн баталсан.
- 2020 оны 12 дүгээр сарын 31-ний өдөр тус хуулийн үйлчлэх хугацааг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгаж, зарим нэмэлт өөрчлөлт оруулсан.
- 4 бүлэг, 18 зүйлтэй

#### **Хуулийн зорилт**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал /цаашид “цар тахал”

гэх/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ (Хуулийн 7 дугаар зүйл)

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалт тогтоох, зайнаас харьцах зэрэг шаардлагатай арга хэмжээг

эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагын саналыг үндэслэн авах, тэдгээрт мөрдөх журам, зааврыг батлах;

2. Цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх;

3. Эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан түрээслээд өмчлөх хэлбэртэй ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүний хүүгийн татаасаар Төв банканд дэмжлэг үзүүлэх;

4. Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг шийдвэрлэх;

5. Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх;

6. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд болон зарим нутаг дэвсгэрийн хэмжээнд хязгаарлах;

7. Өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар теле, цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх журам батлах;

8. Бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах;

9. Шашны байгууллагын шашин номын хурал, цуглааныг олон нийтийг биечлэн хамруулан зохион байгуулахыг тодорхой хугацаагаар зогсоох;

10. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй

хангах;

11. Цар тахлын үед орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, сайжруулсан түлш, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах;

12. Төрөлжсөн асрамжийн газар, түүнчлэн эрүүлжүүлэх, баривчлах, цагдан хорих байр, хорих ангид байгаа болон бусад хэлбэрээр эрх чөлөө нь хязгаарлагдсан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;

13. Цар тахлаас хамааралгүйгээр хийгдэж байгаа бүтээгдэхүүний экспортыг хориглохгүй бөгөөд эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, урвалж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, иргэдийн хамгаалах хэрэгсэл, хүнсний болон бусад шаардлагатай барааг улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг шийдвэрлэх;

14. Цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой 3 сараас доошгүй хугацааны зардлыг шийдвэрлэх;

15. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд ажлын тусгай горимоор томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх олговор, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

16. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;

17. Цар тахлын үед өргөн хэрэглээний болон стратегийн ач холбогдол бүхий зарим бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад чиглэсэн төрийн зохицуулалтын арга хэмжээг авах;

18. Улсын хилээр нэвтрэх болон дотоодын зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тодорхой хугацаанд хязгаарлалт хийх;

19. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээ, түр хамгаалах байранд шаардлагатай хөрөнгө оруулалт болон 24 цагаар ажиллуулах утасны санхүүжилтийг шийдвэрлэх;

20. Коронавирусын халдвар авсан, халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, хуульд заасан аргаар таслан зогсоох;

21. Цар тахлын үед арга хэмжээ авахдаа хүүхэд болон өндөр настай, хууч өвчтэй, эрүүл мэндийн тогтмол тусламж, үйлчилгээ шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

22. Цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах;

23. Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч, холбогдох зардлыг

шийдвэрлэх;

24. Үр тарианы болон хүнсний ногооны үрийн нөөц бүрдүүлэх, газар тариалангийн ургац тасалдахаас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

25. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн хяналт тавих.

26. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосны улмаас Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй болсон нь холбогдох баримтаар тогтоогдсон, гаалийн хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн барааны гаалийн бүрдүүлэлтийн горимд байрших хугацааг дэглэм цуцлах хүртэлх хугацаагаар сунгах, хугацаа хэтрүүлсний торгуулиас чөлөөлөх;

27. Цар тахлын үед төрийн үйлчилгээг мэдээллийн технологи ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх боломжийг бүрдүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх;

28. Төрийн байгууллага хооронд болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай цахим хэлбэрээр албан бичиг илгээх, хүлээн авах боломжийг бүрдүүлсэн солилцооны дундын системийг ашиглах;

29. Шуудангийн үйлчилгээг цар тахлын үед тасралтгүй зохион байгуулах, хот доторх болон хот хоорондын бараа бүтээгдэхүүний хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлэх, цахим худалдааны цар хүрээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах

30. Цар тахлын үед харилцаа холбоо, мэдээллийн технологи, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар, төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг авах.



5-р хэсэг. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээ, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж

**ҮАБЗ, Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар,  
УОК-ын шийдвэрийн тоо, агуулга**


Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах асуудлаар Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар 36 удаа, Улсын онцгой комиссын хуралдаанаар 40 удаа, шуурхай хуралдаан 47 удаа тус тус хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргасан байна.



Зураг 98. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн тоо (2020.12.31-ний өдрийн байдлаар)

Дэлхий дахинд тархаад байгаа коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын улмаас Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нэн ялангуяа хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүссэн тул Засгийн газрын 2020.02.12-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт

хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн. Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу Улсын Их хурал, Засгийн газар нь өдөр тутмын бэлэн байдлын үед тодорхой хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой бүрэн эрхийг хэрэгжүүлдэг бөгөөд үүний дагуу Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол, хуралдааны тэмдэглэлээс аль байгууллагад нийт хэдэн удаа үүрэг өгснийг нь харууллаа.




Зураг 99. Коронавируст халдварт цар тахлын үед 2020 оны 1 дүгээр сараас 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Засгийн газраас гаргасан тогтоолуудаар холбогдох байгууллагуудад өгөгдсөн үүрэг, зөвлөмжийн тоо

**5-р хэсэг. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, харцу арга хэмжээ, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж**

Зургаас харахад Сангийн яам болон Эрүүл мэндийн яам хамгийн их үүрэг, зөвлөмж авч ажилласан нь харагдаж байна.

Улсын онцгой комиссоос гаргасан 12 тогтоолоос аль байгууллагад нийт хэдэн удаа үүрэг өгснийг дараах зургаар харууллаа.



**Зураг 100. Коронавируст халдварт цар тахлын үед 2020 оны 2 дугаар сараас 12 дугаар сар дуустал хугацаанд Улсын онцгой комиссоос гаргасан тогтоолоор холбогдох байгууллагуудад өгөгдсөн үүрэг, зөвлөмжийн тоо**

Гамшгаас хамгаалах тухай хуулинд өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх шаардлагатай 17 арга хэмжээ тусгагдсан. Коронавируст халдварын цар тахлын эсрэг Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол, хурлын тэмдэглэлийн холбогдох заалтууд энэхүү хуулинд заасан арга хэмжээг хэрхэн тусгасан байдалд шинжилгээ хийсэн.

Хүснэгт 10. Засгийн газар, УОК-ын короновируст халдварт цар тахлын үед зарласан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллахад гаргасан зарим шийдвэрт хийсэн шинжилгээний дүн

№	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ (ГХТХ-ийн 10.4.1-17)	Арга хэмжээний тоо		
		ЗГ	УОК	Нийт
1	Гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх;	4	12	16
2	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх;	8	4	12
3	Гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх;	5	12	17
4	Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах	5	37	42
5	Гамшгийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх	15	13	28
6	Соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, цуцлах, хориглох;	6	9	15
7	Харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах	15	29	44
8	Голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах;	9	31	40
9	Нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх;	27	43	70
10	Төрийн болон төрийн өмчит байгууллагын үүрэг, зориулалт, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагийн хуваарийг тогтоосон хугацаагаар өөрчлөх;	7	6	13
11	Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах	15	14	29
12	Стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох, хяналт тавих	6	2	8
13	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх;	7	4	11
14	Эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах;	32	31	63
15	Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран хилийн боомтод тусгай дэглэм тогтоож, мөрдүүлэх;	9	18	27
16	Химийн хорт болон аюултай бодис, ачаа тээвэрлэлтийг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зогсоох;	5		5
17	Зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, хуулийн этгээдээс холбогдох мэдээллийг авах бөгөөд тухайн мэдээллийн нууцлалыг хадгалах, түүнчлэн гамшгаас хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахгүй байх	5	2	7


Хүснэгтээс харахад Монгол Улсын Засгийн газар нь “Эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах”, “Нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх”, “Харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах”, гамшгийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх тал дээр хамгийн их төвлөрч ажилласан байгаа бөгөөд нийт гаргасан шийдвэрийн 55 орчим хувийг эзэлж байна.

УОК нь ГХТХ-ийн 10.4 дүгээр зүйлд заасан өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх 17 үйл ажиллагааны чиглэлийг жигд хангасан шийдвэр гаргасан нь харагдаж байна.

#### **Нийт зүйл заалтын тоогоор авч үзвэл**

- “Нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх”,
- “Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах;”,
- “Голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах”,
- “Эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах”,
- “Харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах” гэсэн үйл ажиллагааны чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь 64 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд энэ талаар илүүтэйгээр чиглэн ажилласан байна.






Зураг 101. 2020 оны 1-р сарын 24-ний өдрөөс 2020 оны 12-р сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд Улсын онцгой комиссын хуралдааны тэмдэглэлээр холбогдох байгууллагуудад өгөгдсөн үүргийн тоо

*5-р хэсэг. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, харцу арга хэмжээ, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж*

Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх чиглэлээр Шадар сайдын 32, Улсын онцгой комиссын даргын 50 дугаар тушаал батлагдан гарсан байна.



**Зураг 102. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх чиглэлээр Шадар сайдын баталсан тушаалын тоо, агуулга**



**Зураг 103. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх чиглэлээр Улсын онцгой комиссын даргын тушаалын тоо, агуулга**

## БҮЛЭГ 5.2. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕ ДЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

### 5.2.1. Коронавируст халдвар (ковид-19)-ын үе дэх олон улсын хамтын ажиллагаа

Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, ОХУ-ын Онцгой байдлын яамны Бүгд Найрамдах Тува Улс дахь Ерөнхий газар хоорондын 2021 онд хамтран ажиллах төлөвлөгөө"-г 2020 оны 12 дугаарын 04-ний өдөр цахим хэлбэрээр баталсан.


"Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, ОХУ-ын Онцгой байдлын яамны Өвөрбайгалийн хязгаар дахь Ерөнхий газар хоорондын 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө"-г 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр цахимаар баталсан.

КОВИД-19 халдварт цар тахлын улмаас Азийн гамшгийн аюулыг бууруулах төвөөс 2020 оны 10 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Япон улсад цахим хэлбэрээр зохион байгуулсан "Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн бага хурал-2020" хуралд ОБЕГ-ын дарга, бригадын генерал Г.Ариунбуян оролцлоо.



Зураг 104. Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн бага хурал-2020

КОВИД-19 халдварт цар тахлын улмаас Швейцарийн Холбооны Улсын Женев хотоос 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан "Ерөнхий ассамблейн 24 дүгээр чуулган"-д ОБЕГ-ын дарга, бригадын генерал Г.Ариунбуян оролцлоо.



Зураг 105. Ерөнхий ассамблейн 24 дүгээр чуулган

## **5.2.2. Коронавируст халдвар (ковид-19)-ын үе дэх хүмүүнлэгийн тусламж**

Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг хүссэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар албан ёсны хандивын данс нээсэн.

Хандив, тусламжийн үйл ажиллагаанд гадаад, дотоодын нийт 737 байгууллага, иргэд оролцож мөнгөөр 3 тэрбум 906 сая төгрөг, бараа материалар 4 тэрбум 683 сая төгрөг буюу нийт 8 тэрбум 590 сая төгрөгийн хандив, тусламжийг үзүүлснийг хүлээн авсан.

Мөн БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 320 сая төгрөгийн 5000 ширхэг амны хаалт /нэг удаагийн/, 5000 ширхэг амны хаалт /N95/, 1000 ширхэг хамгаалалтын хувцас, 5000 ширхэг оношлуурыг тус тус хүлээн авч, ЭМЯ-д хүлээлгэн өгсөн. Мөн тус улсын иргэн Жак Маас 500 мянган ширхэг /KN95/ амны хаалт хандивласныг хүлээн авсан.



*Зураг 106. Гадаад, дотоодын байгууллага, иргэдийн хандив тусламж*

Хандив, тусламжаар төвлөрсөн мөнгөн хөрөнгө болон бараа материалыг хүлээн авах, хуваарилах, хяналт тавих үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-аар зохицуулан ажиллаж байна. Үүнд:

- Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн Зүрх тасагт аппарат худалдан авахад 240 сая төгрөг, уушиг орлуулах ЕСМО аппаратын иж бүрдэл худалдан авахад 450 сая төгрөг, Улсын хоёрдугаар төв эмнэлэгийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах хүрээнд бөөр орлуулах эмчилгээний Гемодиализийн аппарат худалдан авахад 120 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн;

- Коронавирусийн болзошгүй халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахаар БХЯ-ны "Бөртэ" ТӨҮГ, ШШГЕГ-ын 407, 409 дүгээр анги, ХХЕГ-ын 0288 дугаар ангийн оёдлын үйлдвэрүүдээр амны хаалт оёулахаар байгуулсан гэрээний зардал 85 сая төгрөг;

- Коронавируст халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Төрийн байгууллага болон тусгаарлах байранд ажиллаж байгаа албан



хаагчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах, дархлааг дэмжих, УОК-ын Шуурхай штабын үйл ажиллагаанд нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангахад 689.4 сая төгрөг;

- БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж болон тус улсын иргэн Жак Ма-аас ирүүлсэн хандив, тусламжийг хүлээн авах, тээвэрлэх болон УОК-ын шуурхай штаб, тусгаарлан ажиглах байранд ажиллаж байгаа албан хаагчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах, "Монхимо" ХХК-ийн гар ариутгагч, денатуратын үйлдвэрлэлд шаардагдах зардалд 59,1 сая төгрөг,

- Корноавирусийн голомт болон эрсдэлтэй бүсэд ажиллаж байгаа эмч, эмнэлэгийн ажилчид, төрийн зарим албан хаагчдад олгох урамшуулалд 631,9 сая төгрөг,

- Тусгай үүргийн нислэгээр ирсэн иргэдийг тээвэрлэсэн жолооч, тусгаарлах байранд үүрэг гүйцэтгэж буй төрийн байгууллагын ажилтны байр, хоолны төлбөрт 114,8 сая төгрөг,

- Коронавирус халдварт /COVID-19/ цар тахлын тусгаарлалтын үйл ажиллагаатай холбогдуулан гарсан нэмэлт зардлын санхүүжилтэд 243,5 сая төгрөг,

- Сэлэнгэ аймгийн ЗДТГ-т коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 30 сая төгрөг,

- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд 100 сая төгрөг,

- ЦЕГ-ын хилийн боомтоор ачаа, тээвэр зөөвөрлөх зардалд 48,4 сая төгрөг,

- Хилийн чанадад байгаа санхүүгийн хүндрэлийн тодорхой шалгуурыг хангасан зорилтот бүлгийн Монгол Улсын иргэдэд 300 сая төгрөг,

- УОК-ын Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэрэг болон бусад зардалд 82,2 сая төгрөг,

- Нийслэлийн хэмжээнд тусгаарлан ажиглах байранд байгаа иргэд болон үүрэг гүйцэтгэж буй төрийн албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор 32 сая төгрөг,

- Нийслэлийн хэмжээнд эргүүл, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг дулаан хадгалдаг бүтээгдэхүүнээр хангахад 78 сая төгрөг буюу нийт 3 тэрбум 316,7 сая төгрөгийг зарцуулсан байна.

УОК-т хандив, тусламжаар 4 тэрбум 669,6 сая төгрөгийн амны хаалт, бээлий, эмнэлгийн ор, халдвар хамгааллын хувцас, цэвэрлэгээний материал, шатахууны талон, гар утасны ярианы нэгж, интернет дата эрх, дархлаа дэмжих хүнсний бүтээгдэхүүн гэх мэт/ 25 орчим нэр төрлийн бараа, материал ирүүлснийг хүлээн авч, тусгаарлан ажиглах байрууд, аймаг, нийслэлийн Онцгой комисс, автозамын шалган нэвтрүүлэх товчоо, эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдад болон УОК-ийн Шуурхай штаб, өндөржүүлсэн бэлэн байдалд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдад Монгол Улсын Шадар сайдын баталсан хуваарийн дагуу 4 тэрбум 377,1 сая төгрөгийн бараа, материалыг олгоод байна.

Өнөөдрийн байдлаар хандив, тусламжаас 589,3 сая төгрөг, 292,1 сая төгрөгийн бараа, материалын үлдэгдэлтэй байна.

Хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийн орлого, зарцуулалт, худалдан авах ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын шилэн дансанд байршуулахаас гадна цахим хуудасаар тухай бүр мэдээлж байгаа юм.




5-р хэсэг. Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, харцу арга хэмжээ, хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж




Зураг 107. Хандив, тусламжаар ирүүлсэн бараа, материалын төрөл, тоо ширхэг, үнийн дүн /2020.12.31-ний өдрийн байдлаар/



Зураг 108. Хандивлагчдаас ирүүлсэн бараа, материалын эзлэх хувь /2020.12.31-ний өдрийн байдлаар/



Зураг 109. Хандив, тусламжаар ирүүлсэн бараа, материалын төрөл, тоо ширхэг, үнийн дүн, эзлэх хувь /2020.12.31-ний өдрийн байдлаар/



Зураг 110. Хандив, тусламжийн зарцуулалт /2020.12.31-ний өдрийн байдлаар/

ХАВСРАЛТ



### Монгол орны нутаг дэвсгэрт 2020 онд тохиолдсон газар хөдлөлт

*Монгол орны нутаг дэвсгэрт магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 64 удаа болсон байна.*

1. 1 дүгээр сарын 12-нд Булган аймгийн Могод сумын төвөөс зүүн хойш 17 км-ийн зайд магнитуд 3.5-тай,
2. 1 дүгээр сарын 18-нд Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын төвөөс баруун тийш 33 км-ийн зайд магнитуд 3.6-тай,
3. 1 дүгээр сарын 26-нд Увс аймгийн Завхан сумын төвөөс баруун хойш 29 км-ийн зайд магнитуд 4.0-тэй,
4. 1 дүгээр сарын 29-нд Увс аймгийн Цагаанхайрхан сумын төвөөс зүүн урагш 9 км-ийн зайд магнитуд 3.9-тэй,
5. 2 дугаар сарын 11-нд Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын төвөөс баруун тийш 30 км-ийн зайд магнитуд 3.5-тай,
6. 2 дугаар сарын 12-нд Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын төвөөс баруун тийш 31 км-ийн зайд магнитуд 4.8-тай,
7. 2 дугаар сарын 16-нд Булган аймгийн Могод сумын төвөөс урагш 36 км-ийн зайд магнитуд 3.6-тай,
8. 2 дугаар сарын 17-нд Говь-Алтай аймгийн Жаргалант сумын төвөөс зүүн тийш 15 км-ийн зайд магнитуд 4.3-тай,
9. 2 дугаар сарын 19-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс зүүн тийш 81 км-ийн зайд магнитуд 4.2-той,
10. 2 дугаар сарын 23-нд Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын төвөөс урагш 22 км-ийн зайд магнитуд 3.6-тай,
11. 3 дугаар сарын 3-нд Орхон-Уул аймгийн Жаргалант сумын төвөөс баруун урагш 7 км-ийн зайд магнитуд 4.9-тэй,
12. 3 дугаар сарын 20-нд Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвөөс зүүн урагш 31 км-ийн зайд магнитуд 5.9-тэй,
13. 3 дугаар сарын 20-нд Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвөөс зүүн урагш 29 км-ийн зайд магнитуд 3.5-тай,
14. 3 дугаар сарын 20-нд Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвөөс урагш 32 км-ийн зайд магнитуд 4.4-тэй,
15. 3 дугаар сарын 20-нд Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвөөс зүүн урагш 31 км-ийн зайд магнитуд 4.0-тэй,
16. 3 дугаар сарын 22-нд Баян-Өлгий аймгийн Цагааннуур сумын төвөөс баруун хойш 31 км-ийн зайд магнитуд 4.0-тэй,
17. 3 дугаар сарын 23-нд Хөвсгөл аймгийн Ханх сумын төвөөс баруун хойш 39 км-ийн зайд магнитуд 3.5-тай,
18. 3 дугаар сарын 24-нд Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвөөс урагш 31 км-ийн зайд магнитуд 4.5-тай,
19. 3 дугаар сарын 26-нд Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвөөс урагш 29 км-ийн зайд магнитуд 3.9-тай,
20. 3 дугаар сарын 27-нд Говь-Алтай аймгийн Бигэр сумын төвөөс урагш 22 км-ийн зайд магнитуд 3.7-тай,
21. 3 дугаар сарын 27-нд Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвөөс урагш 29 км-

ийн зайд магнитуд 4.1-тэй,

22. 3 дугаар сарын 27-нд Булган аймгийн Баяннуур сумын төвөөс баруун тийш 7 км-ийн зайд магнитуд нь 4.0-тэй,

23. 3 дугаар сарын 30-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс зүүн тийш 74 км-ийн зайд магнитуд нь 3.8-тай,

24. 4 дүгээр сарын 2-нд Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвөөс урагш 28 км-ийн зайд магнитуд 3.9-тэй,

25. 4 дүгээр сарын 6-нд Ховд аймгийн Алтай сумын төвөөс урагш 77 км-ийн зайд магнитуд 4.0-тэй,

26. 4 дүгээр сарын 21-нд Говь-Алтай аймгийн Чандмань сумын төвөөс зүүн тийш 40 км-ийн зайд магнитуд 3.6-тай,

27. 4 дүгээр сарын 26-нд Увс аймгийн Наранбулаг сумын төвөөс баруун тийш 29 км-ийн зайд магнитуд 3.9-тэй,

28. 5 дугаар сарын 11-нд Өмнөговь аймгийн Баяндалай сумын төвөөс зүүн тийш 28 км-ийн зайд магнитуд 3.8-тай,

29. 5 дугаар сарын 17-нд Дундговь аймгийн Хулд сумын төвөөс баруун урагш 35 км-ийн зайд магнитуд 3.8-тай,

30. 5 дугаар сарын 26-нд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын төвөөс хойш 16 км-ийн зайд магнитуд 3.6-тай,

31. 6 дугаар сарын 7-нд Баянхонгор аймгийн Баянцагаан сумын төвөөс хойш 19 км-ийн зайд магнитуд 4.1-тэй,

32. 6 дугаар сарын 8-нд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс зүүн хойш 57 км-ийн зайд магнитуд 4.5-тай,

33. 7 дугаар сарын 4-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс зүүн тийш 67 км-ийн зайд магнитуд 5.1-тэй,

34. 7 дугаар сарын 4-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс зүүн тийш 76 км-ийн зайд магнитуд 4.2-той,

35. 7 дугаар сарын 10-нд Дархан-Уул аймгийн төвөөс баруун тийш 17 км-ийн зайд магнитуд 3.9-тэй,

36. 7 дугаар сарын 20-нд Баянхонгор аймгийн Шинэ-Жинст сумын төвөөс зүүн урагш 107 км-ийн зайд магнитуд 4.9-тэй,

37. 8 дугаар сарын 12-нд Дундговь аймгийн Хулд сумын төвөөс зүүн урагш 16 км-ийн зайд магнитуд 3.6-тай,

38. 8 дугаар сарын 15-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс зүүн тийш 60 км-ийн зайд магнитуд 4.1-тэй,

39. 8 дугаар сарын 16-нд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төвөөс баруун хойш 24 км-ийн зайд магнитуд 3.9-тэй,

40. 8 дугаар сарын 24-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс зүүн тийш 85 км-ийн зайд магнитуд 4.3-тэй,

41. 8 дугаар сарын 25-нд Хөвсгөл аймгийн Рашаант сумын төвөөс зүүн тийш 21 км-ийн зайд магнитуд 3.9-тэй хөдлөлтүүд тус тус болсон байна.

42. 9 дүгээр сарын 1-нд Дорнод аймгийн Халхгол сумын төвөөс баруун тийш 123 км-ийн зайд магнитуд 4.3-тэй

43. 9 дүгээр сарын 11-нд Говь-Алтай аймгийн Чандмань сумын төвөөс зүүн тийш 33 км-ийн зайд магнитуд 3.9-тэй

44. 9 дүгээр сарын 14-нд Төв аймгийн Баян-Өнжүүл сумын төвөөс баруун хойш 2 км-ийн зайд магнитуд 3.6-тай



45. 9 дүгээр сарын 20-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс урагш 57 км-ийн зайд (Сүхбаатар аймгийн нутагт) магнитуд 4.3-тай

46. 9 дүгээр сарын 20-нд Ховд аймгийн Алтай сумын төвөөс урагш 90 км-ийн зайд магнитуд 4.2-той,

47. 9 дүгээр сарын 23-нд Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс баруун урагш 47 км-ийн зайд магнитуд нь 3.8-тай,

48. 9 дүгээр сарын 30-нд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төвөөс баруун тийш 96 км-ийн зайд магнитуд нь 4.0-тэй,

49. 10 дугаар сарын 1-нд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төвөөс баруун тийш 95 км-ийн зайд магнитуд нь 4.0-тэй,

50. 10 дугаар сарын 3-нд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төвөөс баруун тийш 93 км-ийн зайд магнитуд нь 4.0-тэй,

51. 10 дугаар сарын 14-нд Завхан аймгийн аймгийн Асгат сумын төвөөс зүүн хойш 28 км-ийн зайд магнитуд нь 3.5-тай,

52. 10 дугаар сарын 22-нд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төвөөс баруун тийш 77 км-ийн зайд магнитуд нь 4.5-тай,

53. 10 дугаар сарын 28-нд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төвөөс хойш 79 км-ийн зайд магнитуд нь 4.5-тай,

54. 11 дүгээр сарын 05-нд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төвөөс зүүн тийш 101 км-ийн зайд магнитуд нь 5.3-тай, (Уг газар хөдлөлт нь Монгол орны хилийн бүсийн гадна боловч Монгол орны нутаг дэвсгэрт мэдрэгдсэн болно.)

55. 11 дүгээр сарын 13-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс зүүн тийш 79 км-ийн зайд магнитуд нь 3.6-тай,

56. 11 дүгээр сарын 13-нд Дорнод аймгийн Халхгол сумын төвөөс баруун тийш 118 км-ийн зайд магнитуд нь 4.0-тэй,

57. 11 дүгээр сарын 15-нд Говь-Алтай аймгийн Цогт сумын төвөөс баруун урагш 27 км-ийн зайд магнитуд нь 4.1-тэй,

58. 11 дүгээр сарын 16-нд Ховд аймгийн Дарви сумын төвөөс зүүн урагш 8 км-ийн зайд магнитуд нь 3.6-тай,

59. 11 дүгээр сарын 21-нд Баянхонгор аймгийн Баянлиг сумын төвөөс зүүн тийш 36 км-ийн зайд магнитуд нь 4.4-тэй,

60. 11 дүгээр сарын 21-нд Баянхонгор аймгийн Баянлиг сумын төвөөс зүүн тийш 36 км-ийн зайд магнитуд нь 4.1-тэй,

61. 12 дугаар сарын 4-нд Ховд аймгийн Мөнххайрхан сумын төвөөс урагш 28 км-ийн зайд магнитуд нь 3.6-тай,

62. 12 дугаар сарын 10-нд ОХУ-ын Улаан-үүд хотоос баруун хойш 88 км-ийн зайд магнитуд нь 5.4-тэй, (Уг газар хөдлөлт нь Монгол орны хилийн бүсийн гадна боловч Монгол орны нутаг дэвсгэрт мэдрэгдсэн болно.)

63. 12 дугаар сарын 13-нд Булган аймгийн Баян-Агт сумын төвөөс зүүн хойш 26 км-ийн зайд магнитуд нь 3.6-тай,

64. 12 дугаар сарын 26-нд Дорнод аймгийн Матад сумын төвөөс зүүн тийш 87 км-ийн зайд магнитуд нь 3.8-тай,

65. 12 дугаар сарын 26-нд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төвөөс баруун хойш 23 км-ийн зайд магнитуд нь 3.9-тэй,

66. 12 дугаар сарын 28-нд Увс аймгийн Наранбулаг сумын төвөөс зүүн хойш 16 км-ийн зайд магнитуд нь 4.3-тай хөдлөлтүүд тус тус болсон байна.

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

### **Дарга**

Монгол Улсын Ерөнхий сайд

### **Орлогч дарга**

Монгол Улсын Шадар сайд

### **Гишүүд:**

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;
- Батлан хамгаалахын сайд;
- Гадаад харилцааны сайд;
- Сангийн сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
- Барилга, хот байгуулалтын сайд;
- Боловсрол, шинжлэх ухааны сайд;
- Зам, тээврийн хөгжлийн сайд;
- Соёлын сайд;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;
- Эрчим хүчний сайд;
- Эрүүл мэндийн сайд;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн - Ажлын албаны дарга;
- Шадар сайдын Ажлын албаны дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга;
- Үндэсний хөгжлийн газрын дарга;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн - Стратегийн судалгааны хүрээлэнгийн захирал;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн дарга;
- Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга;
- Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч;
- Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга (тохиролцсоноор).

### **Нарийн бичгийн дарга:**

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын дарга

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ /2020.12.18/

### Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааг Монгол Улсын гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж, гамшигт ялангуяа хүний гоц халдварт өвчний цар тахлаас хүн амыг хамгаалах, нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа хохирлыг бууруулахад чиглүүлэх зорилгоор тус зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ЗӨВЛӨМЖ болгох нь:

#### Нэг. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн гишүүдэд:

1.1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үргэлжлэх хугацаа тодорхойгүй, цаашид даамжирч болзошгүй нөхцөл байдал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, түүнтэй тэмцэх бэлэн байдлыг хангах чиглэлээр:

1.1.1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хүн ам, нийгэм-эдийн засагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах, хохирол багатай даван туулахад Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комиссын холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

1.1.2.Бүх шатны төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд коронавируст халдварын цар тахлын үед эрсдэлийг бууруулах менежментийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, эдийн засаг, бизнесийн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн эрх ашиг, эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.1.3.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын Монгол Улс дахь нөхцөл байдал, хариу арга хэмжээний явцын 2020 оны тайлан, мэдээг боловсруулж, мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх.

1.2.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, хүний гоц халдварт өвчний үед шуурхай хариу арга хэмжээ авах салбар дундын харилцан ажиллагаа, чадавх, нөөц, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудад гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны мэргэжилтнийг батлагдсан төсөв, орон тоонд багтаан нэн яаралтай томилон ажиллуулах;

1.3.Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх Байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах.

#### Хоёр. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд:

2.1.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын санал боловсруулах (Онцгой байдлын ерөнхий газартай хамтрах).

**Гурав. Барилга, хот байгуулалтын яаманд:**

3.1.Объектын гал түймэрт тэсвэртэй барилга байгууламж, стандарт нормыг баримтлах хяналтыг эрчимжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах, олон нийтийн барилга байгууламжийн норм, дүрмийн дагуу хот суурин газарт объектын гал түймрийн үед ашиглагдах усны цэгийн байршлыг нэмэгдүүлэх, тэмдэгжүүлэх;

3.2.Нийслэл болон үерийн эрсдэл өндөр аймгуудад үерт тэсвэртэй барилга байгууламж, авто болон төмөр замын дэд бүтцийг хөгжүүлэх, ус зайлуулах далан, суваг, шуудууг шинэчлэх, шинээр байгуулах ажлыг төлөвлөн үе шаттай хэрэгжүүлэх (аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтрах);

3.3.Баруун, зүүн, төвийн бүсийн тулгуур төв хотууд, Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, шинэ, хаяа дагуул хот болон бүх хот суурин газрын хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг боловсруулахад гамшгийн эрсдэлийн үнэлгээнд суурилах, олон улсад хэрэгжсэн судалгаатай, үр дүнтэй арга хэмжээг жишээ болгож, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгах (аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтрах).

**Дөрөв. Гадаад харилцааны яаманд:**

4.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын болон бүс нутгийн платформуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, сургалт, судалгаа, техникийн туслалцаа авах зэргээр үндэсний зөвлөлийн чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.2.Үндэсний зөвлөлийг бүс нутаг, дэлхий дахинаа гамшгийн эрсдэлийг бууруулах, түүний эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг тооцоолох чиглэлээр баримталж буй бодлого, чиглэл, цаг үеийн мэдээ, гадаад улсын ижил төстэй байгууллагын туршлагын талаарх мэдээллээр хангах.

**Тав. Зам, тээврийн хөгжлийн яаманд:**

5.1.Гамшгийн үед ашиглагдах туслах замуудын зураглалыг тогтмол байнга шинэчлэх, нэн шаардлагатай түргэн тусламж, гал, аврах ангийн автомашин саадгүй орж ажиллах нөхцөлийг бүрэн бүрдүүлэх. Үүнд: хаягжилт, зураглалыг тодорхой болгох, GPS-д мэдээллийг тогтмол шинэчлэх (аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтрах);

